ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: nh@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.07.08 № 1194

танай ______-ны № ______-т

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
СҮХБААТАР ДҮҮРГИЙН
АРДЧИЛСАН НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Сүхбаатар дүүргийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Сүхбаатар дүүргийн Ардчилсан намын Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3

002020947

дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сүхбаатар дүүргийн ардчилсан намын мөрийн хөтөлбөр /9 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сүхбаатар дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт: 9 хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР

АРДЧИЛСАН НАМ

# СҮХБААТАР ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Улаанбаатар хот 2020 он

АРДЧИЛСАН НАМ
СҮХБААТАР ДҮҮРГИЙН ХОРОО

# НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

## ХӨГЖИЛД ХӨТЛӨХ СҮХБААТАР ДҮҮРЭГ

1. НЭЭЛТТЭЙ, ХАРИУЦЛАГАТАЙ СҮХБААТАР ДҮҮРЭГ
2. БОЛОВСРОЛООР ТЭРГҮҮЛЭХ СҮХБААТАР ДҮҮРЭГ
3. ЭРҮҮЛ МЭНДИЙГ ИРГЭН БҮРД СҮХБААТАР ДҮҮРЭГ
4. ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРД СҮХБААТАР ДҮҮРЭГ
5. АМЬДРАХАД ТААТАЙ СҮХБААТАР ДҮҮРЭГ

## НЭГ. НЭЭЛТТЭЙ, ХАРИУЦЛАГАТАЙ СҮХБААТАР ДҮҮРЭГ

**1.1 Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, цахим, ил тод хүртээмжтэй хүргэнэ.**

1.1.1. Шилэн дансны хуулийн дагуу дүүргийн төсөв санхүү, төрийн үйл ажиллагаатай холбоотой гарсан шийдвэрүүдийг иргэдэд цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан мэдээлж, тайлагнаж ажиллана.

1.1.2. Иргэдэд төрийн үйлчилгээг хөдөлгөөнт оффисоор үргэлжлүүлэн үзүүлнэ.

1.1.3. Дүүрэг, хороодын иргэний танхимын үйл ажиллагааг идэвхжүүлэх, төр засгийн тогтоол шийдвэрийг тогтмол мэдээлж, иргэн төвтэй болгоно. Иргэний танхимын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай хэрэглэгдэхүүн, тоног төхөөремжөөр хангаж ажиллана.

1.1.4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааны сонгон шалгаруулалтыг хуульд зааснаар ил тод мэдээлнэ .

1.1.5. Дүүргийн удирдлага жилд 2-оос доошгүй удаа үйл ажиллагааны тайлангаа олон нийтэд нээлттэй тайлагнана.

1.1.6. Төрийн зарим чиг үүргийг хороодод шилжүүлж, төрийн үйлчилгээг иргэнд ойртуулна.

1.1.7. Төрийн үйлчилгээнд иргэдээс шаарддаг бичиг баримтыг цөөрүүлж. Төрд байгаа мэдээллийн санд үндэслэн иргэндээ үйлчилнэ.

1.1.8. Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ажлын гүйцэтгэлийг үнэлэх урамшууллын тогтолцоог боловсронгуй болгож хэрэгжүүлнэ.

1.1.9. Иргэдийн өргөдөл, гомдол мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх явцыг цахим бүртгэлд оруулж, цаг алдалгүй судлан үзэж түргэн шуурхай шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлж ажиллана.

1.1.10. Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэх тогтолцоог сайжруулна.

**1.2 Иргэдийн санаачилгыг дэмжин хамтран бүтээнэ.**

1.2.1 Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудыг иргэдийн санал асуулга явуулж, тэдний саналд үндэслэн шийдвэр гаргадаг тогтолцоог тогтмолжуулна.

1.2.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний ажлын саналыг иргэдээс нээлттэй болон цахимаар авч, иргэдийн бүлэг, олон нийтийн оролцоотойгоор гүйцэтгэж, төлөвлөлт, биелэлт, хяналт зарцуулалтыг нээлттэй ил тод болгоно.

1.2.3 Дүүрэг, хороодын иргэний танхимаар дамжуулан иргэний оролцоотойгоор нийтийн сонсголыг тогтмол зохион байгуулна.

## ХОЁР. БОЛОВСРОЛООР ТЭРГҮҮЛЭХ СҮХБААТАР ДҮҮРЭГ

**2.1. Сургалтын чанарыг сайжруулж, сургууль цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.**

2.1.1. Багш, удирдах ажилтны нэр хүнд, мэргэжлийн ёс зүй, ур чадвар, арга зүй, мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилго бүхий сургалт, арга зүйн бодлогын зөвлөлийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.

2.1.2. Сургуулийн өмнөх боловсрол, бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын чанарт тавих хяналтыг сайжруулна.



СҮХБААТАР ДҮҮРГИЙН ХОРОО

2.1.3. Төрийн өмчит цэцэрлэг, сургуулийн барилгыг мэргэжлийн хяналтын дүгнэлтэд үндэслэн дахин төлөвлөх, өргөтгөх болон шинээр барих ажлыг улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлнэ.
2.1.4. Сургууль, цэцэрлэгийн засвар, тохижилтын хөрөнгө оруулалтыг эрэмбэлэх цахим мэдээллийн сан бүрдүүлнэ.
2.1.5. Сургалтын орчинг сайжруулах чиглэлээр олон улсын хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
2.1.6. Найрсаг харилцаа, хамтын ажиллагаатай гадаад, дотоодын хот дүүргүүдтэй "БАГШ, СУРАГЧ СОЛИЛЦООНЫ ХӨТӨЛБӨР"-ийг нэмэгдүүлнэ.
2.1.7. "Насан туршийн боловсролын төв"-өөр олгох сургалтын чанар, хүртээмжийг сайжруулж, сургуульд суралцах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд сургалтыг цахим хэлбэрээр явуулах үйл ажиллагааг дэмжин, шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана.
2.1.8. Сургуулийн өмнөх насны боловсрол олгох хүүхэд хамрагдалтыг одоогийн байгаа 85,1 хувийг 100 хүртэлх хувьд хүргэн хамруулна.

**2.2. Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.**

2.2.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн бүсэд аюулгүй байдлыг бүрэн хангахад чиглэгдсэн арга хэмжээ, туршлагыг нэвтрүүлж, хүүхдийн аюулгүй орчин бий болгох "ГЭРТЭЭ ХАРИХ ЗАМ ГЭРЭЛТЭЙ" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
2.2.2. Хүүхэд, залуучуудын номын сангийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
2.2.3. Эко сургууль, ногоон цэцэрлэг байгуулах аяныг хэрэгжүүлж, бодлогыг дэмжинэ.
2.2.4. Сургууль, цэцэрлэгийн орчинд шаардлагатай гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлнэ.
2.2.5. Төрийн өмчийн сургууль болон алслагдсан сургуулиудад автобус ажиллуулж, хүүхдийг сургуульдаа аюулгүй ирж, очих нөхцөлийг бүрдүүлнэ.
2.2.6. Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах талаарх мэдлэгийг сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сурталчлан таниулах ажлыг эхлүүлж хэрэгжүүлнэ.

**2.3. Хүүхэд, эцэг эх, багшийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.**

2.3.1. "Мэргэжил сонголтын зөвлөх үйлчилгээний төв" байгуулж, сурагчдыг
2.3.2. ажил, мэргэжлээ зөв сонгоход зөвлөн туслах үйлчилгээг нэвтрүүлнэ.
2.3.3. Хүүхдэд зөвлөгөө өгөх "СЭТГЭЛ ЗҮЙН КАБИНЕТ"-ийг нээх ажлыг эхлүүлнэ.
2.3.4. Хүүхэд, эцэг эх, багшийн цахим хамтын ажиллагааг хөгжүүлнэ.
2.3.5. Эцэг эх, багшийн хамтын ажиллагааны хүрээнд хүүхэд, залуust гэр бүл, амьдралын зөв дадал, сайн зан чанар, эх оронч үзлийг төлөвшүүлэх боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
2.3.6. Төрөөс соёлын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, хүүхэд,
2.3.7. залуучууд, иргэдийн авьяас, чадварыг нээн хөгжүүлэх урлагийн их
2.3.8. наадам, чуулган, мэтгэлцээн, конференци зэрэг олон нийтийн арга
2.3.9. хэмжээг дэмжин ажиллана.
2.3.10. Эх орныхоо түүхэн дурсгалт газрууд, соёлын өвтэй танилцах, их түүхийнхээ мэдлэг олгох хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1117145683
ХАА0612 4077278

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ХОРОО

**2.4. Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжинэ.**

2.4.1. Залуучуудыг хотын соёлд суралцуулах, сөрөг зан үйл хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулна.

2.4.2. Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.

2.4.3. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж бүх төрлийн цахим мэдээллийн халдлагаас урьдчилан сэргийлэх ажлыг өрнүүлнэ.

2.4.4. Хүүхэд залуучуудын бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор биеийн тамир, спортын тэмцээн уралдааныг тогтмолжуулж, спорт заал, гадаа талбайг нэмэгдүүлнэ.

## ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙГ ИРГЭН БҮРД СҮХБААТАР ДҮҮРЭГ

**3.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж "ИРГЭН ТӨВТ" үйлчилгээг нэвтрүүлнэ.**

3.1.1. Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлгийг Улс, нийслэл, дүүргийн болон бусад хөрөнгийн эх үүсвэрээр шинээр барьж, орны тоог нэмэгдүүлэн, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.1.2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, оношилгоо, шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, нэн шаардлагатай мэргэшлээр эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургалтад хамруулж чадавхжуулна.

3.1.3. Иргэн бүрийг нас, хүйсийн бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулж "ИРГЭН ТӨВТ" эрүүл мэндийн үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгоно.

3.1.4. Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, эрүүл мэндийн технологийн үнэлгээнд үндэслэн шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр өрхийн эрүүл мэндийн төвийг хангах, барилгыг шинэчлэх ажлыг эрүүл мэндийн яам, нийслэлийн эрүүл мэндийн газартай хамтран шийдвэрлэнэ.

3.1.5. Дүүргийн эрүүл мэндийн төвийг эрүүл мэндийн салбарт шинээр нэвтэрсэн оношилгоо, шинжилгээ, эмчилгээний техник технологи, шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангана.

3.1.6. Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй 3 талт гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцон ажиллана.

3.1.7. Эрүүл мэндийн төвийг түшиглэн идэвхтэй дасгал хөдөлгөөн, иог, бясалгал, чийрэгжүүлэлт, эрүүл зөв хооллолтыг дэмжих, сурталчлах төвийг нээж иргэдийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлнэ.

**3.2. Иргэн бүрийн эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ.**

3.2.1. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлж 18-аас дээш насны иргэдийг чихрийн шижин, цусны даралт ихсэх, хорт хавдар зэрэг зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт жилд 1 удаа хамруулж, эрүүлжүүлнэ.

3.2.2. Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах, амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.

3.2.3. Сүрьеэгийн идэвхтэй эрт илрүүлгийг явуулын хэлбэрт шилжүүлж, эмчилгээний үр дүнг нэмэгдүүлнэ.

3.2.4. Сургуулийн ахлах ангийн сурагчид, 18-аас дээш насны хүүхэд залуучуудыг БЗДХ, ХДХВ, 45-аас дээш насны иргэдийг Хепатитийн В, С вирус зэрэг халдварт өвчний эрт илрүүлэг үзлэгт жил бүр хамруулж,

"ЭРҮҮЛ ГЭР БҮЛ-ЭРҮҮЛ ХҮҮХЭД ОЮУТАН, ЗАЛУУЧУУД" хөдөлгөөн өрнүүлнэ.

3.2.5. Халдварт өвчин, амьсгалын замаар дамжих халдварт өвчний дархлаажуулалтын хамралтыг сайжруулж, өвчлөлийг бууруулна.

3.2.6. Цочмог халдварт өвчин, шинэ сэргэж буй халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакциныг хүн бүрд хүртээмжтэй болгож халдварт өвчний тархалтыг бууруулахад дэмжлэг үзүүлнэ.

**3.3. Зорилтод бүлгийн иргэдэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжин ажиллана.**

3.3.1. Ажил эрхлэдэггүй, дунджаас доогуур орлоготой иргэдийг даатгалд хамруулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх хөдөлгөөн өрнүүлж "Хэнийг ч орхигдуулахгүй байх" зарчмыг хэрэгжүүлнэ.

3.3.2. Ахмад настан, эмзэг бүлгийн иргэдийн суурь судалгааг нарийвчлан гаргаж, өрхийн хөгжлийг дэмжин, хөтөлбөр, арга хэмжээнд хамруулна.

3.3.3. Сүхбаатар сувиллын газрыг "Харвалтын дараах сэргээн засах төв" болгон өргөжүүлнэ.

3.3.4. Сүхбаатар сувиллын газарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч сувилах тасаг нээж ажиллуулна.

3.3.5. Ахмад настныг эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах, тэдний насны онцлогт тохирсон нийгмийн идэвхтэй амьдралд татан оролцуулах Ахмад настанд зөвлөгөө өгөх кабинетыг ажиллуулна.

3.3.6. Ахмад настанд гэрээр тусламж үйлчилгээ үзүүлэх иргэд, залуучуудын сайн дурын санаачилга, хөдөлгөөнийг дэмжин "Хариу нэхээгүй тус" аян зохион байгуулна.

## ДӨРӨВ. ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРД СҮХБААТАР ДҮҮРЭГ

**4.1. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, дэмжин ажиллана.**

4.1.1. Орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэгч татвар төлөгч, ажил олгогчдын чуулга уулзалтыг жил бүр явуулна.

4.1.2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, судалгаанд тулгуурлан дүүргийн залуучуудыг мэргэжил эзэмшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулан иргэдэд ажлын байрны мэдээ, мэдээллийг шуурхай хүргэж ажиллана.

4.1.3. Хүүхэд харах үйлчилгээг хөгжүүлэх, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

4.1.4. Ажлын цагийн уян хатан зохицуулалт, зайнаас болон цахим орчинд хөдөлмөрлөх боломж бүхий ажлын байрыг дэмжиж ажиллана.

4.1.5. Аж ахуйч өрх хөтөлбөр хэрэгжүүлэн дэмжин ажиллана.

4.1.6. Нийгмийн хариуцлагын хүрээнд оюутан залуучуудад цагийн ажил олгож, цаг, өдрөөр ажиллах ажлын байр бий болгосон аж ахуйн нэгжүүдийг дэмжиж ажиллана.

4.1.7. Ахмад настнуудын санаачилгыг дэмжин хөршийн холбоо, иргэдийн бүлэг, эко эргүүлийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн ажлын байрыг нэмэгдүүлнэ.

4.1.8. "Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг нь хангах хөтөлбөр" боловсруулж хэрэгжүүлнэ.

4.1.9. Батлан хамгаалах төрийн үйлчилгээг иргэдэд хүргэнэ.

- 4.1.10. Иргэдийн хөдөлмөр эрхлэх, бизнесээ эхлүүлэхэд нь туслах сургалтуудыг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжиж ажиллана.
- 4.1.11. Мэргэжил олгох, давтан сургалтад зорилтот бүлгийн иргэдийг хамруулна.
- 4.1.12. Гэр бүлийн гишүүн бүрд гэр бүлийн боловсрол олгох, ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ хөгжүүлэх, амьдрах орчноо хамтдаа сайжруулах, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

**4.2. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.**

- 4.2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр батлагдсан хөтөлбөр, арга хэмжээний дагуу хувиараа хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгж, үүний дотор Старт ап бизнес компаниуд, инновацын төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагуудыг бүх талаар дэмжин ажиллана.
- 4.2.2. Дүүргийн Жижиг үйлдвэрлэлийг технологийн шийдлээр дэмжихэд анхаарч, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид болон орхийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн борлуулах борлуулалтыг дэмжиж улирлын чанартай худалдааг зохион байгуулна.
- 4.2.3. Зорилтот бүлгийн иргэн, нөхөрлөл, хоршоодыг бизнес инкубацын арга хэмжээнд хамруулна.
- 4.2.4. Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн дэргэдэх мэдээллийн төвд тулгуурлан жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан сургалт, судалгааг тогтмол зохион байгуулна.
- 4.2.5. Иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРД аян өрнүүлж тасалгааны болон хүлэмжийн бичил орчинг бүрдүүлэх сургалт арга зүйг иргэн, аж ахуй нэгж байгууллагад хүргэж ажиллана.
- 4.2.6. Тогтвортой үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж, хамтран ажиллах, гадаад болон дотоодын зах зээлд таниулах, үзэсгэлэн худалдаанд хамруулна.
- 4.2.7. Бүх нийтийн хүнсний боловсролыг дээшлүүлэх, хоол хүнс, шим тэжээлийн чанар, аюулгүй байдлыг эрүүл амьдралын зан үйл хэвшилтэй нягт уялдуулах чиглэлээр үндэсний хөтөлбөрийг дэмжиж ажиллана.

**4.3. Дүүргийн гадаад харилцааг өргөжүүлнэ.**

- 4.3.1. Гадаад харилцааг өргөжүүлэн уламжлалт харилцаатай улс орны хот, дүүрэгтэй хамтран ажиллах хамтын ажиллагааг бэхжүүлж, шинээр улс орны хот, дүүргүүдтэй харилцаа тогтооно.
- 4.3.2. Харилцаат хот, дүүргүүд рүү албан хаагчдыг албан айлчлал, сургалт, хурал, үзэсгэлэн, туршлага судлах аялалд хамруулж мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.
- 4.3.3. Найрсаг харилцаа, хамтын ажиллагаатай гадаад, дотоодын хот дүүргүүдтэй эмч, сувилагч, багш, сурагч солилцооны хөтөлбөрийг нэмэгдүүлнэ.
- 4.3.4. Дүүрэгт хэрэгжүүлж болох үр ашигтай гадаадын төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллана.

## ТАВ. АМЬДРАХАД ТААТАЙ СҮХБААТАР ДҮҮРЭГ

### 5.1. Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

5.1.1. Төрийн үйлчилгээг иргэдэд нэг цэгээр үзүүлэх хороо, ӨЭМТ, цагдаагийн хэсгийн цогцолбор байрыг шинээр барина.

5.1.2. Сэлбэ цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг үргэлжлүүлэн иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.

5.1.3. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулж, камержуулах хяналтын цогц шийдлийг нэмэгдүүлнэ.

5.1.4. Орон сууцны хороолол доторх авто зам, гэр хорооллын гудамж талбайд сайжруулсан шороон замыг хатуу хучилттай болгож тоосжилтыг бууруулна.

5.1.5. Иргэдийн саналын дагуу нийтийн эзэмшлийн талбай дахь авто зогсоол, ногоон байгууламж, сул шороон хучилт, явган хүний зам, гүүр, шат, худаг усан сангийн хэмжээг нэмэгдүүлнэ.

5.1.6. Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажлын чанар, үр ашгийг нэмэгдүүлж, арчлалт, хамгаалалтыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж ажиллана.

5.1.7. Орон сууцны байрнуудын дулааны алдагдлыг бууруулах зорилгоор дээврийн болон фасад засварлах, дулаалах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

5.1.8. Сууц өмчлөгчдийн холбоодын хариуцлагыг өндөржүүлж, үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

5.1.9. Гэр хорооллын гудамж, замыг тохижуулах ажлыг тухайн хорооны иргэдийн саналыг авч иргэдийн оролцоотой "ЖИШИГ ГУДАМЖ-МАНАЙ ГУДАМЖ" төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.1.10. Дүүргийн нутаг дэвсгэрт үерийн хамгаалалтын барилга, байгууламжийг сэргээх, шинээр барих ажлыг улс, нийслэлийн төсөвтэй уялдуулан үе шаттайгаар зохион байгуулна.

5.1.11. Тохижилт бүтээн байгуулалт хийх ажлын байршлуудыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж батлуулна.

5.1.12. Ногоон байгууламж шинээр бий болгосон иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжиж тэдгээрийг арчлан хамгаалах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

5.1.13. Иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх бүхий ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн нэмж байгуулна.

### 5.2. Иргэдийн аюулгүй байдлыг хангаж, хэв журмыг сахиулна.

5.2.1. Байгалийн гамшиг, аюулт үзэгдэл гэнэтийн гамшиг ослоос хамгаалах ажилд иргэд аж ахуй нэгж байгууллагыг татан оролцуулж анхан шатны мэдлэг сургалтыг зохион байгуулна.

5.2.2. "Олон нийтийн цагдаа", "Оюутан цагдаа" "Хөршийн холбоо" "Иргэдийн бүлгийн ажлыг" үргэлжлүүлэн сайжруулна.

5.2.3. Гэр бүлийн хүчирхийлэл, Өрх толгойлсон эх /эцэг/ зорилтот бүлгийн хүүхдийг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх ажлыг хорооны Ажлын алба, нийгмийн ажилтны хамтарсан багийг байгуулах ажлыг эрчимжүүлнэ.

5.2.4. Агаар, орчны бохирдол, үнс, хог хаягдлыг бууруулах чиглэлээр менежментийн төслийг боловсруулж иргэд аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

5.2.5. Дүүргийн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын техник тоног төхөөрөмжүүдийг нэмэгдүүлж, хүчин чадлыг нь сайжруулна.

5.2.6. Улаанбаатар хотын хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор "ЖОРЛОНГОО ӨӨРЧИЛЬЕ" хөтөлбөрийг дүүрэгтээ иргэдийн оролцоотой хэрэгжүүлнэ.

5.2.7. Гамшиг аюулаас хамгаалах үйл ажиллагааг мэргэжлийн байгууллага, иргэдийн оролцоотой хэрэгжүүлнэ.

**5.3. Иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газар, соёл, урлагийн байгууламжуудыг бий болгоно.**

5.3.1. Дүүргийн иргэд, ахмад настнуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх соёл урлагийг дэмжих, харах хяналтгүй болсон ахмадыг хамгаалах "Ахмадын асрамжийн төв"-ийг барьж байгуулна.

5.3.2. Дүүргийн иргэдийн бие бялдрыг хөгжүүлэх зөв соёлыг хэвшүүлэх зорилгоор "Спорт цогцолбор"-ыг нээнэ.

5.3.3. Хүүхэд, залуус, ахмад настнуудад зориулсан хүүхдийн тоглоом, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн төрөлжсөн талбайг шинээр байгуулах болон шинэчилж, тохижуулна.

5.3.4. Иргэд болон зорилтод бүлгүүдийн дунд /Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд/ нийтийн биеийн тамирын үйлчилгээг өргөжүүлж, бүх ард түмний, Хүүхдийн, Үндэсний, Оюутны спортын наадмуудыг зохион байгуулж, Их наадмуудад дүүргийн баг тамирчдыг оролцуулна.

5.3.5. Олимпын олон төрлөөр өсвөр, залуучууд, насанд хүрэгчдийн спортын үндэсний болон олон улсын хэмжээний томоохон арга хэмжээ, фестиваль, уралдаан тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

5.3.6. Иргэдэд амьдралын зөв дадал хэвшил олгох, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, зохистой хооллолт-идэвхтэй хөдөлгөөн аян, бие бялдрын чийрэгжилтийн түвшин тогтоох сорил хөтөлбөрийг жил бүр өрнүүлж, хүн амын бие бялдрын боловсролын түвшинг дээшлүүлнэ.

**5.4. Газар зохион байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.**

5.4.1. "Зуслан" ерөнхий төлөвлөгөөний дагуу дүүргийн хороодын зуслангийн газар өмчлөх ажлыг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулан нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын албатай хамтран ажиллана.

5.4.2. Газар зохион байгуулалт, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэхэд шаардлагатай материал, судалгаагаар хангаж ажиллана.

5.4.3. Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг гэр хорооллын болон орон сууцны дахин төлөвлөлттэй уялдуулан нийтийн болон, амины орон сууцыг шинээр бий болгох хөтөлбөрийг дэмжин холбогдох байгууллага аж ахуй нэгж иргэдтэй хамтран ажиллана.

5.4.4. Улс нийслэлээс хийгдэж байгаа инженерийн дэд бүтцэд хамруулах ажилд гадны төсөл хөрөнгө оруулалтыг гэр хорооллын төвийн, дундын, захын, бусийн айл эрхийг төвийн болон хэсэгчилсэн, бие даасан дэд бүтцэд холбоно.

--o0o--



АРДЧИЛСАН НАМ
СҮХБААТАР ДҮҮРГИЙН ХОРОО

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 6 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.07.03 № 1191

танай ___________ ны № ___________ т

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
АРДЧИЛСАН НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Сонгинохайрхан дүүргийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа-2050”, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Сонгинохайрхан дүүргийн Ардчилсан намын Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн

37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сонгинохайрхан дүүргийн ардчилсан намын мөрийн хөтөлбөр /10/ хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сонгинохайрхан дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт: 10 хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМ

# ХҮНД ЭЭЛТЭЙ ОРЧИН

## СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР 2020

## АГУУЛГА


1. УХААЛАГ ЗАСАГЛАЛТАЙ ДҮҮРЭГ
2. АЖИЛ ОРЛОГОТОЙ ДҮҮРЭГ
3. ЗӨВ ТӨЛӨВЛӨЛТТЭЙ ДҮҮРЭГ
4. ЭКО ДҮҮРЭГ
5. ЭЭЛТЭЙ ДҮҮРЭГ

Ардчилсан нам нийслэлийг удирдсан 2012-2016 жилүүдэд төр засаг нь иргэдээ сонсдог, иргэнд тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэдэг, Нийслэлийн төр захиргааны үйлчилгээг иргэндээ ойртуулж, Гэр хорооллын дахин төлөвлөлт, Нийтийн тээврийн салбарын цогц шинэчлэл, төрийн үйлчилгээний нэг цэгийн үйлчилгээ зэрэг томоохон өөрчлөлт шинэчлэлийг та бүхэнтэй хамтран эхлүүлсэн билээ.

Бид энэ удаа нийслэлийн ардчилсан намын мөрийн хөтөлбөртэй уялдуулан иргэдийн төлөө дүүргийн захиргааг хариуцлагатай, иргэдээ чирэгдүүлдэггүй болгох, иргэдээ ажилтай орлоготой, агаар, хөрс, тоосжилт, орчны бохирдлыг цогцоор нь шийдвэрлэх, гэр хорооллын дахин төлөвлөлт зэрэг томоохон өөрчлөлтийн төслүүдийг санал болгож байна.

### Хүүхэд багачуудад

Бид хүүхдэд ээлтэй хотын стандартыг мөрдүүлж "нэгдүгээрт хүүхэд" зарчмаар ажиллана. Хамран сурах тойрог буюу хүүхэд багачууд алхаад очих зайд цэцэрлэг, бага сургууль байгуулах ажлыг дахин үргэлжлүүлнэ. Хүүхдүүдийн боловсролын чанарт онцгой анхаарсан тусгай бодлого гарган ажиллана. Хүүхдийг бүтээлч, шинийг санаачлагч болгож төлөвшүүлэх зорилгоор технологийн лаборатори, зохион бүтээгчдийн төв, хүүхэд хөгжлийн ордон байгуулж хүүхэд бүрийн авьяас чадварыг хөгжүүлэхэд онцгой анхаарна.

### Залуучуудад

Бид залуучуудаа дэмжиж, сурч боловсрох, хөгжин дэвших орчин нөхцөлийг бүрдүүлнэ. Залуус чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, нийтийн биеийн тамираар хичээллэх, спортын болон соёл урлагийн байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлнэ.

### Ахмад настнуудад

Ахмадууд ажил амьдралын арвин туршлагаа хуваалцах, орлогоо нэмэгдүүлэх, ажил хөдөлмөр хийх боломжийг бий болгоно. Бид "Ахмадын орон сууц" хөтөлбөрөө үргэлжлүүлж "Ахмадын ажлын байр" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Ахмадын асрамж сувиллын жишиг төв барина.

### Хөгжлийн бэрхшээлтэй (тусгай хэрэгцээт) иргэдэд

Тусгай хэрэгцээт иргэд рүү чиглэсэн дэд бүтэц, нийгмийн амьдралд идэвхтэй оролцож ажиллаж амьдрах боломжийг бүрдүүлэхэд онцгой анхаарал хандуулна.

### Гэр бүлүүдэд

Бид өрх бүрийг тогтмол ажилтай орлоготой болгох, өрхийн бизнес эрхлэлтийг бүх талаар дэмжиж ажиллана. Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны түрээсийн бодлогыг дэмжиж хэрэгжүүлнэ. Дүүргийн эргэн тойронд иргэд амрах, чөлөөт цагаа тав тухтай өнгөрүүлэх бодлогыг баримтална. Гэр бүлтэй залууст төлбөрийн чадвартаа тохирсон орон сууцтай болох хувилбаруудыг дахин эхлүүлнэ.

### Бизнес эрхлэгчдэд

Бид аж ахуй эрхэлж байгаа хувь хүн, байгууллага, гарааны бизнес эрхэлж буй залуус, албан бус секторт ажиллаж байгаа иргэдийг орлогоо нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, шинэ технологи нэвтрүүлэхэд төрийн хүнд суртал, олон давхар хяналтыг зохистой түвшинд багасгаж үйл ажиллагааг нь бүх талаар дэмжинэ.

## 1. УХААЛАГ ЗАСАГЛАЛТАЙ ДҮҮРЭГ

**Өнөөгийн нөхцөл байдал:**

Улаанбаатар хот засаглалын хямралд орсон, дэлхийн хотуудтай харьцуулахад хамгийн үр ашиггүй засаглалтай байна. Хэт олон дарга, удирдах ажилтантай боловч ажлын уялдаагүй, санхүүгийн иж бүрэн нарийвчилсан тайлагнал тааруу, үйл ажиллагааны давхардал, хийдэл ихтэй, хариуцлага алдсан албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэдэггүй.

Иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээний санхүүжилт хэд дахин нэмэгдсэн ч иргэдэд хүрдэггүй, хугацаа тодорхой бус, албан тушаалтан хүнд суртал гаргаж иргэдийг чирэгдүүлдэг.

Иргэдээ сонсдоггүй, сонсон ч асуудлыг нь шийдвэрлэдэггүй, иргэдийн оролцооны эрх зүйн орчин тодорхойгүй, иргэдийн саналыг ямар асуудлаар, ямар цар хүрээнд авах талаар тогтсон дүрэмгүй. Бүх төрлийн үйлчилгээнд цахим технологийг ашигладаг болох, орчин үеийн шуурхай харилцаа, хүргэлтийн системийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

**Бидний хийх ажлууд:**

Ажлын чиг үүрэг нь тодорхой, цомхон, мэргэшсэн ажлаа мэддэг төрийн албан хаагчидтай захиргаатай болно. Хууль зөрчсөн, иргэдийг чирэгдүүлсэн албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэдэг болно. Иргэдэд үйлчлэх үйлчилгээнд орчин үеийн технологи нэвтрүүлэх, иргэдийн түгээмэл саналыг шийдвэр гаргалтанд тусгаж олон талын оролцоотой ажиллахыг зорино.

### 1.1 Дүүргийн удирдлагыг сайн засаглалтай, хариуцлагатай, шийдвэр гаргалтыг шуурхай, нээлттэй болгох чиглэлээр:

1.1.1 Төрийн үйл ажиллагааны давхардал, хийдлийг арилгаж, үр ашигтай, нээлттэй хариуцлагатай, бүтцэд шилжиж ажиллана.

1.1.2 Нийтийн албан тушаалтнуудын гаргасан шийдвэр, үйл ажиллагаанд үнэлгээ хийж, ил тод болгон, хариуцлага алдсан албан тушаалтанд хариуцлага тооцдог болно.

1.1.3 Дүүргийн удирдлагын шийдвэр гаргалтанд мэргэжлийн холбоод, судалгааны байгууллагууд, эрдэмтэн судлаачид, иргэдийн сонирхлын бүлгүүдийн оролцоог хангана.

1.1.4 Дүүргийн удирдлага болон төрийн бүхий л үйл ажиллагааг явуулдаг газрууд улирал тутам үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа олон нийтэд нээлттэй, ил тод тавьдаг болж цахим хуудсандаа тогтмол байршуулна.

### 1.2 Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүртээмжтэй болгох чиглэлээр:

1.2.1 Төрийн бүхий л үйлчилгээг иргэдэд ойртуулах, нэг цэгийн болгох, цахим хэлбэрээр өгөхөд чиглэж ажиллана.

1.2.2 Газар эзэмшил, ашиглалтын талаарх мэдээллийг нээлттэй, ойлгомжтой, цахим болгоход дэмжиж ажиллана.

1.2.3 Жишиг цогцолбор хорооны төвүүдийг шинээр барихад дэмжиж ажиллана. Ингэснээр дэлхийн бусад хотуудад байдаг коммунити центрийн загвараар иргэд төрийн үйлчилгээ, спорт заал, хурал уулзалтын танхим, хүүхдийн өдөр өнжүүлэх, төрөл бүрийн дугуйлан, эмнэлгийн үйлчилгээ бүхий цогцолбор үйлчилгээг авдаг болно.

1.2.4 Иргэдэд үйлчлэхдээ улс төрийн аль нэг нам, эвсэлд хамаарч байгаа эсэхээс үл хамааран төрийн үйлчилгээг чирэгдэлгүй ижил хүргэхэд онцгой анхаарч ажиллана.

**1.3 Иргэд, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр:**

1.3.1 Дүүрэг хөгжүүлэх, тохижуулах асуудлаар шийдвэр гаргахдаа иргэдийн түгээмэл саналд үндэслэдэг болно.
1.3.2 11-11 дуудлагын төвийг дахин ажиллуулна.

## 2. АЖИЛ ОРЛОГОТОЙ ДҮҮРЭГ

**Өнөөгийн нөхцөл байдал:**

Монгол Улсын аж ахуйн нэгжүүдийн 90% нь нийслэлд байрладаг ч Сонгинохайрхан дүүргийн хувьд аж ахуйн нэгж байгууллага цөөн, тэр хэмжээгээр ажлын байр, иргэдийн орлого тааруу байдаг.

**Бидний хийх ажлууд:**

Бид бизнес эрхлэхэд таатай, иргэд нь тогтмол ажилтай орлоготой дүүрэг болох эрхэм зорилго тавина.

**2.1 Бизнес эрхлэхэд таатай орчин бүрдүүлэх чиглэлээр:**

2.1.1 Зөвшөөрлөөс бүртгэл рүү гэсэн зарчим баримтлана. Олон шат дамжлага хүнд суртал бүхий зөвшөөрлын системийг халж бизнес эрхлэхийг хүссэн хүн бүхэн бүртгүүлээд үйл ажиллагаагаа явуулж эхлэх боломжтой байх орчныг дэмжиж ажиллана.
2.1.2 Алслагдсан хороодод аж ахуй эрхлэх байдлыг дэмжихийн зэрэгцээ ажлын байр бий болгож буй аж ахуйн нэгжүүдийг хуулийн хүрээнд дэмжиж ажиллана.
2.1.3 Дүүрэгтээ гадаадын жуулчдад зориулсан аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгож, аюулгүй байдлыг хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
2.1.4 Хувийн хэвшилтэй хамтран иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг танилцуулах үзэсгэлэн худалдааны Сонгинохайрханд үйлдвэрлэв төв байгуулахад дэмжиж ажиллана.

**2.2 Эдийн засгийг тэлэх, ажлын байр бий болгох чиглэлээр:**

2.2.1 Авто тээврийн худалдаа, үйлчилгээний төвийг хөгжүүлнэ.
2.2.2 "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байр" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
2.2.3 Хөнгөн үйлдвэрлэл, технологийн парктай болно.
2.2.4 Хог дахин боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг дэмжиж ажиллана.
2.2.5 Өрхийн санхүүг дэмжихийн тулд тэдэнд байгаа газар, хашаанд тулгуурлан хүлэмжийн аж ахуй эрхлэх, түүнийг худалдан борлуулах тогтолцоог дэмжиж ажиллана.
2.2.6 Дүүрэгтээ хөдөлмөр зуучлалын төв бий болгож, ажилгүй иргэдийг зуучилж, байршуулдаг тогтолцоог бий болгоно.
2.2.7 Залуусын гаражны бизнесийг бодитойгоор дэмжиж ажиллана.

## 3. ЗӨВ ТӨЛӨВЛӨЛТТЭЙ ДҮҮРЭГ

**Өнөөгийн нөхцөл байдал**

Дүүргийн төлөвлөлт тааруу, ил тод биш. Олон нийт төлөвлөлтийг мэддэггүй учир ухаалаг оролцоо, хяналтын тогтолцоо байдаггүй. Үүний үр дүнд хүүхдүүдийн тоглох талбай, настан буурлуудын наргих орон зай, ногоон байгууламж, дэд бүтэц муу байна.

Явган болон унадаг дугуйгаар аюулгүй зорчих дэд бүтэц баригдаагүй. Нийтийн тээвэр, такси үйлчилгээ зэргийг цогцоор хөгжүүлээгүйгээс болж авто хөдөлгөөний түгжрэл сүүлийн жилүүдэд эрс нэмэгдсэн.

**Бидний хийх ажлууд:**

Бид дүүргээ зөв төлөвлөж, түүнийг ил тод, нээлттэй болгож, иргэд, мэргэжлийн байгууллагуудын оролцоог хангахад дэмжиж ажиллана. Нэн тэргүүнд хүүхдүүд, ахмадууд, тусгай хэрэгцээт хүмүүст ээлтэйгээр хэрэгжүүлэхийг зорьж явган алхах болон дугуйн замуудтай, амарч зугаалах таатай орчинтой дүүргийг байгуулна.

**3.1 Төлөвлөлт, хөгжлийн чиглэлээр:**

3.1.1 Төлөвлөлтийг ил тод, нээлттэй болгож, олон нийтэд шилэн болгох.
3.1.2 Барилгажилтыг дэмжихгүй нийтийн эзэмшлийн байршлуудыг шинэчлэн тодорхойлж, уг байршилд шинээр байшин барилга бариулахгүй байх шийдвэр гаргаж, иргэдэд танилцуулна.
3.1.3 Гэр хорооллын иргэдэд төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны хангамжид холбогдсон амины орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлнэ.
3.1.4 Нийтийн бие засах газрыг байгальд ээлтэй болгож хүрэлцээг эрс нэмэгдүүлнэ.
3.1.5 Сэргээгдэх эрчим хүч, байгаль орчинд ээлтэй дэд бүтцийн шийдлүүдийг дэмжинэ
3.1.6 Замын дагалдах дэд бүтэц болох ус зайлуулах шугам, гэрэлтүүлэг, ногоон байгууламжийг олон улсын стандартаар барина.
3.1.7 Дүүрэгт авто зогсоолын тоог төрөлжүүлж, нэмэгдүүлж, автозамын өргөтгөл, шинэчлэлийн ажлыг тогтмол хийнэ.
3.1.8 Осол аваар гардаг замуудад хяналтын камер, хурд хэмжигч, хурд сааруулагч байршуулна.
3.1.9 Гудамжуудыг иргэд, аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулалт хийж, тохижуулж, өөрсдийн нэрээр нэрлүүлэх боломжтой болгоно.
3.1.10 Гэр хорооллын цахилгаан хүчдэлийн уналттай өрхүүд, огт цахилгаанд холбогдоогүй айл өрхүүдийг тогтвортой цахилгаан хангамжтай болгоно.
3.1.11 Баянхошуу, Толгойт бүсүүдэд стандарт шаардлагад нийцсэн хүнсний болон барааны худалдаа үйлчилгээний цогцолбор төв байгуулах

**3.2 Гэр хорооллыг дахин төлөвлөх, орон сууцны орчныг сайжруулах чиглэлээр:**

3.2.1 Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үргэлжлүүлж, орон сууцжуулах олон хувилбарт бодлого хэрэгжүүлнэ.
3.2.2 Гэр хорооллын дахин төлөвлөлтөөс чөлөөлөгдсөн газар дээр иргэдийн амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх, эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлэх цэцэрлэгт хүрээлэнгүүдийг байгуулна.
3.2.3 Цэвэр усны түгээлт, ариутгах татуургын хүртээмжийг тогтвортойгоор шинэчлэн сайжруулж ухаалаг хүртээмжтэй болгоно.
3.2.4 Ашиглалтын шаардлага хангахгүй болсон орон сууцнуудын дахин төлөвлөлтийн төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
3.2.5 Гэр хорооллыг инженерийн дэд бүтэц /цэвэр ус, бохир ус ариутгах татуурга, интернэт шилэн кабель/-д холбож, халаалтыг төвлөрсөн болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй, дулаан алдагдал багатай амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг дэмжих зорилгоор иргэдийн амьдран суух байшингаа барихад нь дэмжлэг үзүүлж ажиллана.

3.2.6 Иргэд өөрийн өмчилж авсан хашааны газар дээр айл, хөрш, гудамжаараа нэгдэн төлөвлөлт хийж, инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон, амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлнэ.
3.2.7 Орлогод нь нийцсэн төлбөр бүхий "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг дэмжиж нэн тэргүүнд залуу гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудыг дэмжих бодлого баримтлана.
3.2.8 Гэр хорооллын яндан цөөрүүлэх, утаа угаарыг багасгах бодлогыг дэмжин хувийн хэвшилтэй хамтран ажиллаж шинэ дэвшилтэт технологи, инновацийн шинэ санааг дэмжинэ.
3.2.9 Гэр хорооллыг өвлийн цагт цахилгаанаар халаах чадвартай болгох үүднээс цахилгаан дамжуулах чадамжийг нэмэгдүүлж эрсдэлгүй аюулгүй дэд бүтцээр хангана.

### 3.3 Хот доторх хөдөлгөөнийг сайжруулах чиглэлээр:

3.3.1 "Бүхний түрүүнд явган зорчигч" зарчмыг хэрэгжүүлж иргэд явган алхах боломжийг бүрдүүлэх зорилгоор авто зам бүхий газар бүр явган хүний зам төлөвлөж ажиллана.
3.3.2 Иргэдийн чөлөөтэй зорчих эрхийг хязгаарласан, хотын өнгө үзэмжид сөргөөр нөлөөлсөн хашаа, хаалтуудыг буулгах, чөлөөлөх шийдвэртэй арга хэмжээнүүдийг авна.
3.3.3 "Унадаг Дугуйтай Улаанбаатар" хөтөлбөрийг дэмжиж ажиллана.
3.3.4 Нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулж, төлөвлөлтийг бүсчлэлд тулгуурлан цагийн хуваарийн дагуу явуулдаг болгоно.
3.3.5 Тэргэнцэртэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийтийн тээврээр саадгүй зорчих стандартыг тогтоож, хэвшүүлнэ.
3.3.6 5 шарын төмөр замтай уулзварын түгжрэлийг бууруулахын тулд цэргийн хотхоноос "хорин хоёр" явах замтай холбогдох шинэ уулзваруудыг нэмэгдүүлэх ажлыг хийнэ.

## 4. ЭКО ДҮҮРЭГ

### Өнөөгийн нөхцөл байдал

Улаанбаатар хот нэг сая хүрэхгүй модтой, ногоон байгууламж муутайгаас агаар, хөрс, орчны бохирдол, тоосжилт зэрэг олон сөрөг үр дагавар бий болж байдаг. Ялангуяа Сонгинохайрхан дүүргийн агаарын болон хөрсний бохирдол иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх түвшинд хүрээд байна.

Цэвэр ус, хог хаягдлын ачилт тээвэрлэлт хүрэлцээгүй, ангилан ялгалт хэвшээгүй, хог боловсруулах үйлдвэргүй, энэ чиглэлийн менежмент бүхэлдээ үгүйлэгдсээр байна.

### Бидний хийх ажлууд:

Бид дүүргээ хүрээлэн буй орчин, байгаль экологитойгоо нягт уялдаатай ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, ус, агаар, хөрсний бохирдлыг эрс бууруулж, нөөцийг хэмнэлттэй, ухаалаг зарцуулах тогтолцоонд шилжсэн тогтвортой хөгжилтэй дүүргийг байгуулна.

### 4.1 Хүрээлэн буй орчныг хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр:

4.1.1 Дүүргийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хөрсний чанарыг сайжруулах зорилгоор гэр хорооллын айл бүрт хашаандаа мод тарих, хүлэмжийн аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгоно.

4.1.2 Харшил үүсгэгч шарилж зэрэг нэр бүхий зэрлэг ургамлыг устгаж, иргэдийн эрүүл таатай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.
4.1.3 Улаанбаатар хотын салхин талд байрладаг Улаан чулуут хогийн цэгийг шилжүүлж түүний газрыг үндэсний цэцэрлэгт хүрээлэн болгох ажлыг дэмжиж ажиллана.
4.1.4 Нарангийн энгэрийн чимээгүй хотыг ногоон байгууламжаар хүрээлэн тохижуулна.

**4.2 Агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр:**

4.2.1 Гэр хорооллын янданг цөөрүүлэх зорилгоор орон сууцжуулах хөтөлбөрийг эрчимжүүлэн хэрэгжүүлж, ипотекийн зээлийн олголтыг гэр хорооллоос орон сууцанд орж буй зорилтот бүлэгт нэмэгдүүлнэ.
4.2.2 Нийслэлд агаарын бохирдлыг бууруулах зорилгоор "Өнтэй өвөлжье" төсөл хэрэгжүүлж, гэр хорооллын айлын дулаан алдагдлыг бууруулах, байгальд ээлтэй, дулаан алдагдал багатай сууцуудыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
4.2.3 "Жорлонгоо өөрчилье" төслийг дэмжин хэрэгжүүлж хөрсний бохирдлыг эрс бууруулна.
4.2.4 Агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд "Эрчим хүч үйлдвэрлэгч иргэн" хөдөлгөөнийг гэр хороололд өрнүүлж, иргэд хашаандаа нар салхины сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэн хэрэглэхээс гадна илүүдэл эрчим хүчээ төвийн эрчим хүчний сүлжээнд худалдан борлуулахыг дэмжинэ.
4.2.5 Хүрээлэн буй орчинд ээлтэй бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ.

**4.3 Нөөцийг тогтвортой ашиглах, хог хаягдлын менежентийг сайжруулах чиглэлээр:**

4.3.1 Усыг дахин ашиглах "Саарал ус"-ны технологийг нэвтрүүлнэ.
4.3.2 Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, хогийг ангилан хаях, нэгдсэн стандартад шилжүүлж, хог боловсруулах, буцаан ашиглах үйлдвэр байгуулнэ.
4.3.3 Аюултай хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, саармагжуулах, устгах тогтолцоог бий болгоно.
4.3.4 Орон сууцны хороолол дунд хог хаягдлыг ангилан байршуулах хэвшлийг нэмэгдүүлнэ. Иргэд дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж тушаасаар зарим үйлчилгээг (нийтийн тээвэр г.м) үнэ төлбөргүй авах хөшүүргийг нэвтрүүлнэ.
4.3.5 Хөрсний усны эрсдэлийг 90 хувь хүртэл бууруулна. Био цөөрөм, хөв цөөрөм байгуулах зэргээр олон улсын технологийг судлан эрдэмтэдтэй хамтран төсөл хэрэгжүүлнэ.
4.3.6 Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих, цахилгаан сүлжээн дэх нийлүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлнэ.
4.3.7 Эрчим хүчний хэмнэлтийг дэмжих, хэрэглээг зүй зохистой удирдах зорилгоор ухаалаг сүлжээг нэвтрүүлнэ

## 5. ЭЭЛТЭЙ ДҮҮРЭГ

**Өнөөгийн нөхцөл байдал**

Сүүлийн жилүүдэд гэмт хэргийн түвшин буурахгүй байгаагийн зэрэгцээ зам тээврийн осол, аваар их гарч байна. Хүүхдэд ээлгүй байна. Гэр хороолод харанхуй, цагдаагийн эргүүл, хараа хяналт бага байгаа нь гэмт хэрэг гарах үндэс болж байна. Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын ачаалал хэтэрсэн, хүүхдийн цэцэрлэгийн хүрэлцээ муу, суурь боловсролын байгууллагуудын сургалтын чанар, сурах орчин, түвшин харилцан адилгүй, ялгаа ихтэй байна.

Иргэд амарч тухлах цэцэрлэгт хүрээлэн байхгүй, иргэдийн ажиллаж, амьдрах орчинг сайжруулаагүй 4 жил өнгөрч байна.

**Бидний хийх ажлууд:**

Бид сурч хөгжих, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ авах боломж бүрдсэн, биеийн тамираар хичээллэдэг, авьяаслаг иргэдтэй, урлаг, гоозүйн үнэт капиталыг хуримтлуулсан, иргэндээ ээлтэй хот болгоно.

**5.1 Амьдрахад таатай, аюулгүй орчин бий болгох чиглэлээр:**

5.1.1 Хуучны угсармал орон сууцны дулаалгыг бүрэн дуусгана.
5.1.2 Орон сууцны дундах бетон болон тоосгон гражтай иргэдийг нэгдсэн дулаан зогсоолтой болгох зохион байгуулалтыг хуулийн хүрээнд дэмжиж ажиллана.
5.1.3 Гэр хорооллын айл өрхийн түлшний хэрэглээг аюулгүй болгоно.
5.1.4 Агаар дахь хорт хийн хэмжээг эрүүл ахуйн шаардлага стандартын хэмжээнд хүртэл багасгаж, халаалтын шинэ технологийг дэмжин агаарын бохирдолгүй болгоно.
5.1.5 "Гудамж" төслийг үргэлжлүүлэн дэмжиж авто замын уулзварыг шинээр барьж түгжрэлийг бууруулна.
5.1.6 Хүүхдэд ээлтэй хот болох цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ.
5.1.7 Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцнуудыг буулгаж, шинээр барих дахин төлөвлөлтийн төслүүдийг хэрэгжүүлнэ.
5.1.8 Ногоон байгууламж, амралт зугаалгын бүс, цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлуудыг бүх талаар дэмжиж ажиллана.
5.1.9 "Хашаандаа сайхан амьдаръя" төсөл хэрэгжүүлж, орчноо тохижуулж мод зүлэг тарьж суулгасан иргэдийг дэмжиж ажиллана.
5.1.10 Улаанбаатар хотын гэр хорооллын болон хотын гудамжнуудыг бүрэн камержуулах, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх замаар гэмт хэргийн гаралтыг бууруулж, хяналтыг сайжруулна.
5.1.11 Цагдаагийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, "Миний Цагдаа намайг хамгаална" гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
5.1.12 Төвөөс алслагдсан бүсийн иргэдэд гамшгаас хамгаалах системийг бий болгож аврах, гал унтраах ангийг шинээр байгуулахад дэмжиж ажиллана.
5.1.13 Улаанбаатар хотын соёлт иргэнийг төлөвшүүлэх чиглэлээр " Хотын соёлт иргэн" сургалт, нөлөөллийн ажлыг Улаанбаатар хотод шинээр нүүн ирж бүртгэгдэж буй иргэд болон бүх шатны боловсролын байгууллагыг хамруулан тогтмол зохион байгуулж хэвшүүлнэ.
5.1.14 Хөршийн холбоо, олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааг идэвхжүүлэн дэмжиж орчны аюулгүй байдлыг сайжруулна.

**5.2 Эрүүл мэнд, боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр:**

5.2.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд идэвхтэй оролцох дэд бүтцийг бий болгоход онцгойлон анхаарна.
5.2.2 Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлнэ.
5.2.3 Бага насны хүүхэд 500 метрийн радиус дотор цэцэрлэг, сургуульдаа хүрэх боломжийг төлөвлөж ажиллана.
5.2.4 Алслагдсан сургуулиудад автобус ажиллуулж, хүүхдийн сургуульдаа аюулгүй ирж, очих нөхцөлийг бүрдүүлнэ.
5.2.5 Хүүхэд хөгжлийн ордон байгуулж боловсролын тэгш бус байдлыг бууруулахад онцгой анхаарч ажиллана.
5.2.6 Сургууль бүрийг 2-оос дээшгүй ээлжээр хичээллэдэг болгоно.



1117145633
УХА0612 5077278

5.2.7 ЕБС-ын үндсэн хичээлээс гадна сурагчдын оюун ухаан, бүтээлч байдлыг хөгжүүлэх, мэдээллийн технологийн орчин үеийн мэдлэг олгох зорилгоор хиймэл оюун ухаан, кодчилол, роботчилол, технологийн лаборатори, дизайны чиглэлийн суурь хөтөлбөрүүдийг хувийн хэвшилтэй хамтран явуулдаг тогтолцоог дэмжиж ажиллана.

5.2.8 Гэр бүл, хүний эрхийг хамгаалах чиглэлээр сургалт сурталчилгааг тогтмолжуулна.

5.2.9 Хороо бүрд урьдчилсан сэргийлэх эмч ажиллуулж, иргэдийн эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, эрүүл мэнд, биеийн тамирын өрөө, талбайг тохижуулж спортоор хичээллэх боломжийг бий болгоно.

5.2.10 Жирэмсэн эхчүүд, хүүхэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд, ахмад настнууд руу чиглэсэн нийгмийн болон эрүүл мэндийн бодлогыг дэмжих эмнэлгийн үйлчилгээг сайжруулах хөтөлбөр боловсруулна.

5.2.11 Сургуулийн эргүүл төслийг үргэлжлүүлэн дэмжиж, сурагч хүүхдүүд сургуульдаа ирэх, гэрлүүгээ буцах замдаа халдлагад өртөхгүй аюулгүй байх үүднээс ухаалаг мэдээлэгчтэй сурагчийн үнэмлэхийг нэвтрүүлж, сургуулийн ойр орчим, автобусны буудал, сургуулийн автобусанд долгион дамжуулагч суурилуулна. Ингэснээр сурагчдын байршил, аюулд өртөж буй эсэх мэдээлэл нь аав ээжийнх нь гар утсанд ирдэг болно.

5.2.12 Гэр хорооллын дахин төлөвлөлтөөс чөлөөлөгдсөн газар дээр олон нийтийн номын санг байгуулах ажлыг дэмжиж ажиллана.

5.2.13 Мэдээллийн технологийн дэд бүтцийг өргөжүүлж, өргөн зурвасын, өндөр хурдны интернет сүлжээг ялангуяа гэр хорооллын бүсэд нэвтрүүлэхэд онцгойлон анхаарна.

**5.3 Иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газар, соёл, урлагийн байгууламжуудыг хамгаалах чиглэлээр:**

5.3.1 Соёлын өвийг хамгаалах төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж, дүүрэгт аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлнэ.

5.3.2 Иргэдийн амрах, зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх цэцэрлэгт хүрээлэн, авто машины зогсоол, саравч, хүүхдийн тоглоомын талбай, боловсон бие засах газрууд бүхий цэгүүд байгуулна.

5.3.3 Өвлийн спортын ордонг гадаад болон дотоодын хөрөнгө оруулалт, улсын болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээр санхүүжүүлж байгуулах ажлыг дэмжиж ажиллана.

5.3.4 Хувийн хэвшлүүдтэй хамтран ахмадын сувилал байгуулахад дэмжиж ажиллана.

5.3.5 Газрын нэгдсэн үзлэг зохион байгуулж, ашиглалт, эзэмшлийн зөрчилтэй газруудыг эргүүлэн авч, нийтийн зориулалттай ногоон байгууламж болгоно.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.07.06 № 1119

танай ______ -ны № ______ -т

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ХАН-УУЛ ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Хан-Уул дүүргийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Хан-Уул дүүргийн Ардчилсан намын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар

зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хан-Уул дүүргийн ардчилсан намын мөрийн хөтөлбөр /...8 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Хан-Уул дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт: 8. хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР

D:\Documents\Documents\2020 onywuulsan bichig\2020.07.01-HUD-ITI-Aхlam.docx

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
"ИРГЭДИЙН ОРОЛЦОО ДҮҮРГИЙН ХӨГЖИЛ"
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

АРДЧИЛСАН НАМ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ХОРОО
8488913 ХНТ1176

## Нэг. ИРГЭДЭЭ ДЭМЖИХ ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРҮҮД

1. "Хүүхдэд ээлтэй Хан-Уул" хөтөлбөрийг хүүхэд хамгаалал, хүүхэд хөгжил гэсэн 2 үндсэн чиглэлээр үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Уг хөтөлбөрийн хүрээнд "Шавийн эрдэм багшаасаа" дэд хөтөлбөр боловсруулж хүүхэд сургууль, цэцэрлэгийн багш нарыг дэмжсэн тусгайлсан ажил зохион байгуулна.
2. Дүүргийн ахмадуудад зориулсан "Ахмадаа дээдлье" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн хүрээнд ахмадуудын эрүүл мэнд, чөлөөт цагт зориулсан арга хэмжээ авч ажиллана.
- Гэр хорооллын гудамжны авто замын зорчиход хүндрэлтэй огцом өгсүүр, энхэл донхолтой, халтиргаа гулгаа үүсдэг хэсгийг жил бүр дүүргийн төсвийн хөрөнгөөр хавар, намар засаж сайжруулна.



1117146633
УХА0612 5077278

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.07.07 № 1154

танай ________ -ны № ________ -т

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
АРДЧИЛСАН НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Багахангай дүүргийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, "Алсын хараа-2050", нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Багахангай дүүргийн Ардчилсан намын Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн

хөтөлбөр түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Багахангай дүүргийн ардчилсан намын мерийн хөтөлбөр 10 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Багахангай дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт: 10 хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг. 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2022.07.06 № 1120

танай ______-ны № ______-т

БАГАНУУР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БАГАНУУР ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Багануур дүүргийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Багануур дүүргийн Ардчилсан намын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл,

сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Багануур дүүргийн ардчилсан намын мөрийн хөтөлбөр /.10.. хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Багануур дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт:10... хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.07.03 № 1111

танай ________ -ны № ________ -т

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БАЯНГОЛ ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Баянгол дүүргийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Баянгол дүүргийн Ардчилсан намын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар

зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баянгол дүүргийн ардчилсан намын мөрийн хөтөлбөр /.6./ хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Баянгол дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт: 6 хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР

## БАЯНГОЛ ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМ

# “ӨРХИЙГ ДЭМЖСЭН-ӨСӨЛТИЙН БОДЛОГО”

Баянгол дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох БГД-ийн Ардчилсан намын Мөрийн хөтөлбөр

1117145633
УХА0612 9077278

2020 он
Улаанбаатар хот

АРДЧИЛСАН НАМ
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ХОРОО
8488916 ХНТ0903

## ХУРААНГУЙ

1. Оршил
2. Нээлттэй засаглалтай БАЯНГОЛ дүүрэг
3. Амьдрахад таатай БАЯНГОЛ дүүрэг
4. Эрүүл чийрэг иргэнтэй БАЯНГОЛ дүүрэг
5. Эрдэм боловсролтой иргэнтэй БАЯНГОЛ дүүрэг
6. Аюулгүй, амгалан БАЯНГОЛ дүүрэг

АРДЧИЛСАН НАМ
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ХОРОО

# 1.ОРШИЛ

Баянгол дүүргийн Ардчилсан нам Баянголчуудынхаа дэмжлэг, иргэдийнхээ даалгавараар 2012-2016 онд "5А" морийн хөтөлбөр, 2016-2020 онд "ШИЙДЭЛ 2020" мөрийн хөтөлбөрөө амжилттай хэрэгжүүллээ.

Баянгол дүүрэгт 2012-2020 онд эрүүл мэнд, боловсрол, дэд бүтэц, зам харилцаа, хүний хөгжлийн чиглэлээр томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж шинэчлэл, өөрчлөлтийн суурийг амжилттай тавьсан.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаа тогтмолжиж, иргэддээ улам бүр нээлттэй, ил тод байх зарчимд шилжин ажиллаж байна. Бид иргэдийнхээ дуу хоолойг сонсдог, тэднийхээ санаа бодолд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулахыг зорин ажиллаж ирсэн.

Бидэнд ахиулАН хийх ажил их байна. Бид Баянгол дүүргийнхээ хөгжлийн шийдлийг тодорхойлсон, ард иргэд нь амьдрахад таатай орчин, нөхцөлтэй, эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж үйлчилгээтэй, хүүхэд багачууд нь сургууль, цэцэрлэгтэй, аюулгүй, амгалан, өрх бүрт өсөлтийг хүргэсэн "ӨРХИЙГ ДЭМЖСЭН-ӨСӨЛТИЙН БОДЛОГО" мөрийн хөтөлбөрөө иргэд, сонгогчиддоо танилцуулж байна.

Энэ бол "5А", "ШИЙДЭЛ 2020" мөрийн хөтөлбөрийн үргэжлэл, өсөлтийг өрх бүрд хүргэх цогц бодлого юм.

Таныг бидний дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийг дэмжин Баянгол дүүргийн Ардчилсан намаас нэр дэвшүүлсэн ӨРХИЙГ ДЭМЖСЭН ХӨГЖЛИЙН БАГ-аа багаар нь дэмжиж дүүргийнхээ хөгжил, дэвшлийн төлөө бидэнтэй хамтран ажиллана гэдэгт итгэл дүүрэн байна.

Баянгол дүүрэг хөгжлийн хурд, бүтээн байгуулалтын эрчээ улам нэмэх болтугай.

--ooOOOoo--

1117145033
УХА0Е12 9377278

АРДЧИЛСАН НАМ
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ХОРОО
8488916 ХНТ0003

## 1.НЭЭЛТТЭЙ ЗАСАГЛАЛТАЙ БАЯНГОЛ ДҮҮРЭГ

1. Дүүргийн хөгжлийн бодлого боловсруулах, дүүргийн төсөв, тухайн жилийн эдийн засаг, нийгмийн зорилтыг боловсруулах, батлахдаа иргэдийн саналыг авах, тусгах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
2. Дүүргийн Иргэний танхимын үйл ажиллагааг идвэхжүүлж дүүргийн удирдлагын шийдвэр гаргалтанд иргэдийн байр суурь, санал бодлыг тусгах, олон нийтийн санааг зовоож буй асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг хийх, хууль эрх зүйн чиглэлээр иргэдийг сургалтанд хамруулах, хуулийг сурталчлах, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангах, иргэдэд шаардлагатай бүхий л төрлийн сургалтуудыг зохион байгуулж ажиллана.
3. Нэг цэгийн үйлчлгээний товийн үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
4. 1800-1222 дугаар бүхий Баянгол дүүргийн лавлан туслах үйлчилгээг үргэлжлүүлэн ажиллуулж, иргэн, ААН, байгууллагын өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх "ШУУРХАЙ БАГ"-ийг тогтмол ажиллуулна.
5. Хорооны цогцолбор байргүй 9, 18, 24, 25 дугаар хороог цогцолбор байртай болгож, Баянгол дүүргийн 25 хороонд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай, хүртээмжтэй үзүүлэх нэгдсэн стандартыг батлан мөрдүүлж ажиллана.
6. Хүн амын тоо, газарзүйн байршлыг харгалзан 3, 5, 6, 7, 12, 20 дугаар хороодыг хуваан шинээр хороо байгуулах асуудлыг эрх бүхий байгууллагатай хамтран шийдвэрлэж, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулна.
7. Дүүргийн иргэдэд газар өмчлүүлэх ажлыг бусад газрын нөөц бүхий дүүргүүд болон улсын чанартай авто зам дагуу зохион байгуулна.
8. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, тэдний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулах зорилгоор "Баянголд үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдааг үргэлжлүүлэн зохион байгуулж, тоог нэмэгдүүлнэ.
9. Мэдээ мэдээллийг нээлттэй, хүртээмжтэй, ил тод байлгаж www.bgd.mn веб хуудсын үйл ажиллагааг мэдээлийн эх сурвалж болгоно.

## 2.АМЬДРАХАД ТААТАЙ БАЯНГОЛ ДҮҮРЭГ

1. Дүүргийн гэр хороолол бүхий хороодыг инженерийн дэд бүтэц /цэвэр ус, бохир ус ариутгах татуурга, шилэн кабель/-д холбож, халаалтын төвлөрсөн болон бие даасан эрчим хүчний эх үүсвэртэй амины орон сууц болгон дахин төлөвлөх "БАЯНГОЛ-АМИНЫ ОРОН СУУЦ" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
2. Дулаан алдагдал ихтэй угсармал орон сууцны фасадыг шинэчлэх, дулаалах "ДУЛААН ТЕХНИКИЙН ШИНЭЧЛЭЛ" хөтөлбөрийг хэрэгжүүлж 2, 3, 4, 10-р хороолол болон 6-р бичиг хорооллын 495 орон сууцыг дулаална.
3. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон иргэд, залуу гэр бүл зэрэг дэмжлэг, туслалцаа шаардлагатай 1000 өрх, иргэнийг хамруулах "БАЯНГОЛ-ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦ" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
4. Орон сууцны дээвэр засвар, лифт шинэчлэлийн ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
5. Дүүргийн алслагдсан хороодод нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
6. "Баянголчуудын Бямба" аяныг үргэлжлүүлэн зохион байгуулж, бүх нийтийн тохижилт, их цэвэрлэгээний ажлыг эрчимжүүлнэ.

1117145633
УХА00128077978

АРДЧИЛСАН НАМ
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ХОРОО
8468916 ХНТ0001

7. Хог хаягдлыг ангилан ялгах тогтолцоог нэвтрүүлж, "Баянгол шинэ өргөө" ОНӨААТҮГ-ын дэргэд бага оврын хог хаягдал боловсруулах үйлдвэр байгуулна.
8. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон хуучин орон сууцны барилгуудыг иргэдийнх нь оролцоотойгоор дахин төлөвлөлт хийж, төсөл сонгон шалгаруулалтаар дахин барилгажуулах ажлыг нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
9. Дүүргийн нутаг дэвсгэрт байгаа тоосгон болон дан гражийг иргэдийн оролцоотой дахин төлөвлөж, газар доор болон олон давхар авто зогсоол барих ажлыг УБ хотын Захирагчийн ажлын алба болон төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран хэрэгжүүлнэ.
10. Дүүргийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын идэвх санаачлагад тулгуурлан нийтийн эзэмшлийн зам талбайг цэцэрлэгжүүлэх, зүлэгжүүлэх, мод тарих замаар ногоон байгууламжийг 25 хувиар нэмэгдүүлнэ.
11. "Баянгол-Агропарк" ОНӨУТҮГ-ын эзэмшил талбайд цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдийн амралт, зугаалгын бүс бий болгоно.
12. Хуучны орон сууцны дундах эвдэрсэн авто замыг нөхөх, засварлах болон шинэчлэх ажлыг нийслэлийн холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.
13. Цэвэр усны хангамж хангалтгүй гэр хороолол бүхий хороодод цэвэр ус түгээх худаг барина.
14. Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааг дэмжиж, дүүргийн Нэгдсэн зөвлөлийг үргэлжлүүлэн ажиллуулна.

## 3.ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ИРГЭНТЭЙ БАЯНГОЛ ДҮҮРЭГ

1. Өрхийн эмнэлгийн цогцолбор байргүй 9, 18, 24, 25 дугаар хороог цогцолбор байртай болгож, иргэдэд анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай хүргэх ажлыг зохион байгуулна.
2. Хороо, өрхийн эрүүл мэндийн төвөөс алслагдсан хороолол, хотхонд ӨЭМТ-ийн салбарыг байгуулж анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэнэ.
3. Хүн амын эрүүл мэндийг дэмжих, бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх зорилгоор "Баянгол олимп" наадмыг тогтмол зохион байгуулан ажиллана.
4. Баянгол дүүргийн Ахмад хөгжлийн ордонд ахмад настанд зориулсан эрүүл мэндийг дэмжих, бие бялдрыг чийрэгжүүлэх болон нийгэм соёлын, олон нийтийн үйл ажиллагааг тогтмолжуулна.
5. Баянгол дүүргийн 15 дугаар хорооны нутаг дэвсгэрт 2014 онд барилгын ажлыг эхлүүлсэн дүүргийн Спорт цогцолборыг[1] ашиглалтанд бүрэн оруулж дүүргийн хүүхэд залуучуудыг спортын бүх төрлөөр хичээллэх, бие бялдраа хөгжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх боломжийг бүрдүүлнэ.
6. Иргэдийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор дүүргийн хэмжээнд гүйлтийн зам, дугуйн зам, чийрэгжүүлэлтийн талбай бүхий цогцолбор 2-с доошгүйг байгуулна.
7. Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор сайжруулсан түлш нийлүүлэх, худалдаалах үйл ажиллагааг эрх бүхий байгууллагатай хамтран иргэдэд хүндрэл чирэгдэлгүй зохион байгуулж ажиллана.

[1] Гүйцэтгэл 80 хувьтай байна.

1117145633
УХА0612 9077273

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ХОРОО
6481916 ХИТ0903

8. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хоёрдогч түүхий эдийн цэгийн тоог цөөрүүлж, алслагдсан хороодод нүүлгэн шилжүүлэх, түүний хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана.

## 4.ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ ИРГЭНТЭЙ БАЯНГОЛ ДҮҮРЭГ

1. Төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд өргөтгөл хийх замаар хичээллэх ээлжийн тоог бууруулж, анги дүүргэлтийн стандартыг мөрдүүлнэ.
2. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын үйл ажиллагааг ажлын чанар, үр дүнгийн индексээр урамшуулна.
3. Нийслэлтэй хамтран 1, 16, 17, 21, 22, 23 дугаар хороодод шинээр хүүхдийн цэцэрлэг байгуулж сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувь хэмжээг 100 хувьд хүргэнэ.
4. Иргэд, аж ахуйн нэгжүүдээс хүүхэд харах үйлчилгээ, алслагдсан гэр хороололд цэцэрлэгийн салбар бүлэг байгуулахыг дэмжинэ.
5. Горхи-тэрэлжийн байгалийн цогцолбор газарт 2014 онд барилгын ажлыг эхлүүлсэн "Баянгол-Хүүхдийн зуслан"-г бүрэн ашиглалтанд оруулж, үйл ажиллагааг эхлүүлнэ.
6. Баянгол дүүргийн "Хүүхэд, залуучуудын соёлын ордон"-д шаардлагатай нэмэлт хөрөнгө оруулалтыг шийдвэрлэн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.
7. Өсвөр насны хүүхэд багачуудад цэрэг, эх оронч хүмүүжил олгох "Эх орон-36" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

## 5.АЮУЛГҮЙ АМГАЛАН БАЯНГОЛ ДҮҮРЭГ

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх "Хөршийн холбоо" дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
2. Олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааг идэвхжүүлэн дэмжиж, орчны аюулгүй байдлыг сайжруулна.
3. "Сэргийлэгч" хөтөлбөр, "Өсверийн сэргийлэгч" дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдээ, мэдээллийг иргэд, хүүхэд залуучуудад олгох, тэднийг урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах арга хэмжээ авч ажиллана.
4. Нийтийн эзэмшлийн талбай, орон сууцны болон гэр хорооллын гудамж талбайд шинээр гэрэлтүүлэг, камер суурилуулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
5. Дүүргийн хэмжээнд эзэнгүй нохой, муур устгалын ажлыг эрчимжүүлж, тоог бууруулахад шинэлэг арга хэлбэрийг ашиглана.
6. Дүүргийн хэмжээнд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд тавих хяналтыг сайжруулж, хүүхэд хамгааллын үйлчилгээг чанартай хүргэж ажиллана.

--ооOOOоо--

1117145633
УХА0612 9077278

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ХОРОО
8488916 ХНТ0503

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.07.08 № 1195

танай ____________-ны №____________-т

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
АРДЧИЛСАН НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Баянзүрх дүүргийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, "Алсын хараа-2050", нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Баянзүрх дүүргийн Ардчилсан намын Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн

37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баянзүрх дүүргийн ардчилсан намын мөрийн хөтөлбөр 11 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Баянзүрх дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт: 11 хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР

# Нийслэлийн Баянзүрх дүүргийн Ардчилсан намын хорооны 2020 оны орон нутгийн ээлжит сонгуульд дэвшүүлж буй мөрийн хөтөлбөр

ЗОРИЛТ:

1. АМЬДРАХАД ТААТАЙ-БАЯНЗҮРХ
2. АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ-БАЯНЗҮРХ
3. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛТЭЙ-БАЯНЗҮРХ
4. БОЛОВСРОЛД ЭЭЛТЭЙ-БАЯНЗҮРХ
5. НЭЭЛТТЭЙ ДҮҮРЭГ-БАЯНЗҮРХ

УЛААНБААТАР ХОТ

2020 ОН

**Манай намаас дэвшүүлж буй мөрийн хөтөлбөр таны ажил амьдралд дараах өөрчлөлтийг санал болгоно:**

Баянзүрх дүүргийг удирдсан 2012-2020 онуудад төр засаг нь иргэдээ сонсдог, иргэнд тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэдэг, дүүргийн төр захиргааны үйлчилгээг иргэндээ ойртуулж, Гэр хорооллын дахин төлөвлөлт, Нийтийн тээврийн салбарын цогц шинэчлэл, төрийн үйлчилгээний нэг цэгийн үйлчилгээ зэрэг томоохон өөрчлөлт шинэчлэлийг хийж ажилласан билээ.

Бид энэ удаа нутгийн захиргааны байгууллагуудаа илүү хариуцлагатай болгож, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэдэг байх зарчмыг баримталж, иргэдээ ажилтай орлоготой болгох, агаар, хөрс, тоосжилт, орчны бохирдлыг багасгах хөтөлбөрийг боловсрууллаа. Түүнчлэн дүүргийн хэмжээнд дэд бүтцийг бий болгож иргэдийг эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл боломжоор хангах зорилт тавиад байна.

**Хүүхэд багачуудад:**

Бид хүүхдэд ээлтэй дүүргийн стандартыг мөрдүүлж "нэгдүгээрт хүүхэд" гэх зарчмаар ажиллана. Хамран сурах тойрог буюу хүүхэд багачууд алхаад очих зайд цэцэрлэг, бага сургуулийг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлнэ. Хүүхдүүдийн боловсролын чанарт онцгой анхаарсан тусгай хөтөлбөр гарган ажиллана. Хороо бүрд хүүхэд залуучууд шинийг санаачлагч зохион бүтээгчдийн төв, хүүхэд хөгжлийн ордон байгуулж хүүхэд бүрийн авьяас чадварын хөгжүүлэхэд онцгой анхаарна.

**Залуучуудад:**

Бид залуучуудаа дэмжиж, сурч боловсрох, хөгжин дэвших орчин нөхцлийг бүрдүүлнэ. Гарааны бизнес эхлүүлж буй залууст хөрөнгө оруулалт татах төр, хувийн хэвшлийн түншлэлийг нэмэгдүүлнэ. Цагийн ажлын байр бий болгох эрх зүйн тогтолцоог бий болгож, залууст чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, нийтийн биеийн тамираар хичээллэх спортын, соёл урлагийн байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлнэ. Залуу гэр бүлийг төлбөрийн чадвартаа тохирсон орон сууцтай болох бодлого төлөвлөлтийг дэмжин ажиллана.

**Ахмад настнуудад:**

Ахмадууд ажил амьдралын арвин туршлагаа хуваалцах, ажил хөдөлмөр хийх боломжийг нэмэгдүүлэх "Ахмадын ажлын байр" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Тэдний нийгмийн амьдралд идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх "Хоёр дахь залуу нас" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлнэ. "Ахмадын орон сууц" хөтөлбөрт дүүргийн ахмадуудыг хамруулахад дэмжлэг үзүүлнэ. Ахмадын асрамж сувиллын жишиг төвийг байгуулна.

**Хөгжлийн бэрхшээлтэй (тусгай хэрэгцээт) иргэдэд:**

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХОРОО

Хөгжлийн бэрхшээлтэй(тусгай хэрэгцээт) иргэд нийгмийн амьдралд идэвхтэй оролцож ажиллаж амьдрах боломжийг шинэ түвшинд гаргаж тэднийг сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэх тусгай хөтөлбөр боловсруулж ажиллана.

## НЭГ. АМЬДРАХАД ТААТАЙ-БАЯНЗҮРХ

**1.1 Иргэдийн ажиллаж, амьдрах таатай, эрүүл аюулгүй орчинг бий болгох чиглэлээр:**

**1.1.1** Хотын тоосжилтыг бууруулах зорилгоор гудамж талбайг зүлэгжүүлж, бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулж, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

**1.1.2** Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагууд болон Сууц өмчлөгчдийн холбоодыг хотын стандартын дагуу тохижилт хийх, ногоон байгууламж нэмэгдүүлэх, иргэдийн зорчих боломжийг хангах хөтөлбөр боловсруулж ажиллана.

**1.1.3** Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлын чанар, үр ашгийг нэмэгдүүлж, арчлалт хамгаалалтыг иргэд, аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

**1.1.4** Нийтийн эзэмшлийн орон сууцнуудын дээврийн болон фасад засварлах, сэргээх ажлыг үргэлжлүүлнэ.

**1.1.5** Нийтийн эзэмшлийн зам талбай болон гэр хороолол, орон сууцны хороолол доторх гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлж нэгдсэн удирдлагын системд бүрэн холбоно.

**1.1.6** Гэр хорооллын дахин төлөвлөлтийг дахин эхлүүлэхийн тулд иргэдийн саналыг тусгаж, Жишиг гудамжуудыг нэмэгдүүлнэ.

**1.1.7** Хашаандаа сайхан амьдрая төслийг хэрэгжүүлж, орчноо тохижуулж, мод зүлэг суулгасан иргэдийг урамшуулж ажиллах системийг бий болгоно.

**1.1.8** Хөршийн холбоо, олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааг идэвхжүүлэн дэмжиж , орчны аюулгүй байдлыг сайжруулна.

**1.1.9** Улсын болон нийслэл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлыг тухайн нутаг дэвсгэрт амьдарч буй иргэдийн санал хүсэлтийг харгалзан шийдвэрлэнэ.

**1.1.10** Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй түргэн үйлчилгээний цэгүүдийг олон улсын жишигт нийцүүлэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангуулна.

**1.2 Эрүүл мэндийн чиглэлээр:**

**1.2.1** Эрүүл мэндийн үйлчилгээ авах шат дамжлага, чирэгдлийг бууруулж, эрүүл мэндийн төвүүдийн үйлчилгээний стандартыг шинэ түвшинд гаргаж, иргэдэд үзүүлэх эмнэлэгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, эрүүл мэндийн байгууллагуудын эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжийг шат дараатай нэмэгдүүлнэ.

**1.2.2** Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох эрүүлжүүлэх "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

**1.2.3** Дүүргийн иргэдийг сүрьеэгийн эрт илрүүлгийг сайжруулж, ертөмтгий бүлгийн судалгааг гарган урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд жилд 1 удаа хамруулна.

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХУРАЛ

1.2.4 Халдварт өвчин, амьсгалын замаар дамжих халдварт өвчний дархлаажуулалтын хамралтыг сайжруулж, өвчлөлийг бууруулах арга хэмжээг үе шаттай авна.

1.2.5 Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлж иргэдийг чихрийн шижин, цусны даралт ихсэх, хорт хавдар зэрэг зохилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт жилд нэг удаа хамруулж, "Эрүүл-Баянзүрх" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.2.6 Архины хамаарал бүхий орон гэргүй тэнэмэл иргэдийг бичиг баримтжуулах, тэдгээр иргэдийг соён гэгээрүүлэх замаар нийгэмшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлнэ.

**1.3 Нийтийн биеийн тамираар хичээллэх орчин нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр:**

1.3.1 Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.3.2 Дүүргийн иргэдийн "Спортын их наадам"-ыг олон төрлөөр жил бүр өргөн хүрээнд зохион байгуулж, "Бүх ард түмний, Үндэсний, Сюутны спортын их наадам"-уудад дүүргийн баг тамирчдыг оролцох нөхцөл, боломцоогоор хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.3.3 Хүүхэд, залуучууд, ахмад настнуудад зориулсан хүүхдийн тоглоом, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн төрөлжсөн талбайг шинээр байгуулах, шинэчилж тохижуулах ажлыг шат дараатай хийнэ.

1.3.4 Усан спорт сургалтын төв, спорт цогцолбортой сургуулиудыг түшиглэн хүүхдийг эрүүл, чийрэг, өв тэгш бие бялдартай болгох зорилт тавьж, "Би сэлж чадна" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

**1.4 Гэр бүл, залуучуудын чиглэлээр:**

1.4.1 Дүүргийн Засаг даргын дэргэдэх Залуучуудын зөвлөлийн үйл ажиллагааг дэмжиж, залуучуудын үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг нэмэгдүүлж, орон нутгийн хөгжилд залуучуудын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч, дүүргийн Засаг даргын дэргэдэх Залуучуудын зөвлөлийн салбар байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

1.4.2 Залуу гэр бүл, зорилтот хэсгийг судалгаанд хамруулж түрээсийн орон сууц болон ипотекийн зээлд үе шаттайгаар хамруулахад дэмжлэг үзүүлж ажиллана.

1.4.3 Гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бий болгохын тулд "Гэр бүлийн өдөр"-ийг жил бүр тэмдэглэж зөвлөгөө өгөх "Гэр бүл"-ийн төвийг байгуулна.

1.4.4 Гэр бүлийг хүчирхийллээс урьдчилан сэргийлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй байгууллага, хамт олныг шалгаруулж олон нийтэд сурталчилна.

1.4.5 Залуучуудыг хотын соёлд суралцуулах, гэр бүлийн боловсрол олгох, сэрэг зан үйл хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, соён гэгээрүүлэх дугуйлан клубуудыг нээж, үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

1.4.6 Залуучуудыг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулж, тогтвортой ажлын байраар хангаж, дэмжлэг үзүүлнэ

1117145633
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХОРОО

1.4.7 Залуу эцэг эхчүүдэд зориулсан амьдрах ухаанд сургах, зөвлөгөө мэдээллээр хангах арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран үе шаттай зохион байгуулна.

1.4.8 "Залуу-Ээж" хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж, дүүргийнхээ залуу ээжүүдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх төвийг байгуулж, сургалт зохион байгуулна.

### 1.5 Ахмад настнуудад дэмжлэг үзүүлэх чиглэлээр:

1.5.1 Ахмад настны асаргаа үйлчилгээ, сэргээн засах болон сувилахуйн үйлчилгээг нэмэгдүүлэхэд анхаарч, ахмадуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулна.

1.5.2 Ахмад настнуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх танхимыг хороо бүрд байгуулж, үйл ажиллагааг дэмжинэ.

1.5.3 Ахмадын ордон байгуулж, 28 хорооны дэргэдэх Ахмадын зөвлөлөө түшиглэн дүүргийн нийт ахмад настнуудыг хамруулсан үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.

### 1.6 Хог цэвэрлэгээ, тээвэрлэлтийн чиглэлээр:

1.6.1 Хог хаягдлын удирдлагын шинэ менежментийг нэвтрүүлж, хог тээврийн машины тоог нэмэгдүүлж, парк шинэчлэл хийнэ.

1.6.2 Хог ангилах, ялгах, дахин боловсруулах үйл явцыг төрийн бус байгууллагууд болон хувийн хэвшилүүдтэй хамтран зохион байгуулж, хог ангилан ялгах савны тоо, байршлуудыг нэмэгдүүлнэ.

1.6.3 Орчны бохирдол, гуу жалга, далан суваг үүсмэл болон хур хогийн цэвэрлэгээг эрчимжүүлж, хогийн цэг үүсэх нөхцөлийг арилгана.

1.6.4 Хог хаягдал үүсгэж, гудамж талбайг бохирдуулж хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангахгүй байгаа хууль бус үйлдлүүдэд хяналт тавих эргүүлийг ажиллуулна.

## ХОЁР-АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ-БАЯНЗҮРХ

### 2.1 Бизнес эрхлэхэд таатай орчинг бүрдүүлэх чиглэлээр:

2.1.1 Дүүргийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвөөр дамжуулан төр хувийн хэвшлийн түншлэлийг гүнзгийрүүлж, хувийн хэвшлийн хийх боломжтой ажлуудыг төр хийдэггүй байх зарчмыг баримталж, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

2.1.2 Дүүргийн Засаг даргын дэргэдэх Залуучуудын зөвлөлийн Залуу бизнес эрхлэгчдийн холбооны үйл ажиллагааг дэмжиж, бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлж, хамтран ажиллана.

2.1.3 Жижиг дунд, эрхийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлж, Баянзүрхэд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан авахыг иргэдэд сурталчилах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, бараа бүтээгдэхүүнээ борлуулах ажлын байраар шат дараатай хангах ажлыг үргэлжлүүлнэ.

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ... ХОРОО

**2.1.4** Алслагдсан хороодод аж ахуй эрхлэх байдлыг дэмжихийн зэрэгцээ ажлын байр бий болгоход хувь нэмэр оруулсан аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжинэ.

**2.2 Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох чиглэлээр:**

**2.2.1** Хороо бүрд хөдөлмөр зуучлалын төв байгуулж, ажилгүй иргэдийг ажилд зуучилдаг тогтолцоог сайжруулна.
**2.2.2** Орчин үеийн дэвшилтэт технологи бүхий бага, дунд оврын жишиг загвар бүхий үйлдвэр байгуулахыг дэмжиж ажиллана.
**2.2.3** Оюутан залуучуудад цагийн ажил олгож, цаг, өдрөөр ажиллах ажлын байр бий болгосон аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ
**2.2.4** Иргэдийн өрхийн бизнесийг дэмжих зорилгоор сошиал платформыг үүсгэнэ.
**2.2.5** Залуусын гарааны бизнесийг дэмжих "Бизнес-Старт-Ап" төвийг байгуулна.
**2.2.6** "Хөдөлмөрч оюутан" хөтөлбөрийг хэрэгжүүлж Цахим ажлын байрыг бий болгоно.
**2.2.7** "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байр" хөтөлбөр боловсруулж, Тавиас дээш насныхан болон тэтгэврийн насныхныг ажлын байраар хангах "Хоёр дахь залуу нас" хөтөлбөр хэрэгжүүлнэ.

## ГУРАВ. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛТЭЙ-БАЯНЗҮРХ

**3.1. Хот байгуулалт, дэд бүтцийн хөгжлийн чиглэлээр:**

**3.1.1** Зам, замын байгууламжийн оновчтой төлөвлөлтийг хэрэгжүүлж, асфальт, бетонон болон бусад төрлийн замуудаар гэр хорооллын гол гудамжуудыг төв замтай холбох ажлыг шат дараатай зохион байгуулна.
**3.1.2** Дүүргийн гэр хороолол дундах шороон замыг хусч тэгшлэх болон орон сууцны хороолол доторх зам талбайг засаж сайжруулах ажлыг үргэлжлүүлж хийнэ.
**3.1.3** Гэр хороод болон зуслангийн бүсийн дэд бүтцийг сайжруулна.
**3.1.4** Иргэдийн эрэлтэд нийцсэн нийтийн тээврийн шинэ чиглэлүүдийг бий болгоно.
**3.1.5** Гэр хороодын гуу жалга бүхий газруудад явган шат, гүүр зэргийг барьж иргэдийн зорчих нөхцөлийг сайжруулна.
**3.1.6** Гэр хорооллын хүн амын суурьшлын бүсэд төвлөрлийн зэргийг тодорхойлж хэрэгцээт цэгт ус түгээх худгийн тоог нэмэгдүүлнэ.
**3.1.7** Дүүргийн нутаг дэвсгэрт байгаа тоосгон болон дан гаражийг иргэдийн оролцоотой дахин төлөвлөнө.
**3.1.8** Гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр бүрэн хангана.
**3.1.9** Хороолол дунд ус зайлуулах сувгууд болон үерийн далан хамгаалалтыг шинээр бий болгоно.

**3.2 Агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр:**

**3.2.1** Гэр хорооллын яндang цөөрүүлэх зорилгоор орон сууцжуулах хөтөлбөрийг эрчимжүүлж, гэр хорооллоос орон сууцанд орж буй зорилтот бүлгийг бодлогоор дэмжиж ипотекийн зээлийн олголтыг хамруулна.

**3.2.2** Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын айлын дулаан алдагдалыг бууруулах "Өнтэй эвлэжье" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

**3.2.3** Гэр хорооллыг өвлийн цагт цахилгаанаар халаах чадвартай болгох үүднээс цахилгаан дамжуулах чадамжийг нэмэгдүүлж, эрсдэлгүй аюулгүй дэд бүтцээр хангана.

**3.2.4** Хөрсний бохирдлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж "Жорлонгоо өөрчлье" төслийг өргөжүүлэх дүүрэг-иргэн хоёрын хамтын механизмийг хөгжүүлж, гэр хорооллын айлуудын жорлонг шинэчилж, жорлонгоос үүдэх өвчлөл, бохирдолыг тэглэнэ.

**3.3 Хүрээлэн буй орчныг хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр:**

**3.3.1** "Ногоон бүс" хөтөлбөр (Туул, Улиастай голыг сэргээх, хамгаалах, арчлах зорилгоор голын эрэг дагасан ногоон бүс, ойжуулалт хийх) хэрэгжүүлж, 2024 он гэхэд дүүргийн 1 хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлнэ.

**3.3.2** Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хөрсний чанарыг сайжруулах зорилгоор гэр хорооллын айл бүрт хашаандаа мод тарих, хүлэмжийн аж ахуй эрхлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгоно.

**3.3.3** Харшил үүсгэгч шарилж зэрэг нэр бүхий зэрлэг ургамлыг устгаж, иргэдийн эрүүл таатай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

**3.3.4** Дарь-Эх цогцолбор, Баянзүрх хайрхан, Гачууртыг Улаанбаатар хотын аялал жуулчлалын нэгдсэн маршрутад оруулж, цэцэрлэгт хүрээлэн байгуулна.

## ДӨРӨВ-БОЛОВСРОЛД ЭЭЛТЭЙ-БАЯНЗҮРХ

**4.1 Цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр улсын төсөв, гадаадын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр:**

**4.1.1** Улсын төсөв, төрийн өмчийн концесс, гадаадын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар дүүрэгт сургуулийн барилга шинээр барих, сургуулийн өргөтгөл барих ажлыг үе шаттайгаар зохион байгуулж сургуулиудыг хоёр ээлжид бүрэн шилжүүлнэ.

**4.1.2** Дүүргийн цэцэрлэггүй хороодод цэцэрлэг барих, төрийн өмчийн цэцэрлэгийг түшиглэн гэр цэцэрлэг байгуулах ажлыг үргэлжүүлж, хүүхдийг хөгжүүлэх зардлыг нэмэгдүүлнэ.

**4.1.3** Бага насны хүүхэд 500 метр радиус дотор цэцэрлэг, сургуульдаа хүрэх боломжтойгоор хотын ерөнхий төлөвлөгөөнд тусгасны дагуу цэцэрлэг сургуулийг нэмж барин хүртээмжийг жигд болгож, сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын түвшинг үе шаттайгаар өсгөнө.

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХОРОО

**4.2 Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр:**

**4.2.1** Сургууль, цэцэрлэгийн бүсэд аюулгүй байдлыг бүрэн хангасан стандарт нэвтрүүлж, цэцэрлэг, сургуулийн орчныг гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, автомашины хурд сааруулагчтай болгох ажлыг зохион байгуулна.

**4.2.2** Хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор дугуйлан секцийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.

**4.2.3** Хүүхдийг осол гэмтэл, мансуурал, донтолт, болзошгүй эрсдэл, цахим орчны сөрөг нөлөөнөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, эрсдэлд өртсөн хүүхдэд үзүүлэх нөхөн сэргээх үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

**4.2.4** Хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээлэл хяналтын тогтолцоог бэхжүүлж, хариу үйлчилгээний чанарыг сайжруулах замаар хараа хяналтгүй, хөдөлмөр эрхэлдэг, хүчирхийлэлд өртсөн, эрх нь зөрчигдсөн хүүхдийн тоог бууруулж, эрсдэлд өртсөн хүүхдийг шуурхай хамгаалан, үйлчилгээ үзүүлэх нэгжийн үйл ажиллагааг үргэлжүүлж, эрчимжүүлнэ.

**4.2.5** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих, тэгш хамран сургах нөхцлийг бүрдүүлэхэд анхааран, тусгай сургууль цэцэрлэгийн үйл ажиллагааг дэмжинэ.

**4.2.6** Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хичээлээс гадна сурагчдын оюун ухааныг хөгжүүлэх, мэдээллийн технологийн орчин үеийн мэдлэг олгох зорилгоор хиймэл оюун ухаан, кодчлол, эд юмсын интернэт гэх мэт. хичээл сургалтыг орно.

**4.2.7** Сургуулийн эргүүл төслийг үргэлжлүүлэн дэмжиж, сурагч хүүхдүүд сургуульдаа ирэх, гэрлүүгээ буцах замдаа халдлагад өртөхгүй аюулгүй байх үүднээс ухаалаг мэдээлэгчтэй сурагчийн үнэмлэхийг нэвтрүүлж, сургуулийн ойр орчим, автобусны буудал, сургуулийн автобусанд долгион дамжуулагч суурилуулна.

**4.2.8** Дүүргийн зарим хороонд Хүүхэд хөгжлийн төв болон Олон нийтийн номын сангуудыг байгуулна.

**4.2.9** Хүүхэд залуусын инженерийн сэтгэлгээг хөгжүүлэх залуу зохион бүтээгчдийн тоз, сансар судлалын танин мэдэхүйн төв байгуулах ажлыг дэмжиж ажиллана.

**4.2.10** Олон улсын чанартай тэмцээн уралдаанд мэдлэг, чадвараараа манлайлж амжилт гаргасан дүүргийн оюутан, залуучууд болон ерөнхий боловсролын сурагчид хүүхэд багачуудыг дэмжих сан байгуулж, тэдгээрийг алдаршуулна.

**4.3 Сургалтын чанарыг сайжруулах чиглэлээр:**

**4.3.1** "Хүн болох багаасаа" аян өрнүүлж, хүүхдийг амьдрах ухаан бие даах чадвар, харилцааны зев дадал хэвшилд сургаж, үндэсний бахархал, глобал сэтгэлгээтэй иргэн болгон төлөвшүүлэх ажлыг зохион байгуулна.

**4.3.2** Нийтийн спорт заалыг байгуулж, иргэдийн эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх, хамгаалах орчин бүрдүүлнэ.

**4.3.3** Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдтэй хамтран хүүхэд залуучуудыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд

дэмжлэг үзүүлэх зорилгоор виртуал орчин бүхий "Цахим хөгжлийн төв"-ийг байгуулна.

**4.4 Багшийн мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр:**

**4.4.1** Сургууль, цэцэрлэгийг чадварлаг боловсон хүчин, сургалтын орчинтой болгох "Нийслэлийн боловсрол-2024" хөтөлбөр хэрэгжүүлнэ. Олон улсын хөтөлбөрт сургуулийн тоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.
**4.4.2** Багшийн мэргэжил, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор гадаад орнуудад дүүргийн багш нарыг урт болон богино хугацааны сургалтад хамруулах, туршлага солилцох арга хэмжээг шат дараатай зохион байгуулна.
**4.4.3** Олон улсын, улсын болон нийслэлийн шилдэг мэргэжилтний багийг урилгаар ажиллуулж, багш нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна.

**4.5 Иргэний боловсрол олгох албан бус сургалтын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр:**

**4.5.1** Дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудад сурагчдыг ажил мэргэжлээ зөв сонгоход туслах зөвлөн туслах үйлчилгээ нэвтрүүлнэ.

**4.5.2** Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулж, төгсөгчдийг ажлын байраар хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

**4.5.3** "Насан туршийн боловсролын төв"-өөр олгох сургалтын хүртээмжийг сайжруулж, дүүргийн хэмжээнд сургууль завсардалтыг бууруулна.

**4.6 Соёл, урлаг үйлчилгээний чиглэлээр:**

**4.6.1** Соёлын хүртээмжийг нэмэгдүүлж, "Хотын соёл"-ыг төлөвшүүлнэ.

**4.6.2** Соёлын биет болон биет бус өвийн бүртгэл, судалгаа гаргах, сурталчлах, таниулах, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна

**4.6.3** Сургалтын хөтөлбөрт түүх, соёл, үндэсний зан заншил, соёлын үнэт зүйлсийг таниулах, хувь хүний соёл, өв уламжлал, эх оронч сэтгэлгээг хөгжүүлэн, төлөвшүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулна.

## ТАВ. НЭЭЛТТЭЙ -БАЯНЗҮРХ

**5.1 Оновчтой бүтэц-Уялдаатай үйлчилгээний чиглэлээр:**

**5.1.1** Дүүргийн хөгжлийн бодлогыг тодорхойлох хэрэгжилтийг хангах хяналт тавих хариуцлагатай чадварлаг засаглалын бүтцийг бүрдүүлж бэхжүүлэх.
**5.1.2** Төрийн албан хаагчдыг сургах мэргэшүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
**5.1.3** Бүх шатны нутгийн захиргааны байгууллагууд тогтмол хугацаанд иргэдэд ажлаа тайлагнадаг, сонсдог байлгахын тулд "Нээлттэй бодлого" өдөрлөгийг тогтмол зохион байгуулна.

АРДЧИЛСАН НАМ
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХОРОО

5.1.4 Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтыг тогтмолжуулж, үр дүнг тооцох, хяналт тавина.

5.1.5 Төвлөрлийг сааруулж, тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэхийн тулд хүн амын тостой уялдуулан төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, дүүргийг орон нутгийн зэрэглэлтэй хот болгох, их хүн амтай хороодыг хуваах, ачааллыг тэнцвэржүүлэх асуудлыг Нийслэл, УИХ-д уламжилж шийдвэрлүүлэх.

5.1.6 Дүүргээс олгодог тусгай эрх зөвшөөрөл авахад тавигдах шаардлага, шалгуурыг хялбаршуулж, цахим хэлбэрт шилжүүлж, нэгдсэн удирдлагын программ хангамжаар хангана.

**5.2 Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгох чиглэлээр:**

5.2.1 Дүүргийн харьяа байгууллагууд болон хороодод иргэдэд үйлчлэх угтах үйлчилгээг нэвтрүүлж, хөтөч ажиллуулна.

5.2.2 Нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчдад бүх хэлбэрийн авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

5.2.3 Нутгийн захиргааны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэх, төрийн үйлчилгээний олон улсын стандартад нийцсэн шинэ технологийг нэвтрүүлэх, баталгаажуулах. шийдвэр гаргахад бүх нийтийн оролцоо, төр хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлнэ.

5.2.4 Иргэдийн өргөдөл, гомдол мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх явцыг цахим бүртгэлд оруулж, цаг алдалгүй судлан үзэж түргэн шуурхай шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлж ажиллана.

5.2.5 Хяналт шалгалтыг сайжруулж төрийн үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түргэн шуурхай, ил тод мэдээлж ажиллана.

5.2.6 Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод хяналтыг сайжруулах замаар ажлын байрны эмх цэгц үүрэг хариуцлагыг дээшлүүлнэ.

5.2.7 Нутгийн захиргааны байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, төсөв санхүүгийн сахилга батыг чанд мөрдүүлнэ.

**5.3 Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:**

5.3.1 Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийг татан оролцуулж, Олон нийтийн цагдаа, Оюутан цагдаа хөтөлбөрүүдийг үргэлжлүүлнэ.

5.3.2 Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд камержуулалтын ажлыг эрчимжүүлнэ.

5.3.3 Иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүднээс цагдаагийн хэсгүүдийг хороодын дунд нэмж байршуулна.

5.3.4 Дүүргийн хэмжээнд архидан согтуурахтай тэмцэх ажлыг сайжруулж, согтууруулах ундаа худалдаалан борлуулдаг, түүгээр үйлчилдэг газруудын түвшинг тогтоож, хуулийн хэрэгжилтийг хханган ажиллуулна.

**5.4 Газрын харилцааны чиглэлээр:**

**5.4.1** Иргэдээс судалгаа авч хэсэгчилсэн болон ерөнхий төлөвлөгөөний дагуу газар олгох боломжуудыг судалж, шийдвэрлэнэ.

**5.4.2** Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох зэрэг газартай холбоотой мэдээ мэдээллийг нээлттэйгээр иргэдэд хүргэнэ.

**5.4.3** Зуслан ерөнхий төлөвлөгөөний дагуу 11,20,23 дугаар хороодын зуслангийн газар өмчлөх ажлыг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулан үргэлжлүүлнэ.

## 5 БҮЛЭГ 108 ЗОРИЛТ БҮХИЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

БАГАНУУР ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМ

*"АЖИЛЛАЖ АМЬДРАХАД ТААТАЙ БАГАНУУРЫН ТӨЛӨӨ"*

# БАГАНУУР ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР-2020

1117145033
УХА0612 9077278

АРДЧИЛСАН НАМ
1
БАГАНУУР ДҮҮРГИЙН ХОРОО

АГУУЛГА

1. ХАРИУЦЛАГАТАЙ ЗАСАГЛАЛТАЙ БАГАНУУР

2. АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ БАГАНУУР

3. НЭЭЛТТЭЙ ТӨЛӨВЛӨЛТТЭЙ БАГАНУУР

4. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛТЭЙ БАГАНУУР

5. АМЬДРАХАД ТААТАЙ БАГАНУУР

**Манай мөрийн хөтөлбөр таны ажил амьдралд өөрчлөлтийг санал болгоно**

Ардчилсан нам Багануур дүүргийг удирдсан 2012-2016 жилүүдэд төр засаг нь иргэдээ сонсдог, иргэнд тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэдэг, Нийслэл, дүүргийн төр захиргааны үйлчилгээг иргэндээ ойртуулж, гэр хорооллын инженерийн шугам сүлжээ, цэрдмэл зам, дэд бүтэц, сургууль, цэцэрлэг, ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмж түүний парк шинэчлэлт, төрийн үйлчилгээний нээлттэй, ил тод, түргэн шуурхай үйлчилгээ зэрэг томоохон өөрчлөлт шинэчлэлийг та бүхэнтэй хамтран эхлүүлсэн билээ. Бид энэ удаа дүүргийнхээ иргэдийн төлөө төр захиргааг хариуцлагатай, иргэдээ чирэгдүүлдэггүй болгох, иргэдээ ажилтай орлоготой болгох, агаар, хөрс, тоосжилт, орчны бохирдлыг цогцоор нь шийдвэрлэх гэр хорооллын дахин төлөвлөлт, нийтийн болон амины орон сууц зэрэг томоохон өөрчлөлтийн төслүүдийг санал болгож байна.

**Хүүхэд багачуудад**

Бид хүүхдэд ээлтэй хотын стандартыг мөрдүүлж "нэгдүгээрт хүүхэд" гэх зарчмаар ажиллана. Хүүхдүүдийн боловсролын чанарт онцгой анхаарсан тусгай бодлого гарган хүүхэд, залуучууд шинийг санаачлагч зохион бүтээгчдийн төв, хүүхэд хөгжлийн ордон байгуулж хүүхэд бүрийн авьяас чадварын хөгжүүлэхэд онцгой анхаарна.

**Залуучуудад**

Бид залуучуудаа дэмжиж, суралц боловсрох, хөгжин дэвших орчин нөхцөлийг бүрдүүлнэ. Гарааны бизнес эхлүүлж буй залууст хөрөнгө оруулалт татах төр, хувийн хэвшлийн түншлэл байгуулна. Цагийн ажлын байр бий болгох эрх зүйн тогтолцоог бий болгоно. Залуус чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, нийтийн биеийн тамирааp хичээллэх, спортын, соёл урлагийн байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлнэ. Гэр бүлтэй залууст төлбөрийн чадвартаа тохирсон орон сууцтай болох хувилбаруудыг эхлүүлнэ.

**Гэр бүлүүдэд**

Бид өрх бүрийг тогтмол ажилтай орлоготой болгох бодлогод анхааран хөдөлмөр зуучлалын төвд бүртгэлтэй 500 залууг ажлын байранд зуучлан ажиллана. Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны хувилбарт бодлогыг хэрэгжүүлж 2024 он гэхэд 1000 мянга гаруй өрхийг шинээр орон сууцанд оруулж гэр хорооллын 500 өрхийг инженерийн шугам сүлжээнд шинээр холбосон байна. Дүүргийн хороо бүрд амрах, чөлөөт цагаа тав тухтай өнгөрүүлэх бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулна.

**Ахмад настнууд**

Ахмадууд ажил амьдралын арвин туршлагаа хуваалцах, ажил хөдөлмөр хийх боломжийг нэмэгдүүлэх "Ахмадын ажлын байр" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Тэдний нийгмийн амьдралд идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх "Хоёр дахь залуу нас "үндэсний хөдөлгөөнийг өрнүүлнэ. "Ахмадын орон сууц" Ахмадын өдөр өнжүүлэх төв зэрэг хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1117145633
А0612 9672278

АРДЧИЛСАН НАМ
БАГАНУУР ДҮҮРГИЙН ХОРОО

## 1. ХАРИУЦЛАГАТАЙ ЗАСАГЛАЛТАЙ БАГАНУУР

**Өнөөгийн нөхцөл байдал:**

Хэт олон дарга, удирдах ажилтантай, боловч ажлын уялдаагүй, үйл ажиллагааны давхардал, хийдэл ихтэй, хариуцлага алдсан албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэдэггүй.

Иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээний санхүүжилт хэд дахин нэмэгдсэн ч иргэддээ хүрдэггүй, хугацаа тодорхой бус, албан тушаалтан хүнд суртал гаргаж иргэдийг чирэгдүүлдэг.

Иргэдээ сонсдоггүй, сонссон ч асуудлыг нь шийдвэрлэдэггүй, иргэдийн оролцооны эрх зүйн орчин тодорхойгүй, иргэдийн саналыг ямар асуудлаар, ямар цар хүрээнд авах талаар тогтсон дүрэмгүй.

**Бидний хийх ажлууд:**
*Ажлын чиг үүрэг нь маш тодорхой, цомхон, мэргэшсэн ажлаа мэддэг төрийн албан хаагчидтай бүтэц, хотын захиргаатай болно. Хууль зөрчсөн, иргэдийг чирэгдүүлсэн албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэдэг болно. Иргэдэд үйлчлэх үйлчилгээнд орчин үеийн технологи нэвтрүүлэн, иргэдийн саналыг шийдвэр гаргалтад тусгах журам мөрдүүлнэ.*

### 1.1. Дүүргийн удирдлагыг хариуцлагатай, шийдвэр гаргалтыг шуурхай, нээлттэй болгох чиглэлээр:

1.1.1. Дүүргийн харьяа байгууллагуудыг цомхон болгож, үр ашигтай бүтцэд шилжүүлж үйл ажиллагааны давхардал, хийдлийг устгана.
1.1.2. Нийтийн албан тушаалтнуудын гаргасан шийдвэр, үйл ажиллагаанд үнэлгээ хийж, хариуцлага алдсан албан тушаалтанд хариуцлага тооцдог болно.
1.1.3. Дүүргийн удирдлагын шийдвэр гаргалтад мэргэжлийн холбоод, судалгааны байгууллагууд, иргэдийн сонирхлын бүлгүүдийн оролцоог хангана.
1.1.4. Дүүргийн удирдлага улирал тутам үйл ажиллагааны тайлангаа олон нийтэд нээлттэй тавьдаг болно.

### 1.2. Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүртээмжтэй болгох чиглэлээр:

1.2.1. Төрийн бүхий л үйлчилгээг иргэдэд ойртуулж хорооноосоо авдаг болгоно.
1.2.2. Газар эзэмшил, ашиглалтын талаарх мэдээллийг нээлттэй цахим болгоно.
1.2.3. Төрийн үйлчилгээг иргэдэд цахимаар хүргэж, 2024 он гэхэд 59 төрлийн 536 үйлчилгээг багцлан 100 үйлчилгээг онлайнаар үзүүлнэ.
1.2.4. Төрийн үйлчилгээнд иргэдээс шаарддаг бичиг баримтыг цөөрүүлнэ.
1.2.5. Төрд байгаа мэдээллийг иргэнээс шаарддагийг болиулна.

1117145633
УХА0512 5077270

### 1.3. Иргэд, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр:

1.3.1. Иргэдийн оролцоог хангах эрхзүй, дүрэм, журмыг боловсронгуй болгож үр нөлөөтэй тогтолцоо бий болгоно.
1.3.2. Дүүргийн хөгжилд оруулах иргэдийн санал, хүсэлт, санаачилгыг бүртгэх, хүлээн авах, бодлогод тусгах нэгдсэн цахим платформ бий болгоно.
1.3.3. Дүүргийн иргэний баримтлах хэм хэмжээ, биеэ авч явах соёлын хэмжүүрийг тусгасан " Багануур хотын дүрэм"-ийг шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ.
1.3.4. Хотынхсо захирагчийг иргэд нь шууд сонгож, хариуцлага хүлээлгэдэг эрх зүйн орчныг боловсронгуй болгож хэрэгжүүлнэ.
1.3.5. Хот тохижилтын асуудлаар шийдвэр гаргахдаа иргэдийн санал үндэслэдэг болно.
1.3.6. Дүүргийн иргэдийн хурлаар шийдвэрлэх асуудлын хүрээнд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын саналыг харгалзан үздэг болно.

## 2. АЖИЛТАЙ ОРЛОГОТОЙ БАГАНУУР

### 2.1. Бизнес эрхлэхэд таатай орчин бүрдүүлэх чиглэлээр:

2.1.1. Хувийн хэвшлийн хийх боломжтой ажлуудыг төр хийдэггүй байх зарчмыг баримталж, дүүргийн хэмжээнд хувийн хэвшлийг татвар, санхүүгийн оновчтой бодлогоор дэмжинэ.
2.1.2. Орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүдийн бүтэц зохион байгуулалт, менежментийг сайжруулна.
2.1.3. Дүүргийн харьяа байгууллагууд жижиг дунд, өрхийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлж, дүүрэгт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан авдаг зарчимд шилжинэ.
2.1.4. Дүүргийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэхэд зориулагддаг төсвийг нэмэгдүүлнэ.
2.1.5. Жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэх байдлыг дэмжихийн зэрэгцээ ажлын байр бий болгоход дорвитой хувь нэмэр оруулсан аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх боломж бүрдүүлнэ.
2.1.6. Багануур үйлдвэр технологийн парк бодлогоос гадна, дотнын донор байгууллагын зээл, тусламж татна.
2.1.7. Гахай, шувуу, зөгий, загас үржүүлгийн аж ахуй эрхлэх, хөгжүүлэх санаачилгыг дэмжинэ.
2.1.8. Нийтийн орон сууцанд худалдаа үйлчилгээ эрхлэгч хувь хүн, иргэдийн ус, дулаан, цахилгааны үнийн тарифт өөрчлөлт оруулж бууруулна.
2.1.9. Хувийн хэвшилтэй хамтран зүүн бүсийн худалдаа үйлчилгээний бөөний төв байгуулна. / Зах /

### 2.2. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох чиглэлээр:

1117145633
УХА0512 5077278

АРДЧИЛСАН НАМ
БАГАНУУР ДҮҮРГИЙН ХОРОО

2.1.1. Хөдөлмөр зуучлал, ажилгүй иргэдийг дүүргийн аж ахуйн нэгжүүдэд ажилд зуучилдаг тогтолцоог сайжруулна.
2.1.2. Оюутан залуучуудад цагийн ажил олгож, цаг, өдрөөр ажиллах ажлын байр бий болгосон аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжинэ.
2.1.3. Залуусын бизнес эрхлэлт, инновацлаг гарааны бизнесийг дэмжих бодлогыг оновчтой болгож, үүссэн дэд бүтцийг өргөжүүлж сайжруулна.

**2.3. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр:**

2.3.1. Багануур аялал жуулчлал хөтөлбөр боловсруулж батлуулна.
2.3.2. Багануурын түүхийн музейг байгуулна.
2.3.3. Хэрлэн гол дагуу Спорт загасчлаа, загас үржүүлгийн цөөрөм бий болгоно.

## 3. НЭЭЛТТЭЙ ТӨЛӨВЛӨЛТТЭЙ БАГАНУУР

**3.1. Хот төлөвлөлт, бүсчилсэн хөгжлийн чиглэлээр:**

3.1.1. Багануур дүүргийн хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө 2030-г нээлттэй болгож, олон нийтийн хяналттай хэрэгжүүлнэ.
3.1.2. Ерөнхий төлөвлөгөө түүний хэрэгжилтийг хариуцлагажуулна.
3.1.3. Барилгажилтыг дэмжихгүй байршлуудыг шинэчлэн тодорхойлж, уг байршилд шинээр байшин барилга бариулахгүй байх шийдвэр гаргаж, иргэдэд танилцуулна.
3.1.4. Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу дүүргийн татварын (авто зогсоол, шатахуун түгээх станц, түрээс, ашиглалтгүй барилга байгууламж, хөрөнгө гэх мэт) бааз суурийг өргөжүүлнэ.
3.1.5. Дүүргийн газрын харилцааг ил тод болгоно.

**3.2. Дэд бүтэц, инженерчлэлийн чиглэлээр:**

3.2.1. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг төр хувийн хэвшлийн оролцоотойгоор эрчимжүүлнэ.
3.2.2. Гэр хороолол 2012-2016 онуудад хэрэгжүүлж байсан инженерийн шугам сүлжээний ажлаа үргэлжлүүлнэ.
3.2.3. Бие даасан ус, дулаан дамжуулах дэд төв
3.2.4. Ус, дулаан дамжуулах тэвүүдийг өргөтгөнө. /ЦТП/
3.2.5. Гэр хорооллын иргэд төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны хангамжид холбогдсон амины орон сууцтай болохыг дэмжинэ.
3.2.6. Гэр хорооллын гол зам, гудамж талбайг сайжруулж, камержуулна.
3.2.7. Гэр хорооллын цахилгааны хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамжийг сайжруулна.
3.2.8. Гэр хороолол өндөр хурдны интэрнет сүлжээ, IPTV-г өргөжүүлнэ.
3.2.9. Цахимаар олгосон газрыг шат дараатай дэд бүтэцжүүлнэ.

1117145633
УХА0612 5077278

БАГАНУУР ДҮҮРГИЙН ХОРОО
9100316 ХНТ0001

3.2.10. Сэргээгдэх эрчим хүч, байгаль орчинд ээлтэй дэд бүтцийн шийдлүүдийг дэмжинэ.
3.2.11. Замын дагалдах дэд бүтэц болох ус зайлуулах шугам, гэрэлтүүлэг, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.
3.2.12. Дүүргийн авто зогсоолын тоог нэмэгдүүлнэ.
3.2.13. Төв болон гол, гудамж, замуудад хяналтын камер, хурд хэмжигч хурд сааруулагч байршуулна.
3.2.14. Дүүргийн гудамжнуудыг иргэд, аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулалт хийж, тохижуулж, өөрсдийн нэрээр нэрлүүлэх боломжтой болгоно.
3.2.15. Нийтийн тээврийн үйлчилгээ, чанарыг дээшлүүлж парк шинэчлэлт хийнэ.

## 4. ТОГТВОРТОЙ ХӨГЖИХ БАГАНУУР

### Өнөөгийн нөхцөл байдал

Багануур дүүргийн гэр хороолол ногоон байгууламж муутайгаас агаар, хөрс, орчны бохирдол, тоосжилт зэрэг олон сөрөг үр дагавар бий болж байгаа ч ногоон байгууламжийг нэмэгдүүлж мод тарьсан иргэдээ дэмжих эрх зүйн орчин байхгүй байна.

Гэр хороолold инженерийн дэд бүтцийн хүрэлцээ хангалтгүй, өндөр насжилттай авто машинууд болон хөрсний эвдрэл зэргээс агаар, орчин, хөрсний бохирдол маш өндөр.

Ус, дулааны нөөцийг зохистой, тогтвортой ашиглах, алдагдлыг бууруулах, хог хаягдлын менежмент хийх тогтолцоог бүрдүүлээгүй байна.

**Бидний хийх ажлууд:**

*Бид Багануур дүүргээ хүрээлэн буй орчин, байгаль экологитойгоо нягт шүтэлцээтэй, ой мод, ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, ус, агаар, хөрсний бохирдлыг эрс бууруулж, нөөцийг хэмнэлттэй, ухаалаг зарцуулах тогтолцоонд шилжсэн тогтвортой хөгжлийг бий болгоно.*

**4.1. Хүрээлэн буй орчныг хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр:**

4.1.1. "Ногоон бүс" хөтөлбөр (гэр хорооллын төв зам дагуу ногоон бүс) хэрэгжүүлж 2024 он гэхэд дүүргийн 1 хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлнэ.
4.1.2. Уурхай дагасан хотын хувьд байгаль орчинд хяналт тавьдаг иргэдийн хяналтын бүлэг байгуулж баталгаажуулна.
4.1.3. Дүүргийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хөрсний чанарыг сайжруулах зорилгоор гэр хорооллын айл бүрд хашаандаа мод тарих, хүлэмжийн аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгоно.
4.1.4. Дүүрэгт буй харшил үүсгэгч шарилж зэрэг нэр бүхий зэрлэг ургамлыг устгаж, иргэдийн эрүүл таатай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

1117145633
УХА0612-9877278
АРДЧИЛСАН НАМ
БАГАНУУР ДҮҮРГИЙН ХОРОО

4.1.5. Мал бэлчээрийн газрыг зөв зохистой хэрэглэх үүднээс бодлогын бичиг баримт боловсруулж, батлуулж, мөрдүүлнэ.

**4.2. Агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр:**

4.2.1. Гэр хорооллын янданг цөөрүүлэх зорилгоор орон сууцжуулах хөтөлбөрийг эрчимжүүлэн хэрэгжүүлж, ипотекийн зээлийн олголтыг гэр хорооллоос орон сууцанд орж буй зорилтот бүлэгт нэмэгдүүлнэ.
4.2.2. Дүүргийн агаарын бохирдлыг багасгах, гэр хорооллын айлын дулаан алдагдлыг бууруулахад дотоод, гадаад, олон улсын байгууллагуудтай хамтран санхүүгийн хөнгөлөлттэй нөхцөлтэй хөтөлбөр хэрэгжүүлнэ.
4.2.3. Дүүргийн тоосжилтыг багасгах цогц арга хэмжээ хэрэгжүүлж, PM10 тоосонцрын хэмжээг 50% бууруулна.
4.2.4. Гэр хорооллыг өвлийн цагт цахилгаанаар халаах чадвартай болгох үүднээс цахилгаан дамжуулах чадамжийг нэмэгдүүлж, эрсдэлгүй аюулгүй дэд бүтцээр хангана.
4.2.5. Дүүрэгт цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх цэг байгуулна.
4.2.6. Зуслангийн газарт шаардлагатай дэд бүтэц тавьж, эзэмшүүлэх, өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.
4.2.7. "Жорлонгоо өөрчилье" төслийг өргөжүүлэх дүүрэг-иргэн хоёрын хамтын механизм хөгжүүлж, гэр хорооллын 1000 айлын жорлонг шинэчилж, жорлонгоос үүдэх өвчлөл, бохирдолтыг тэглэнэ.
4.2.8. Ой, рашаан, булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нохой сэргээсэн аж ахуй нэгжийг бүхий л нөхцөлөөр дэмжинэ.
4.2.9. Орчноо ногооруулсан иргэд, аж ахуй нэгжийг урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.

**4.3. Нөөцийг тогтвортой ашиглах, хог хаягдлын менежентийг сайжруулах чиглэлээр:**

4.3.1. Эрчим хүчний хэмнэлттэй хотын гэрэлтүүлэг, ухаалаг гэрлэн дохионы стандарт нэвтрүүлнэ.
4.3.2. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, хог боловсруулах, буцаан ашиглах үйлдвэрийг сайжруулж шинэчилнэ.
4.3.3. Орон сууцны хороолол дунд хог хаягдлыг ангилан байршуулах хэвшлийг нэмэгдүүлнэ.
4.3.4. Хог хаягдлыг дахин боловсруулах, аж ахуйн нэгжүүд өөрсдийн гаргаж буй сав, баглаа, боодлыг татан авч, дахин ашиглах тогтолцоог дэмжих бодлого хэрэгжүүлнэ.

1117145023
УХА0612 9877278

АРДЧИЛСАН НАМ
БАГАНУУР ДҮҮРГИЙН ХОРОО

## 5. АМЬДРАХАД ТААТАЙ БАГАНУУР

### 5.1. Амьдрахад таатай, аюулгүй орчин бий болгох чиглэлээр:

5.1.1. Дүүргийн төвийн газар эзэмшиж буй аж ахуйн нэгж, иргэдэд хотын стандартын дагуу тохижилт хийх ногоон байгууламж байгуулах, иргэдийн зорчих боломжийг хангах шаардлага тавьж, хэрэгжүүлнэ.

5.1.2. Дүүргийн бүхий л байгууллага аж ахуй нэгжид хуулийн дагуу тусгай хэрэгцээт ( хөгжлийн бэрхшээлтэй ) иргэдийг ажлын байраар хангах, тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан зорчих болон үйлчилгээний стандартыг мөрдүүлнэ.

5.1.3. Угсармал орон сууцны дулаалгын ажлыг үргэлжлүүлнэ.

5.1.4. Инфляцид нөлөөлөгч гол нэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг шударга өрсөлдөөний зарчмаар бууруулна.

5.1.5. Дүүргийн гэр хорооллын болон хотын гудамжнуудыг бүрэн камержуулах, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх замаар гэмт хэргийн гаралтыг бууруулж, хяналтыг сайжруулна.

5.1.6. Дүүргийн хүнсний аюулгүй байдлыг хангах үүднээс дүүрэг орчмын газарт органик хөдөө аж ахуй эрхлэгчдэд сертификат олгож, хоол хүнсний нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгоно.

5.1.7. Мах, ногооны зоорь байгуулах иргэн, аж ахуй нэгжийг бүх талаар дэмжинэ.

5.1.8. Иргэдийн хүнсний хэрэгцээгээ өөрөө хангах, хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг бүх талаар дэмжинэ

### 5.2. Эрүүл мэнд, боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр:

5.2.1. Дүүргийн иргэд харьяалал харгалзахгүйгээр бусад дүүргийн эмнэлгээс эрүүл мэндийн үйлчилгээг авдаг болгоно.

5.2.2. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг стандартын шаардлагад нийцүүлэн сайжруулж, эмнэлгийн орны тоог дотоод нөөц боломжид тулгуурлан нэмэгдүүлнэ.

5.2.3. Дүүргийн эрүүл мэндийн төвд нэн шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг нэмэгдүүлж нэгдсэн эмнэлгийн зэрэглэлтэй болгоно.

5.2.4. Иргэн бүрийг насны бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд хамруулна.

5.2.5. Дүүргийн иргэдийн шүдний эрүүлжилтийг 100 хувьд хүргэнэ.

5.2.6. Бүх эмч, сувилагч нарыг мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх сургалтад хамруулна.

5.2.7. Эмч, ажилчдын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлнэ.

5.2.8. Эмэгтэйчүүд, мэс засал, дурангийн хагалгааны нэр төрлийг нэмэгдүүлнэ.

5.2.9. Эрүү, нүүр чих, хамар, хоолой, хүүхдийн мэс заслын төрлийг нэмэгдүүлнэ.

1117145633

УБ0042-9977278

АРДЧИЛСАН НАМ

БАГАНУУР ДҮҮРГИЙН ХОРОО

5.2.10. Эмнэлгийн дотоод орчин, сантехникийн асуудлыг бүрэн шийдвэрлэнэ.
5.2.11. Ахмадын сувиллыг өргөтгөх, өвөл, зунгүй ажиллуулдаг болгоно.
5.2.12. Төрийн, төрийн бус өмчийн алслагдсан сургуулиудад автобус ажиллуулж, хүүхдийн сургуульдаа аюулгүй ирж, очих нөхцөлийг бүрдүүлнэ.
5.2.13. Хороо бүрд спортын талбай байгуулж, иргэдийн эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх, хамгаалах орчин бүрдүүлнэ.
5.2.14. Хороодын олон нийтийн номын сангуудын тоог нэмэгдүүлнэ.
5.2.15. Олон улсын хөтөлбөр хэрэгжүүлнэ. /Боловсрол, Гүн галуутай, Оюуны эрин цогцолбор сургууль/
5.2.16. Нарийн нуур, нугын тал, талын толгой орчимд бага сургууль цэцэрлэгийн цогцолбор байгуулна.
5.2.17. Дүүргийн төрийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудын ажилчид амины орон сууцтай болохыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
5.2.18. Хувийн хэвшилтэй хамтран мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв байгуулна.
5.2.19. 100 хүүхдийн дотуур байр байгуулна.
5.2.20. Хүүхэд хөгжлийн төв байгуулна.
5.2.21. Багш сурагчдын амжилтыг үнэлсэн /Амжилт/ хөтөлбөр хэрэгжүүлж жил тутам урамшуулал олгодог болно.
5.2.22. Техникийн их сургуулийн лицей анги байгуулна.
5.2.23. Оюуны эрин сургуулийн өргөтгөл. /урлаг заал, номын сан, мэдээлэл зүйн кабинет/

**5.3. Иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газар, соёл, урлагийн байгууламжуудыг хамгаалах чиглэлээр:**

5.3.1. Уурхайчдын бахархал цэцэрлэгт хүрээлэн байгуулна.
5.3.2. Соёлын өвийг хамгаалах төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж, дүүргийн аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлнэ.
5.3.3. Иргэдийн амрах, зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх төв талбайг тохижуулж сайжруулна.
5.3.4. Дүүргийн нутаг дэвсгэрт олон улсын хүүхдийн амралтын цогцолбор төв байгуулна.
5.3.5. Газрын нэгдсэн үзлэг зохион байгуулж, ашиглалт, эзэмшлийн зөрчилтэй газруудыг эргүүлэн авч, нийтийн зориулалттай ногоон байгууламж болгоно.
5.3.6. Зуслангийн газрыг өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.
5.3.7. Хүүхэд залуусын инженерийн сэтгэлгээг хөгжүүлэх залуу зохион бүтээгчдийн төв байгуулна.

1117145633
УХ0612 9077278

АРДЧИЛСАН НАМ
БАГАНУУР ДҮҮРГИЙН ХОРОО

Багахангай дүүргийн Ардчилсан Нам

*ХҮН БҮРТ ЭЭЛТЭЙ БАГАХАНГАЙН ТӨЛӨӨ*
*ҮЙЛДВЭРЛЭГ'І БАГАХАНГАЙН ТӨЛӨӨ*

# БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР 2020


АРДЧИЛСАН НАМ
БАГАХАНГАЙ
ДҮҮРГИЙН
ХОРОО
8488916 ХНТ3946

АГУУЛГА


1. УХААЛАГ ЗАСАГЛАЛТАЙ БАГАХАНГАЙ
2. АЖИЛ ОРЛОГОТОЙ БАГАХАНГАЙ
3. НЭЭЛТТЭЙ ТӨЛӨВЛӨЛТТЭЙ БАГАХАНГАЙ
4. ЭКО БАГАХАНГАЙ
5. ЭЭЛТЭЙ БАГАХАНГАЙ
6. БИДНИЙ ДҮҮРЭГТ



1117145833
УХА0012 9377278

АРДЧИЛСАН НАМ
БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ХОРОО
0469916 ХНТ3946

## БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМЫН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Нийслэлийн Багахангай дүүрэг хэмээх их айлын эзэн танд хүнээ дээдэлсэн, үйлдвэрлэлийг дэмжсэн хөгжлийн бодлого санал болгон мэндчилж байна.

Ардчилсан нам Багахангай дүүрэгт 1990 оноос хойших 30 жилд анх удаа 2012-2016 онд 5 төлөөлөгчтэй болж нийтийн эрх ашгийг нэгдүгээрт тавьж ажилласан. Та бидний хамтдаа санаачилсан олон ажил амжилт авчирч байсныг Та бүхэн санаж байгаа гэдэгт итгэлтэй байна.

Багахангай дүүргийн иргэн бүрт хүрсэн өөрчлөлтийн төлөө эрхэм хүндэт Багахангайчууд та бүхэн гар бие оролцож, татвараа ч төлсөөр ирсэн. Энэ бүхэн бол та бидний хамтын зүтгэл байсан билээ.

Тэгвэл бид өнөөдөр дүүргээ хоноцын сэтгэлээр хандаж ирсэн одоогийн удирдлагуудыг эрс өөрчлөх тэр цаг мөч бидний өмнө тулж ирээд байна.

Дэлхий даяар өндөр хурдаар холбогдон, өнцөг булан бүрт нь минутын дотор хүрч чаддаг болсон, мэдээлэлжсэн эрин зуунд дэлхийн нийтийн хөгжлөөс хоцрох, хүрсэн амжилтаасаа ухрах цаг хугацаа дахиад бидэнд байхгүй ээ.

2020 он бол шинэ мянганы эхний, шилжилт өнгөрч байгаа, хөгжлийнхөө замд эргэлт буцалтгүй орох үе. Бид одоо дэлхийн хотуудтай эн зэрэгцэн хөгжиж, олон улсад өрсөлдөх чадвартай залуучууддаа илүү хөгжих боломжийг нь олгож, хүүхэд багачууд, ирээдүйдээ итгэлтэй, ахмад буурлуудаа аюулгүй амар тайван орчинд амьдардаг болгох хэрэгтэй байна. Бид Улаанбаатар хэмээх дэлхийн хотыг хөгжүүлэх эхлэл, өөрчлөлтийн төлөө нэгдэх цаг болжээ.

Бидний Багахангайчууддаа амлан, хэрэгжүүлж чадах зүйл бол "хөгжил дэвшил" байх болно. Багахангай дүүргийн Ардчилсан нам 2020-2024 онд дүүргээ "ажиллаж амьдрахад таатай" дүүрэг болгох хөтөлбөрөө танилцуулж байна.

Та бид нэгдож, "Хөгжил"-д хамтдаа хүрэх итгэл дүүрэн байна.

1117145635
УХА0512 9077278

АРДЧИЛСАН НАМ
БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ХОРОО
В488916 ХНТ3946

Ардчилсан нам нийслэлийг удирдсан 2012-2016, Багахангай дүүрэгт олон төлөөлөтэй болж дүүргийн Засаг даргын орлогчтой ажиллаж байсан жилүүдэд төр засаг нь иргэдээ сонсдог, иргэнд тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэдэг, Нийслэлийн төр захиргааны үйлчилгээг иргэндээ ойртуулж, иргэдээ сонсож орон нутгийн хөгжлийн санг нэмэгдүүлсэн, төрийн байгууллагуудыг шилэн данстай болгож иргэдэд нээлттэй болгосон, Нийтийн тээврийн салбарын цогц шинэчлэл, төрийн үйлчилгээний цахим үйлчилгээг нэвтрүүлсэн зэрэг томоохон өөрчлөлт шинэчлэлийг та бүхэнтэй хамтран эхлүүлсэн билээ. Бид энэ удаа Багахангайнхаа иргэдийн төлөө дүүргийн захиргааг хариуцлагатай, иргэдээ чирэгдүүлдэггүй болгох, иргэдээ ажилтай орлоготой болгох, агаар, хөрс, тоосжилт, орчны бохирдлыг цогцоор нь шийдвэрлэх гэр хорооллын дахин төлөвлөлт зэрэг томоохон өөрчлөлтийн төслүүдийг санал болгож байна.

**Хүүхэд багачуудад**

Бид хүүхдэд ээлтэй хотын стандартыг мөрдүүлж "нэгдүгээрт хүүхэд" гэх зарчмаар ажиллана. Хамран сурах тойрог буюу хүүхэд багачууд алхаад очих зайд цэцэрлэг, бага сургууль байгуулах ажлыг дахин үргэлжлүүлнэ. Хүүхдүүдийн боловсролын чанарт онцгой анхаарсан тусгай бодлого гарган ажиллана. Дүүрэгт хүүхэд залуучууд шинийг санаачлагч зохион бүтээгчдийн төв, "Хүүхэд хөгжлийн ордон" байгуулж хүүхэд бүрийн авьяас чадварын хөгжүүлэхэд онцгой анхаарна.

**Залуучуудад**

Бид залуучуудаа дэмжиж, сурч боловсрох, хөгжин дэвших орчин нөхцлийг бүрдүүлнэ. Гарааны бизнес эхлүүлж буй залууст хөрөнгө оруулалт татах төр, хувийн хэвшлийн түншлэл байгуулна. Залуус чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, нийтийн биеийн тамираар хичээллэх спортын, соёл урлагийн байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлнэ. Гэр бүлтэй залууст төлбөрийн чадвартаа тохирсон орон сууцтай болох хувилбаруудыг хэрэгжүүлнэ.

**Ахмад настнуудад**

Ахмадууд ажил амьдралын арвин туршлагаа хуваалцах, ажил хөдөлмөр хийх боломжийг нэмэгдүүлэх "Ахмадын ажлын байр" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Тэдний нийгмийн амьдралд идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх "Хоёр дахь залуу нас" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлнэ. "Ахмадын орон сууц" хөтөлбөрт хамруулна. Ахмадын асрамж сувиллын жишиг төв барина.

**Хөгжлийн бэрхшээлтэй (тусгай хэрэгцээт) иргэдэд**

Хөгжлийн бэрхшээлтэй(тусгай хэрэгцээт) иргэд нийгмийн амьдралд идэвхтэй оролцож ажиллаж амьдрах дэд бүтцийг бий болгож нийтийн тээвэр, албан газар, олон нийтийн үйлчилгээний газар, орон сууцанд стандарт тогтоож мөрдүүлнэ.

**Гэр бүлүүдэд**

Бид өрх бүрийг тогтмол ажилтай орлоготой болгох бодлогод анхааран ажиллана. Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны хувилбарт бодлогод гэр бүлүүдээ хамруулна. 2024 он гэхэд 100 өрхийг инженерийн шугам сүлжээнд шинээр холбосон байна. Орлогод нь нийцсэн төлбөр бүхий "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлж, Бид дүүргийн гэр хорооллын өрхүүдээ дулааны хэмнэлттэй орон сууцтай болох нөхцөлийг бүрдүүлнэ.

АРДЧИЛСАН НАМ
БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ХОРОО

## МӨРИЙН ХӨТӨЛБӨРӨӨС ОНЦЛОХ 15 АЖИЛ

1. Газар эзэмшил, ашиглалтын талаарх мэдээллийг нээлттэй цахим болгоно. Газар дагасан авилга хүнд суртлыг арилгана.

2. Дүүргийн газар авсан байгууллага, иргэдийг газраа зориулалтын дагуу ашиглах талаар байнга шаардлага зөвлөмж өгч ажилна.

3. Дүүргийн 2-р хороонд шинээр орон сууцны барилга барих чиглэлээр барилгын компани, МЗХНН Улаанбаатар төмөр замтай хамтран ажиллана.

4. Зөвшөөрлөөс бүртгэл рүү зарчим баримтлана. Олон шат дамжлага хүнд суртал бүхий зөвшөөрлийн системийг халж бизнес эрхлэхийг хүссэн хэн бүхэн бүртгүүлээд үйл ажиллагаагаа явуулж эхлэх боломжтой байх орчныг бий болгоно.

5. Гэр хорооллыг инженерийн дэд бүтэц /цэвэр ус, бохир ус ариутгах татуурга, интернэт шилэн кабель/-д холбож, халаалтын төвлөрсөн болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг дэмжих зорилгоор Сервис Центрүүдийг байгуулж иргэдийн амьдран суух байшингаа барихад нь урт хугацаатай, хүү багатай, орон сууцны ипотекийн зээлээр санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллана.

6. Орлогод нь нийцсэн төлбөр бүхий "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлж, 2024 он гэхэд 120 өрхийг түрээсийн орон сууцанд оруулсан байна. Нэн тэргүүнд залуу гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудыг дэмжих бодлого баримтлана.

7. "Бүхний түрүүнд явган зорчигч" зарчмыг хэрэгжүүлж, явган хүний гарц дээр явган зорчигчийг хүлээдэг соёлыг хэвшүүлнэ.

8. Нийтийн тээврийн үйлчилгээг Багахангай -Улаанбаатар чиглэлд стандартад нийцсэн такси үйлчилгээ болгон нэмэгдүүлнэ.

9. Гарааны бизнесийг дэмжих төвийг бий болгож тэдний оролцоотой сонгон шалгаруулалтыг явуулж ази тивд төдийгүй дэлхийд өрсөлдөхөд нь дэмжлэг үзүүлнэ.

10. "Жорлонгоо өөрчилье" төслийг дэмжин хэрэгжүүлж гэр хорооллын 300 айлын жорлонг шинэчилж, хөрсний бохирдлыг бууруулна.

11. Гэр хорооллын байшин дулаалах ажлыг эрчимтэй хэрэгжүүлнэ.

12. "Унадаг Дугуйтай Багахангай" хөтөлбөрийг хэрэгжүүлж, дугуйн хэрэглээг бүх талаар дэмжинэ. Хоёр хорооны дунд замд 5 км дугуйн зам барина.

13. "Хашаандаа сайхан амьдаръя" төсөл хэрэгжүүлж орчноо тохижуулж мод зүлэг тарьж суулгасан иргэдийг дэмжиж ажиллана.

14. Хөгжлийн бэрхшээлтэй (тусгай хэрэгцээт) иргэдийн нийгмийн амьдралд идэвхтэй оролцох дэд бүтцийг бий болгоход онцгойлон анхаарна.

15. Жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх санг жинхэнэ Жижиг Дунд Бизнес эрхлэгчдийн сан болгож олон нийтийн хяналт удирдлагад оруулна.

АРДЧИЛСАН НАМ
БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ХОРОО

## УХААЛАГ ЗАСАГЛАЛТАЙ БАГАХАНГАЙ

**Өнөөгийн нөхцөл байдал:**
Багахангай дүүрэг засаглалын хямралд орсон, үр ашиггүй засаглалтай байна. Хэт олон дарга, удирдах ажилтантай, боловч ажлын уялдаагүй, үйл ажиллагааны давхардал, хийдэл ихтэй, хариуцлага алдсан албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэдэггүй.

Иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээний санхүүжилт хэд дахин нэмэгдсэн ч иргэдэд хүрдэггүй, хугацаа тодорхой бус, албан тушаалтан хүнд суртал гаргаж иргэдийг чирэгдүүлдэг, мөн намаар ялгаварлан гадуурхдаг.

Иргэдээ сонсдоггүй, сонссон ч асуудлыг нь шийдвэрлэдэггүй, иргэдийн оролцооны эрх зүйн орчин тодорхойгүй, иргэдийн саналыг ямар асуудлаар, ямар цар хүрээнд авах талаар тогтсон дүрэмгүй. Бүх төрлийн үйлчилгээнд цахим технологийг ашигладаг болох, орчин үеийн шуудан харилцаа, хүргэлтийн системийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

**Бидний хийх ажлууд:**

Ажлын чиг үүрэг нь маш тодорхой, цомхон, мэргэшсэн ажлаа мэддэг төрийн албан хаагчидтай хотын захиргаатай болно. Хууль зөрчсөн, иргэдийг чирэгдүүлсэн албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэдэг болно. Иргэдэд үйлчлэх үйлчилгээнд орчин үеийн технологи нэвтрүүлэн, иргэдийн саналыг шийдвэр гаргалтанд тусгах журам мөрдүүлнэ.

**Дүүргийн удирдлагыг хариуцлагатай, шийдвэр гаргалтыг шуурхай, нээлттэй болгох чиглэлээр:**

- Нийтийн албан тушаалтнуудын гаргасан шийдвэр, үйл ажиллагаанд үнэлгээ хийж, хариуцлага алдсан албан тушаалтанд хариуцлага тооцдог болно.
- Дүүргийн удирдлагын шийдвэр гаргалтанд Мэргэжлийн холбоод, судалгааны байгууллагууд, иргэдийн сонирхлын бүлгүүдийн оролцоог хангана.
- Дүүргийн удирдлага улирал тутам үйл ажиллагааны тайлангаа олон нийтэд нээлттэй тавьдаг болно.

**Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүртээмжтэй болгох чиглэлээр:**

- Төрийн бүхий л үйлчилгээг иргэдэд ойртуулж дүүрэг, хорооноосоо авдаг болгоно.

- Газар эзэмшил, ашиглалтын талаарх мэдээллийг нээлттэй цахим болгоно. Газрын биржийн үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар газар дагасан авилга хүнд суртлыг арилгана.

- Төрийн үйлчилгээнд иргэдээс шаарддаг бичиг баримтыг цөөрүүлнэ. Төрд байгаа мэдээллийг иргэнээс нэхдэгийг болиулна.
- Дүүргийн төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ажлын гүйцэтгэлийг үнэлэх урамшууллын тогтолцоог боловсронгуй болгож хэрэгжүүлнэ.

1117145633
УХА0612 9077278

БАГАХАНГАЙ
ДҮҮРГИЙН
ХОРОО
0488916 ХНТ3946

**Иргэд, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр:**

- Иргэдийн оролцоог хангах эрхзүй, дүрэм журмыг боловсронгуй болгож, үр нөлөөтэй тогтолцоо бий болгоно.
- Дүүрийн иргэний баримтлах хэм хэмжээ, биеэ авч явах соёлын хэмжүүрийг тусгасан " Багахангай дүүргийн дүрэм"-тэй болно.
- Дүүрэг хөгжүүлэх, тохижуулах асуудлаар шийдвэр гаргахдаа иргэдийн санал үндэслэдэг болно.
- Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлэх асуудлын хүрээнд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын саналыг харгалзан үздэг болно.

## АЖИЛ ОРЛОГОТОЙ БАГАХАНГАЙ

**Бидний хийх ажлууд:**

*Бид дүүргээ эдийн засгийн томоохон төвүүдийн нэг, санхүүгийн чадавх сайтай, хөгжлийн зорилтуудаа санхүүжүүлэх хөрөнгө оруулалтаа өөрөө бий болгож, татаж чаддаг, бизнес эрхлэхэд таатай, иргэд нь тогтмол ажилтай орлоготой дүүрэг болгоно.*

**Бизнес эрхлэхэд таатай орчин бүрдүүлэх чиглэлээр:**

- Хувийн хэвшлийн хийх боломжтой ажлуудыг төр хийдэггүй байх зарчмыг баримталж, дүүргийн хэмжээнд хувийн хэвшлийг татвар, санхүүгийн оновчтой бодлогоор дэмжинэ.
- Нийслэл, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийг нээлттэй, олон нийтийн өмчит хэлбэрт оруулж, нэгтгэж, менежментийг эрс өөрчилнө.
- Дүүргийн харьяа байгууллагууд жижиг дунд, өрхийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлж, дүүрэгт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан авдаг зарчимд шилжинэ.
- Дүүргийн харьяа байгууллагууд Монголдоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан авдаг байх зарчимд шилжинэ.

## НЭЭЛТТЭЙ ТӨЛӨВЛӨЛТТЭЙ БАГАХАНГАЙ

**Бидний хийх ажлууд:**

*Бид дүүргийнхээ төлөвлөлтийг ил тод, нээлттэй болгож, нэн тэргүүнд хүүхдүүд, ахмадууд, тусгай хэрэгцээт хүмүүст ээлтэйгээр хэрэгжүүлэн, дүүргийн дэд бүтцийг шийдэж, явган алхах болон дугуйн замуудтай, амарч зугаалах таатай орчинтой дүүргийг байгуулна.*

**Дэд бүтэц, инженерчлэлийн чиглэлээр:**

- Гэр хорооллын иргэдэд төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны хангамжид холбогдсон амины орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлнэ.
- Сэргээгдэх эрчим хүч, байгаль орчинд ээлтэй дэд бүтцийн шийдлүүдийг хөнгөлөлттэй санхүүжилтээр дэмжинэ.
- Дүүргийн гудамж, байшингийн хаягжилтыг олон улсын жишигт нийцүүлж, хялбар чиглүүлэгчтэй болгоно.

АРДЧИЛСАН НАМ БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ХОРОО

- Сууц өмчлөгчдийн холбоодыг дэмжих, бэхжүүлэх, чадамжийг нь дээшлүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- Гэр хорооллын янданг цөөрүүлэх, утаа угаарыг багасгах бодлогыг дэмжин хувийн хэвшил, шинэ дэвшилтэт технологи, инновацын шинэ санааг дэмжинэ.
- Цахимаар газар өмчлөх ажлыг эрчимжүүлнэ.
- Цахимаар газар олгсон шинэ суурьшлын бүсийн байршилд инженер хангамжийн байгууламжуудыг үе шаттайгаар байгуулна.

## ЭКО БАГАХАНГАЙ

**Бидний хийх ажлууд:**

Бид Багахангай дүүрэгтэй хүрээлэн буй орчин, байгаль экологитойгоо нягт шүтэлцээтэй, мод, ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, ус, агаар, хөрсний бохирдлыг эрс бууруулж, нөөцийг хэмнэлттэй, ухаалаг зарцуулах тогтолцоонд шилжсэн тогтвортой хөгжилтэй дүүрэг байгуулна.

**Хүрээлэн буй орчныг хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр:**

- Дүүргийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хөрсний чанарыг сайжруулах зорилгоор гэр хорооллын айл бүрт хашаандаа мод тарих, хүлэмжийн аж ахуй эрхлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгоно.
- Дүүргийн бүсэд харшил үүсгэгч шарилж зэрэг нэр бүхий зэрлэг ургамлыг устгаж, иргэдийн эрүүл таатай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

**Нөөцийг тогтвортой ашиглах, хог хаягдлын менежентийг сайжруулах чиглэлээр:**

- Хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах тогтолцоог дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
- Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих, цахилгаан сүлжээн дэх нийлүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлнэ.
- Эрчим хүчний хэмнэлтийг дэмжих, хэрэглээг зүй зохистой удирдах зорилгоор ухаалаг сүлжээг нэвтрүүлнэ.

1117145633
УХА0612 9077278

АРДЧИЛСАН НАМ
БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ХОРОО
8488916 ХНТ2946

ЭЭЛТЭЙ БАГАХАНГАЙ

**Бидний хийх ажлууд:**

Бид дүүргээ иргэд нь сурч хөгжих, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ авах боломж бүрдсэн, спортлог, авьяаслаг иргэдтэй, урлаг, гоозүйн үнэт капиталыг хуримтлуулсан, өв соёлоо хойч үедээ өвлүүлсэн, иргэндээ ээлтэй дүүрэг болгоно.
Амьдрахад таатай, аюулгүй орчин бий болгох чиглэлээр:

- Онцгой байдал, гамшгийн менежментийн тогтолцоог боловсронгуй болгон хөгжүүлж шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана.
- Хүүхдэд ээлтэй дүүрэг болох цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ.
- "Хашаандаа сайхан амьдаръя" төсөл хэрэгжүүлж орчноо тохижуулж мод зүлэг тарьж суулгасан иргэдийг дэмжиж ажиллана.
- Цагдаагийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, "Миний Цагдаа намайг хамгаална" гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Зам тээврийн ослыг бууруулах зорилгоор нийтийн тээврийн жолоочдод тавигдах шаардлагыг олон улсын жишигт нийцүүлнэ.
- Хөршийн холбоо, олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааг идэвхжүүлэн дэмжиж , орчны аюулгүй байдлыг сайжруулна.

Эрүүл мэнд, боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд идэвхтэй оролцох дэд бүтцийг бий болгоход онцгойлон анхаарна.
- Эмч, багш нарын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулдаг индексийн урамшууллыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- ЕБС-ийн үндсэн хичээлээс гадна сурагчдын оюун ухааныг хөгжүүлэх, мэдээллийн технологийн орчин үеийн мэдлэг олгох зорилгоор хиймэл оюун ухааны, кодчлол, эд юмсын интернэт гэх мэт хичээл сургалтыг нэмэлтээр ордог болгоно.
- Хороо бүрт урьдчилсан сэргийлэх эмч ажиллуулж, иргэдийн эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, эрүүл мэнд, биеийн тамирын өрөө, талбайг тохижуулж спортоор хичээллэх боломжийг бий болгоно.
- Жирэмсэн эхчүүд, ахмад настны халамж, эмнэлгийн үйлчилгээг сайжруулах хөтөлбөр боловсруулна.

**Иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газар, соёл, урлагийн байгууламжуудыг хамгаалах чиглэлээр:**

- Соёлын өвийг хамгаалах төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж, хотын аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлнэ.
- Иргэдийн амрах, зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх цэцэрлэгт хүрээлэн, авто машины зогсоол, саравч, хүүхдийн тоглоомын талбай, боловсон бие засах газар бүхий цэгүүд байгуулна.
- Орчин үеийн "Соёл урлагийн ордон" байгуулах ажлыг дэмжиж ажиллана.

1117145633
УХА0612 5077278

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ХОРОО

**Бид дүүрэгтээ дараах бүтээн байгуулалтуудыг хийнэ:**

- Дүүрэгт усан спортын цогцолбор байгуулж, иргэдийн эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх, хамгаалах орчин бүрдүүлнэ.
- Дүүрэгт иргэдийн амрах, зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх цэцэрлэгт хүрээлэнг сайжруулж мах шарах саравч, хүүхдийн тоглоомын талбай, боловсон бие засах газар бүхий цэгүүд байгуулна.
- Байруудын урд авто машины зогсоол, ногоон байгууламж байгуулна.
- Шинэ суурьшлын бүсэд дэд бүтцийг барина.
- Худалдаа, үйлчилгээний төв байгуулна.
- Малчдын худагт байнгын эрчим хүчээр хангаж, автомат систем тавина.
- 2-р хорооны байруудыг гадна дулаалга хийнэ.
- Халаалтын уурын зуух шинээр барина.
- Махны үйлдвэрийг хувийн байгууллагуудтай хамтран шинээр байгуулна.

АРДЧИЛСАН НАМ
БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ХОРОО

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.07.08 № 1192

танай ____________-ны №____________-т

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
НАЛАЙХ ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН
НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Налайх дүүргийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, "Алсын хараа-2050", нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Налайх дүүргийн Ардчилсан намын Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн

37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Налайх дүүргийн ардчилсан намын мөрийн хөтөлбөр /13/ хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Налайх дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт: 13 хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР

**Налайх дүүргийн Ардчилсан Нам**

# НАЛАЙХ ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР 2020

АГУУЛГА

1. ИРГЭН ТӨВТЭЙ НАЛАЙХ

2. АЖИЛ ОРЛОГОТОЙ НАЛАЙХ

3. ЭРҮҮЛ НАЛАЙХ

4. ЭКО НАЛАЙХ

5. ЭЭЛТЭЙ НАЛАЙХ

Ардчилсан нам Налайх дүүргийг удирдсан 2012-2016 онд иргэдээ сонсдог, иргэнд тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэж, хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, Шинэ Налайх хороолол 6000 айлын орон сууцны мега төслийг эхлүүлж, 115км авто зам, нийтийн эзэмшлийн гудамж талбайд гэрэлтүүлэг, камержуулалт хийж гүйцэтгэв. Мөн шинээр 208, 154 дүгээр цэцэрлэгийг байгуулж, ногоон байгууламжуудын тоог нэмэгдүүлэв. 35-39 дүгээр байр, 40,41, 64-67 дундах талбайг засч хатуу хучилттай авто зогсоолуудыг шинээр барьж мөн байрнуудын гадна дулаан цэвэр, бохир усны шугамыг бүрэн сольж, подвалийн шугамыг шинэчилэв. Угсармал орон сууцнуудыг дулаалж, хүүхдийн тоглоомын талбайг хороодод шинээр барьж хүүхэд хөгжлийн төв, спорт цогцолбор, нийгмийн даатгалын хэлтэс, тартан зам бүхий гүйлтийн замын ажлыг эхлүүлсэн билээ.

Бид бүхэн энэ удаа иргэдээ ажилтай орлоготой, гэр хороолол болон дүүргийн 60-аас дээш жилийн насжилттай барилгуудыг дахин төлөвлөлтөнд оруулж, гэр хорооллыг инженерын шугамд холбох, түрээсийн орон сууц хөтөлбөрийг дүүрэгтэй хэрэгжлүүлэх, агаар, хөрс, тоосжилт, орчны бохирдлыг шийдвэрлэх зэрэг өөрчлөлтийн төслүүдийг санал болгож байна.

### Хүүхэд багачуудад

Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийг үргэлжлүүлнэ. Цэцэрлэгийн нэг ангид 30 хүүхдээс илүүгүй байх стандартыг мөрдүүлж цэцэрлэг хүрэлцээгүй байгаа хороодод хүрэлцээг нэмэгдүүлэхээр үргэлжлүүлэн ажиллана. Хүүхэд залуучууд шинийг санаачлагч зохион бүтээгчдийн төвийг байгуулж хүүхэд бүрийн авьяас чадварын хөгжүүлэхэд онцгой анхаарна.

### Залуучуудад

Бид залуучуудаа дэмжиж, сурч боловсрох, хөгжин дэвших орчин нөхцлийг бүрдүүлнэ. Гарааны бизнес эхлүүлж буй залууст хөрөнгө оруулалт татах төр, хувийн хэвшлийн түншлэл байгуулна. Залуус чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, нийтийн биеийн тамираар хичээллэх спортын, соёл урлагийн байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлнэ. Гэр бүлтэй залууст төлбөрийн чадвартаа тохирсон орон сууцтай болох хувилбаруудыг эхлүүлнэ. Ардчилсан намын мөрийн хөтөлбөрт тусгагдсан түмэн инженер хөтөлбөрийн хүрээнд гадаадын шилдэг 100 их сургуульд суралцах мөн дотоодын их дээд сургуульд суралцах, сургалтын төлбөрийн зээлд хамрагдах боломжоор тэгш хангана.

**Ахмад настнуудад**

Ахмадууд ажил амьдралын арвин туршлагаа хуваалцах, ажил хөдөлмөр хийх боломжийг нэмэгдүүлэх "Ахмадын ажлын байр" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Тэдний нийгмийн амьдралд идэвхитэй оролцоог нэмэгдүүлэх нийслэлтэй хамтран 'Хоёр дахь залуу нас" хөдөлгөөнийг өрнүүлнэ.

**Хөгжлийн бэрхшээлтэй (тусгай хэрэгцээт) иргэдэд**

Хөгжлийн бэрхшээлтэй(тусгай хэрэгцээт) иргэд нийгмийн амьдралд идэвхитэй оролцож ажиллаж амьдрах дэд бүтцийг бий болгож нийтийн тээвэр, албан газар, олон нийтийн үйлчилгээний газар, орон сууцанд стандарт тогтоож мөрдүүлнэ.

**Гэр бүлүүдэд**

Бид өрх бүрийг тогтмол ажилтай орлоготой болгох бодлогод анхааран ажиллана. Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны хувилбарт бодлогыг хэрэгжүүлж 2024 он гэхэд 2000 гаруй өрхийг шинээр орон сууцанд, 2024 он гэхэд 1000 гаруй өрхийг инженерийн шугам сүлжээнд шинээр холбох. Мөн орлогод нь нийцсэн төлбөр бүхий ''Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлж, 2024 он гэхэд 500 өрхийг түрээсийн орон сууцанд оруулхаар зорин ажиллах болно. Дүүргийн 6 дугаар хороонд нийслэлтэй хамтран "Тэрэлж" амралт зугаалгын бүс, "Морин аялалын цогцолбор" байгуулна. Өрх тутамд 1 ажлын байр буюу 1000 ажлын байр бий болгохоор ажиллана.

**УХААЛАГ ЗАСАГЛАЛТАЙ НАЛАЙХ**

**Өнөөгийн нөхцөл байдал:**

Иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээний санхүүжилт хэд дахин нэмэгдсэн ч иргэдэд хүрдэггүй, хугацаа тодорхой бус, албан тушаалтан хүнд суртал гаргаж иргэдийг чирэгдүүлдэг.

Иргэдээ сонсдоггүй, сонсон ч асуудлыг нь шийдвэрлэдэггүй, иргэдийн оролцооны эрх зүйн орчин тодорхойгүй, иргэдийн саналыг ямар асуудлаар, ямар цар хүрээнд авах талаар тогтсон дүрэмгүй. Бүх төрлийн үйлчилгээнд цахим технологийг



1117145833
УХА0612 9077278

ашигладаг болох, орчин үеийн шуудан харилцаа, хүргэлтийн системийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

**Бидний хийх ажлууд:**

*Ажлын чиг үүрэг нь маш тодорхой, цомхон, мэргэшсэн ажлаа мэддэг төрийн албан хаагчидтай захиргаатай болно. Хууль зөрчсөн, иргэдийг чирэгдүүлсэн албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэдэг болно. Иргэдэд үйлчлэх үйлчилгээнд орчин үеийн технологи нэвтрүүлэн, иргэдийн саналыг шийдвэр гаргалтанд тусгах журам мөрдүүлнэ.*

**Дүүргийн удирдлагыг хариуцлагатай, шийдвэр гаргалтыг шуурхай, нээлттэй болгох чиглэлээр:**

- ОНӨААТҮГ-уудыг үр ашигтай бүтцэд шилжүүлнэ. Үйл ажиллагааны давхардал, хийдлийг арилгана.
- Нийтийн албан тушаалтнуудын гаргасан шийдвэр, үйл ажиллагаанд үнэлгээ хийж, хариуцлага алдсан албан тушаалтанд хариуцлага тооцдог болно.
- Дүүргийн удирдлагын шийдвэр гаргалтанд мэргэжлийн холбоод, судалгааны байгууллагууд, иргэдийн сонирхлын бүлгүүдийн оролцоог хангана.
- Дүүргийн удирдлага улирал тутам үйл ажиллагааны тайлангаа олон нийтэд нээлттэй тавьдаг болно.
- Дүүргийн төсөв, орон нутгийн хөгжлүүлийн сангийн хөрөнгийг хуваарилахдаа урсгал зардлыг нэмэгдүүлэхэд бус, нэн тэргүүнд гэр хорооллыг дахин төлөвлөх, авто замын түгжрэл, агаар, хөрсны бохирдлыг бууруулах, дэд бүтцийг тэлэхэд чиглүүлнэ.

**Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүртээмжтэй болгох чиглэлээр:**

- Төрийн бүхий л үйлчилгээг иргэдэд ойртуулж хорсоноосоо авдаг болгоно.
- Газар эзэмшил, ашиглалтын талаарх мэдээллийг нээлттэй цахим болгоно. Газрын биржийн үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар газар дагасан авилга хүнд суртлыг арилгана.
- Дүүргийн төрийн үйлчилгээг иргэдэд цахимаар хүргэнэ.
- Төрийн үйлчилгээнд иргэдээс шаарддаг бичиг баримтыг цөөрүүлнэ. Төрд байгаа мэдээллийг иргэнээс нэхдэгийг болиулна.

АРДЧИЛСАН НАМ ХОРОО

1117143633
УУА0612 9077278

- Дүүргийн төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ажлын гүйцэтгэлийг үнэлэх урамшууллын тогтолцоог боловсронгуй болгож хэрэгжүүлнэ.

**Иргэд, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр:**

- Иргэдийн оролцоог хангах эрхзүй, дүрэм журмыг боловсронгуй болгож, үр нөлөөтэй тогтолцоо бий болгоно.
- Дүүрэг хөгжүүлэх, тохижуулах асуудлаар шийдвэр гаргахдаа иргэдийн санал үндэслэдэг болно.
- Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар шийдвэрлэх асуудлыг иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын саналыг харгалзан үздэг болно.
- Дүүргээс төрөл бүрийн зөвшөөрөл олгохдоо ашиг сонирхол нь зөрчигдөж болох иргэд, оршин суугчид, аж ахуйн нэгжүүдийн саналыг харгалздаг байх, шийдвэр гаргах явцад тэдний оролцоог нээлттэй хангах зарчмыг хатуу баримтална.

**Цахим технологийн ашиглалт, шуудангийн харилцааг хөгжүүлэх чиглэлээр:**

- Нийслэлтэй хамтран "Гэрээсээ бүгдийг" хөтөлбөр хэрэгжүүлж, хаягжилтыг цэгцлэн, шуудангийн үйлчилгээг иргэдийн өдөр тутмын салшгүй хэрэглээ болгон хөгжүүлж, цахим худалдааг дэмжих, төрийн олон үйлчилгээг цахимаар болон шуудангийн хүргэлтээр үзүүлдэг болох шат дараатай арга хэмжээнүүдийг авна.

- Мэдээллийн технологийн дэд бүтцийг өргөжүүлж, өргөн зурвасын, өндөр хурдны интернэт сүлжээг байгуулна. Ялангуяа гэр хорооллын бүсэд нэвтрүүлэхэд онцгойлон анхаарна.

- Инновацийн төвийг байгуулж шинэ технологийг улс, олон улсын зах зээлд гаргахад бодлогоор дэмжинэ.

## АЖИЛ ОРЛОГОТОЙ НАЛАЙХ

**Өнөөгийн нөхцөл байдал:**

Налайх дүүргийн иргэдийн өрхийн орлого амьжиргааны зардалтайгаа харьцуулахад бага, ажилгүйдэл их, гурван хүн тутмын нэг нь ядуу амьдарч байна.

АРДЧИЛСАН НАМ
НАЛАЙХ ДҮҮРГИЙН

1117146633
УХА0512 9077278

Ажилгүй иргэдийн тоо улам нэмэгдэж ажлын байр хумигдаж иргэд ирээдүйдээ итгэх итгэлгүй, архидалт, гэр бүлийн хүчирхийлэл,гэр бүл салалт нэмэгдсээр байна.

**Бидний хийх ажлууд:**

*Налайх дүүргээ санхүүгийн чадавх сайтай, хөгжлийн зорилтуудаа санхүүжүүлэх хөрөнгө оруулалтаа өөрөө бий болгож, татаж чаддаг, бизнес эрхлэхэд таатай, иргэд нь тогтмол ажилтай орлоготой дүүрэг болгоно.*

**Бизнес эрхлэхэд таатай орчин бүрдүүлэх чиглэлээр:**

- Хувийн хэвшлийн хийх боломжтой ажлуудыг төр хийдэггүй байх зарчмыг баримталж, дүүргийн хэмжээнд хувийн хэвшлийг татвар, санхүүгийн оновчтой бодлогоор дэмжинэ.
- Орон нутгийн өмчит газрууд жижиг дунд, өрхийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан авдаг зарчимд шилжинэ.
- Ажлын байр бий болгоход дорвитой хувь нэмэр оруулсан аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх тал дээр бодлогоор дэмжиж ажиллана.

**Эдийн засгийг тэлэх, ажлын байр бий болгох чиглэлээр:**

- Дүүрэг бүрт хөдөлмөр зуучлалын төв бий болгож, ажилгүй иргэдийг дүүргийн аж ахуйн нэгжүүдэд ажилд зуучилж, байршуулдаг тогтолцоог бий болгоно
- Оюутан залуучуудад цагийн ажил олгож, цаг, өдрөөр ажиллах ажлын байр бий болгосон аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжинэ.
- Жижиг дунд, өрхийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг борлуулах "Налайхад үйлдвэрлэв" худалдааны төвийг төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна.
- Залуусын гарааны бизнесийг дэмжих сан бий болгож тэдний оролцоотой сонгон шалгаруулалтыг явуулдаг нээлттэй төвийг иргэдийн оролцоотойгоор, иргэдийн хяналттай байгуулна.
- Тавиас дээш насныхан болон тэтгэврийн насныхныг ажлын байраар хангах "Хоёр дахь залуу нас" хөтөлбөр боловсруулна.
- "Ажилсаг оюутан" "Жуулчин цагдаа" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байр" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- Налайх дүүргийн өрх бүрийг үйлдвэрлэгч болгох ажлыг дүүргийн бодлого болгож дэмжиж ажиллана.



АРДЧИЛСАН НАМ ХОРОО 9488515 ХНТ0505
1117145633 УХА0612 9077279

- Налайх барилгын материал, үйлдвэр технологийн паркийн ажлыг үргэлжлүүлнэ.
- Ерөнхийлөгч Х.Баттулга АНУ-ын ерөнхийлөгч Д.Трампад Монгол улсаас оёмол сүлжмэл бүтээгдэхүүнийг татваргүй экспортлох хүсэлт тавьж улмаар АНУ-ын конгресс хүлээн авч хууль батласан. Энэхүү ажлын хүрээнд дүүрэгтэй оёмол,сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах, өргөжүүлэх ажлыг дүүргийн бодлого болгоно. Хороо бүрээс ажилгүй иргэдийг хамруулна.

**Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр:**

- Нийслэлтэй хамтран "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийг сэргээн өргөжүүлж, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх үүднээс "Бүргэдийн баяр", "Тэмээний баяр"-ыг дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт зохион байгуулна
- "Тэрэлж" амралт зугаалгын бүс, "Морин аялалын цогцолбор" байгуулна
- Нийслэлтэй хамтран дүүргийн 6 дугаар хороонд Олон улсын хурал зөвлөгөөн, үзэсгэлэн худалдаа, урлагийн наадам, соёлын арга хэмжээг зохион байгуулах жуулчдыг хүлээн авах төвийг байгуулна
- Дүүргийн дөрөв дүгээр хорооны 1 га газарт Казах иргэдийн өв соелоо сурталчилах соёлын төвийг байгуулна.
- Төр хувийн хэвшлийн түншлэлээр дэлхийн стандартад нийцсэн, аюулгүй, орчин үеийн тоглоом бүхий соёл амралтын хүрээлэн байгуулна.

## ЭКО НАЛАЙХ

**Өнөөгийн нөхцөл байдал**

Налайх дүүрэг ногоон байгууламж муутайгаас агаар, хөрс, орчны бохирдол, тоосжилт зэрэг олон сөрөг үр дагавар бий болж байгаа ч ногоон байгууламжийг нэмэгдүүлж мод тарьсан иргэдээ дэмжих эрх зүйн орчин байхгүй байна. Агаарын бохирдол гамшигийн хэмжээнд хүрээд байна. Дүүргийн гурав дугаар хороонд 200 га газар хөрсний нөхөөн сэргээлт хийхгүй бол гамшигийн хэмжээнд хүрсэн

*Ус, дулааны нөөцийг зохистой, тогтвортой ашиглах, алдагдлыг бууруулах тогтолцоо бүрдээгүй байна. Хог хаягдлын ачилт тээвэрлэлт хүрэлцээгүй, ангилан ялгалт хэвшээгүй, хог боловсруулах үйлдвэргүй, зам чиглэлийн менежмент бүхэлдээ үгүйлэгдсээр байна.*

1117146833
УХА0612 9877278

**Бидний хийх ажлууд:**

Налайх дүүргийн хүрээлэн буй орчин, байгаль экологитойгоо нягт уялдаатай, ой мод, ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, ус, агаар, хөрсний бохирдлыг эрс бууруулж, нөөцийг хэмнэлттэй, ухаалаг зарцуулах тогтолцоог бий болгоно.

**Хүрээлэн буй орчныг хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр:**

- Дүүргийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хөрсний чанарыг сайжруулах зорилгоор гэр хорооллын айл бүрт хашаандаа мод тарих, хүлэмжийн аж ахуй эрхлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгоно.
- Байгалийн болзошгүй гамшгийн тохиолдолд хариу үйлдэх, эргэн сэргэх чадавхийг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Төвийн бүсэд харшил үүсгэгч шарилж зэрэг хор бүхий зэрлэг ургамлыг устгаж, иргэдийн эрүүл таатай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.
- Дүүргийн 3 дугаар хорооны 200 га газарт байгалийн нөхөн сэргээлт хийнэ.
- Хогийг байгальд булдаг байдлыг зогсоож хогоо ангилж боловрсуулах үйлдвэрийн ажлыг судлаж эхлүүлнэ.

**Агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр:**

- Дүүрэгт агаарын бохирдлыг бууруулах зорилгоор "Өнтэй өвөлжье" төсөл хэрэгжүүлж, гэр хорооллын айлын дулаан алдагдалыг бууруулах санхүүгийн хөнгөлттэй нөхцөлтэй хөтөлбөр хэрэгжүүлнэ
- Гэр хорооллын янданг цөөрүүлэх зорилгоор орон сууцжуулах хөтөлбөрийг эрчимжүүлэн хэрэгжүүлж ипотекийн зээлийн олголтыг гэр хорооллоос орон сууцанд орж буй зорилтод бүлэгт нэмэгдүүлнэ.
- Гэр хорооллыг өвлийн цагт цахилгаанаар халаах чадвартай болгох үүднээс цахилгаан дамжуулах чадамжийг нэмэгдүүлж, эрсдэлгүй аюулгүй дэд бүтцээр хангана.
- "Жорлонгоо сэргээе" төслийг дэмжин хэрэгжүүлж гэр хорооллын 6000 мянган айлын жорлонг шинэчилж, хөрсний бохирдлыг эрс бууруулна.
- Хөрсний бохирдол гүний цэвэр усанд нэвчихээс сэргийлж, яаралтай саармагжуулах арга хэмжээ авна.

АРДЧИЛСАН НАМ
НАЛАЙХ ДҮҮРГИЙН ХОРОО

1117145633
УХА0612 9077278

**Нөөцийг тогтвортой ашиглах, хог хаягдлын менежентийг сайжруулах чиглэлээр:**

- Усыг дахин ашиглах "Саарал ус"-ны технологийг нэвтрүүлнэ
- Дулаан, усны дамжуулалтын алдагдлыг бууруулах зорилгоор газар доорх дундын хоолой, айл өрх бүрт ус, цахилгааны хэрэглээгээ (өдөр, сарын хэрэглээ, мөнгөн дүн г.м) хянах боломжийг олгох электрон дэлгэцтэй смарт метрийг суурилуулна
- Аюултай хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, саармагжуулах, устгах тогтолцоог бий болгоно.
- Орон сууцны хороолол дунд хог хаягдлыг ангилан байршуулах хэвшлийг нэмэгдүүлнэ. Иргэд дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж тушаасанаар зарим үйлчилгээг (нийтийн тээвэр г.м) үнэ төлбөргүй авах хөшүүргийг нэвтрүүлнэ.
- Хог хаягдлыг дахин боловсруулах, аж ахуйн нэгжүүд өөрсдийн гаргаж буй сав, баглаа, боодлыг татан авч, дахин ашиглах тогтолцоог дэмжих бодлого хэрэгжүүлнэ
- Хөрсний усны эрсдлийг 90 хувь хүртэл бууруулна. Био цөөрөм, хөв цөөрөм байгуулах зэргээр олон улсын технологийг судлан эрдэмтэдтэй хамтран төсөл хэрэгжүүлнэ
- Эрчим хүчний хэмнэлтийг дэмжих, хэрэглээг зүй зохистой удирдах зорилгоор ухаалаг сүлжээ нэвтрүүлнэ.

## ЭЭЛТЭЙ НАЛАЙХ

### Өнөөгийн нөхцөл байдал

Налайх дүүрэгт гэмт хэргийн тоо буурахгүй байна. Хүүхэд хүчирхийлэлд өртөх, зам тээврийн осолд орох, цаг бусаар хорвоог орхих үзэгдэл улам нэмэгдэж байна. Соёл урлаг, спортын өндөр амжилт гаргаж буй авьяаслаг иргэдээ дорвитой дэмжиж чадахгүй байна. Иргэд амарч тухлах цэцэрлэгт хүрээлэнгийн хаалга цоожтой хэвээр байна.

### Бидний хийх ажлууд:

*Иргэд нь сурч хөгжих, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ авах боломж бүрдсэн, спортлог, авьяаслаг иргэдтэй, урлаг, соёлын үнэт капиталыг хуримтлуулсан, өв соёлоо хойч үедээ өвлүүлсэн, иргэндээ ээлтэй дүүрэг болсоно.*

**Амьдрахад таатай, аюулгүй орчин бий болгох чиглэлээр:**



АРДЧИЛСАН НАМ
ХОРОО
1117146633
9077278

- Цахилгааны хүрэлцээгүй айл өрхүүдэд стандартад нийцсэн аюулгүй шугамаар хангах ажлыг зохион байгуулна.
- Агаар дахь хорт хийн хэмжээг эрүүл ахуйн шаардлага стандартын хэмжээнд хүртэл багасгаж, халаалтын шинэ технологийг дэмжин агаарын бохирдолгүй болгохоор зорин ажиллана
- Хүүхдийн тоглоом, ахмадын амрах, нийрэгжүүлэх талбайг шинээр хороо бүрд байгуулна.
- Хүүхэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ
- Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцнуудыг буулгаж, шинээр барих дахин төлөвлөлтийн ажлыг иргэдийн саналд тулгуурлан зохион байгуулна.
- Дүүргийн төвийн газар эзэмшиж буй аж ахуйн нэгж, иргэдэд хотын стандартын дагуу тохижилт хийх, ногоон байгууламж байгуулах, иргэдийн зорчих боломжийг хангах шаардлага тавьж, хэрэгжүүлнэ.
- Ногоон байгууламж, амралт зугаалгын бүс, парк байгуулах гэх мэт эко бизнес эрхлэгчдийг бодлогоор дэмжиж ажиллана.
- "Хашаандаа сайхан амьдаръя" төсөл хэрэгжүүлж орчноо тохижуулж мод зүлэг тарьж суулгасан иргэдэд урамшуулдаг тогтолцоог бий болгоно.
- Дүүргийн гэр хорооллын болон төвийн гудамжуудыг бүрэн камержуулах, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх замаар гэмт хэргийн гаралтыг бууруулж, хяналтыг сайжруулна
- Цагдаагийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, "Миний Цагдаа намайг хамгаална" гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Гэр хорооллын зорчих хөдөлгөөн ихтэй гудамж талбайд авто зогсоол, хатуу хучилттай зам тавина.
- Хүнсний аюулгүй байдлыг хангах үүднээс 5 дугаар хороо орчмын газарт агро паркийг байгуулж органик хөдөө аж ахуй эрхлэгчдэд сертификат олгож, хоол хүнсний нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгоно.
- Зам тээврийн ослыг бууруулах зорилгоор нийтийн тээврийн жолоочдод тавигдах шаардлагыг олон улсын жишигт нийцүүлнэ.
- Хөршийн холбоо, олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааг идэвхжүүлэн дэмжиж , орчны аюулгүй байдлыг сайжруулна.
- Хороо бүрд халуун ус, ахуй үйлчилгээний газрыг байгуулах
- Цахим ухаалаг худаг байгуулах
- Олон улсын стандартад нийцсэн хогийн цэгүүдийг байгуулах
- Орлогод нь нийцсэн төлбөр бүхий "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлж, 2024 он гэхэд 500 өрхийг түрээсийн орон сууцанд оруулсан байхаар зорьж ажиллана. Нэн тэргүүнд залуу гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудыг дэмжих бодлого баримтлана. Гэр хорооллын 5

АРДЧИЛСАН НАМ
НАЛАЙХ ДҮҮРГИЙН



1117145633
УХА0512 9077278

байршилд орон сууцжуулах төслүүдийг боловсруулж иргэдээ орон сууцанд оруулна.

- Өндөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээг дахин эхлүүлж бодлогоор дэмжиж ажиллана.
- Шинэ Налайх хороолол 6000 айлын орон сууц хөтөлбөрийг үргэлжлүүлнэ
- БОАЖЯ, Горхи тэрэлжийн байгалийн цогцолбор газартай зөвшилцөж Налайх дүүргийн 6 дугаар хорооны иргэдийн амьдарч буй газрыг эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна.
- Дулааны цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлж өргөтөл хийхэд дэмжиж ажиллана.
- Шинээр суурьшлын бүсүүдийг судлаж урьдчилан дэд бүтцүүдээр хангах

## ЭРҮҮЛ НАЛАЙХ

**Эрүүл мэнд, боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр:**

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд идэвхитэй оролцох дэд бүтцийг бий болгоход онцгойлон анхаарна.
- Эрүүл мэндийн байгууллагын хүртээмжийг стандартын шаардлагад нийцүүлэн сайжруулж, эмнэлэгийн орны тоог нэмэгдүүлнэ
- Бага насны хүүхэд 500 метрийн радиус дотор цэцэрлэг, сургуульдаа хүрэх боломжтойгоор хотын ерөнхий төлөвлөгөөнд тусгасны дагуу цэцэрлэг сургуулийг нэмж хүртээмжийг жигд болгох бодлогыг баримтлана.
- Эмч, багш нарын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулдаг индексын урамшууллыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- Алслагдсан сургуулиудад автобус ажиллуулж, хүүхдийн сургуульдаа аюулгүй ирж, очих нөхцлийг бүрдүүлнэ.
- ЕБС-ын үндсэн хичээлээс гадна сурагчдын оюун ухааныг хөгжүүлэх, мэдээллийн технологийн орчин үеийн мэдлэг олгох зорилгоор хиймэл оюун ухааны, кодчлол, эд юмсын интернэт гэх мэт хичээл сургалтыг нэмэлтээр заадаг болгоно
- Хороо бүрт урьдчилан сэргийлэх эмч ажиллуулж, иргэдийн эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, эрүүл мэнд, биеийн тамирын өрөө, талбайг тохижуулж, спортоор хичээллэх боломжийг бий болгоно.
- Хороо бүрт тоноглогдсон биеийн тамирын талбай бий болгоно.
- Сургуулийн эргүүл теслийг үргэлжлүүлэн дэмжиж, сурагч хүүхдүүд сургуульдаа ирэх, гэрлүүгээ буцах замдаа халдлагад өртөхгүй аюулгүй байх үүднээс ухаалаг мэдээлэгчтэй сурагчийн үнэмлэхийг нэвтрүүлж, сургуулийн

ойр орчим, автобусны буудалд долгион дамжуулагч суурилуулна. Ингэснээр сурагчдын байршил, аюуч=лд өртөж буй эсэх мэдээлэл нь аав ээжийх нь гар утсанд ирдэг болно.

- Дүүргийн номын санг өргөжлүүлж тусгай байртай болгохоос гадна гэр хороололд олон нийтийн номын сангуудыг байгуулна.
- "Англи хэлтэй Налайхын залуус" хөтөлбөрийг ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, оюутан залуусын дунд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

**Иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газар, соёл, урлагийн байгууламжуудыг хамгаалах чиглэлээр:**

- Орчин үеийн Соёл урлагийн ордон байгуулах ажлыг судлана.
- Спортын байгууламж, заал талбайг спортын төрөл төрлөөр олшруулж, менежментийг нь спортын холбоод, клубуудад хариуцуулан хамтарч ажиллах, клубуудыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
- Газрын нэгдсэн үзлэг зохион байгуулж, ашиглалт, эзэмшлийн зөрчилтэй газруудыг эргүүлэн авч, нийтийн зориулалттай ногоон байгууламж болгоно.
- Зуслангийн газрыг өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.
- Заан-Тэрэлжийг аялал жуулчлал, амралт, зугаалгын бүс болгон тохижуулна.
- Дүүргийн нутаг дэвсгэрт Монгол морины соёлыг дэлгэрүүлж, морь сургах, морин тойруулга, морин аялалын цогцолбор байгуулахыг бодлогоор дэмжинэ.
- Олон улсын чанар стандартад нийцсэн, орчин үеийн тоглоом бүхий соёл амралтын хүрээлэн байгуулна.

Мэдээллийг бэлтгэсэн НАЛАЙХ ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМ (НДАН) - ыг төлөөлж

(тамга тэмдэг)

НДАН-ын дарга
М.Дашхүү (99195866)

ХЭГ-ын дарга
О.Ганболд (96051241)

НХ-ны гишүүн
Г.Мөнхзаяа (90071020)

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.07.09 № 1213

Танай ____________ -ны № ____________ -т

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ НИЙСЛЭЛИЙН АРДЧИЛСАН НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Нийслэлийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, "Алсын хараа-2050", нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Нийслэлийн Ардчилсан намын нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-

2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Нийслэлийн Ардчилсан намын мөрийн хөтөлбөр /13 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Нийслэлийн сонгуулийн хороонд

Хавсралт: 13 хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР

**НИЙСЛЭЛИЙН АРДЧИЛСАН НАМ**

# СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

**Хаяг:**
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8-р хороо, Амарын гудамж-4
Интер оффис 4 давхар -401

**Утас:** 11 32 12 04

И-мэйл: contact@citydemparty.mn

АРДЧИЛСАН НАМ

НИЙСЛЭЛИЙН
АРДЧИЛСАН НАМ

# 1. УХААЛАГ ЗАСАГЛАЛТАЙ УЛААНБААТАР

**Өнөөгийн нөхцөл байдал:**

Улаанбаатар хот засаглалын хямралд орсон, дэлхийн хотуудтай харьцуулахад хамгийн үр ашиггүй засаглалтай байна. Хэт олон дарга, удирдах ажилтантай, боловч ажлын уялдаагүй, үйл ажиллагааны давхардал, хийдэл ихтэй, хариуцлага алдсан албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэдэггүй

Иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээний санхүүжилт хэд дахин нэмэгдсэн ч иргэдэд хүрдэггүй, хугацаа тодорхой бус, албан тушаалтан хүнд суртал гаргаж, иргэдийг чирэгдүүлдэг.

Иргэдээ сонсдоггүй, сонссон ч асуудлыг нь шийдвэрлэдэггүй, иргэдийн оролцооны эрх зүйн орчин тодорхойгүй, иргэдийн саналыг ямар асуудлаар, ямар цар хүрээнд авах талаар тогтсон дүрэмгүй. Бүх төрлийн үйлчилгээнд цахим технологийг ашигладаг болох, орчин үеийн шуурхай харилцаа, хүргэлтийн системийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

**Бидний хийх ажлууд:**

*Ажлын чиг үүрэг нь маш тодорхой, цомхон, мэргэшсэн ажлаа мэддэг төрийн албан хаагчидтай хотын захиргаатай болно. Хууль зөрчсөн, иргэдийг чирэгдүүлсэн албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэдэг болно. Иргэдэд үйлчлэх үйлчилгээнд орчин үеийн технологи нэвтрүүлэн, иргэдийн саналыг шийдвэр гаргалтад тусгах журам мөрдүүлнэ.*

**1.1 Хотын удирдлагыг хариуцлагатай, шийдвэр гаргалтыг шуурхай, нээлттэй болгох чиглэлээр:**

1. Нийслэлийн харьяа байгууллагуудыг цомхон болгож, үр ашигтай бүтцэд шилжүүлнэ. Үйл ажиллагааны давхардал хийдлийг арилгана.
2. Улаанбаатар хотын менежментийг гадаадын тэргүүлэх хотуудын түвшинд хүргэж, гүйцэтгэл, бүтээмжийг эрс нэмэгдүүлнэ.
3. Нийтийн албан тушаалтнуудын гаргасан шийдвэр, үйл ажиллагаанд үнэлгээ хийж, хариуцлага алдсан албан тушаалтанд хариуцлага тооцдог болно.
4. Хот төлөвлөлт, удирдлагыг боловсронгуй болгох шинжлэх ухааны судалгааны тинк танк төв байгуулах талаар тооцоо, судалгаа гаргаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
5. Нийслэлийн удирдлагын шийдвэр гаргалтад мэргэжлийн холбоод, судалгааны байгууллагууд, иргэдийн сонирхлын бүлгүүдийн оролцоог хангана.
6. Нийслэлийн удирдлага улирал тутам үйл ажиллагааны тайлангаа олон нийтэд нээлттэй тавьдаг болно.
7. Нийслэлийн төсвийг хуваарилахдаа урсгал зардлыг нэмэгдүүлэхэд бус, нэн тэргүүнд гэр хорооллыг дахин төлөвлөх, авто замын түгжрэл, агаар, хөрсний бохирдлыг бууруулах, дэд бүтцийг тэлэхэд чиглүүлнэ.

**1.2 Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүртээмжтэй болгох чиглэлээр:**

1. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиудыг шинэчлэн батлуулж хот, тосгон бие даан хөгжих эдийн засаг эрх зүйн орчныг бий болгоно.
2. Төрийн бүх үйлчилгээг иргэдэд ойртуулж дүүрэг, хорооноосоо авдаг болгоно.
3. Хотын захирагчийг иргэд нь шууд сонгож, хариуцлага хүлээлгэдэг эрх зүйн орчныг боловсронгуй болгож хэрэгжүүлнэ.
4. Нийслэлийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хяналтын хувьцааг IPO хийх замаар олон нийтийн өмчийн оролцоотой болгож, удирдлага менежментийг сайжруулж компанийн сайн засаглалыг хөгжүүлж, үр ашгийг нэмэгдүүлнэ.

1117145633
УХА0612 9077273

НИЙСЛЭЛИЙН
ХОРОО



Л. Ө

5. Газар эзэмшил, ашиглалтын талаарх мэдээллийг нээлттэй цахим болгоно. Газрын биржийн үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар газар дагасан авлига хүнд суртлыг арилгана.
6. Нийслэлийн төрийн үйлчилгээг иргэдэд цахимаар хүргэж, 2024 он гэхэд 59 төрлийн 536 үйлчилгээг багцлан 100 үйлчилгээг онлайнаар үзүүлнэ.
7. Төрийн үйлчилгээнд иргэдээс шаарддаг бичиг баримтыг цөөрүүлнэ. Төрд байгаа мэдээллийг иргэнээс нэхдэгийг болиулна.
8. Нийслэлийн шуурхай удирдлагын нэгдсэн төвийн үйл ажиллагааг Хиймэл оюун ухаан, Их өгөгдөл гэх мэт дэвшилтэд технологийн тусламжтайгаар сайжруулж, замын түгжрэл, гэрэлтүүлэг, гэрлэн дохио, цахилгаан, дулааны хангамж, гомт хорог зэргийг хянаж, шуурхай зохицуулдаг нэг цэгийн ухаалаг удирдлагатай болгох талаар судалгаа, тооцоог хийж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
9. Нийслэлийн төрийн албан хаагчдын ажлын харилцлагыг нэмэгдүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ажлын гүйцэтгэлийг үнэлэх урамшууллын тогтолцоог боловсронгуй болгож хэрэгжүүлнэ.
10. Жишиг цогцолбор хорооны төвүүдийг шинээр барих талаар судалгаа тооцоог хийж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. Ингэснээр дэлхийн бусад хотуудад байдаг коммунити центрийн загвараар иргэд төрийн үйлчилгээ, спорт заал, хурал уулзалтын танхим, хүүхдийн өдөр өнжүүлэх, төрөл бүрийн дугуйлан, эмнэлгийн үйлчилгээ бүхий цогцолбор үйлчилгээг авдаг болно.

**1.3 Иргэд, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр:**

1. Иргэдийн оролцоог хангах эрхзүй, дүрэм журмыг боловсронгуй болгож, үр нөлөөтэй тогтолцоо бий болгоно.
2. Хотын хөгжилд оруулах иргэдийн санал, хүсэлт, санаачилгыг бүртгэх, хүлээн авах, бодлогод тусгах нэгдсэн цахим платформ бий болгоно.
3. Нийслэл хотын иргэний баримтлах хэм хэмжээ, биеэ авч явах соёлын хэмжүүрийг тусгасан " Улаанбаатар хотын дүрэм"-тэй болно.
4. Хот хөгжүүлэх, тохижуулах асуудлаар шийдвэр гаргахдаа иргэдийн саналд үндэслэдэг болно.
5. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар шийдвэрлэх асуудлын хүрээнд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын саналыг харгалзан үздэг болно.
6. Нийслэлээс төрөл бүрийн зөвшөөрөл олгохдоо ашиг сонирхол нь зөрчигдөж болох иргэд, оршин суугчид, аж ахуйн нэгжүүдийн саналыг харгалздаг байх, шийдвэр гаргах явцад тэдний оролцоог нээлттэй хангах зарчмыг хатуу баримтална.

**1.4 Цахим технологийн ашиглалт, шуудангийн харилцааг хөгжүүлэх чиглэлээр:**

1. "Гэрээсээ бүгдийг" хөтөлбөр хэрэгжүүлж, хаягжилтыг цэгцлэн, шуудангийн үйлчилгээг иргэдийн өдөр тутмын салшгүй хэрэглээ болгон хөгжүүлж, цахим худалдааг дэмжих, төрийн олон үйлчилгээг цахимаар болон шуудангийн хүргэлтээр үзүүлдэг болох шат дараатай арга хэмжээнүүдийг авна.
2. Нийслэлийн мэдээллийн технологийн дэд бүтцийг өргөжүүлж, өргөн зурвасын, өндөр хурдны интернет сүлжээг байгуулж, нийслэлийн интернет хэрэглэгчдийн тоог 850.0 мянгад хүргэнэ. Ялангуяа гэр хорооллын бүсэд нэвтрүүлэхэд онцгойлон анхаарна.

1117145633
УХА00129077278

АРДЧИЛСАН НАМ
НИЙСЛЭЛИЙН ХОРОО

## 2. АЖИЛ ОРЛОГОТОЙ УЛААНБААТАР

**Өнөөгийн нөхцөл байдал:**

Улаанбаатар хот эдийн засаг, санхүүгийн чадавхаа өөрөө бий болгох, хөрөнгө оруулалт, санхүүжилтийг татах, хөгжлийн зорилтуудаа санхүүжүүлэх тал дээр эрхзүйн хязгаарлалтуудтай тулгардаг.

Монгол Улсын аж ахуйн нэгжүүдийн 90% нь нийслэлд байрладаг ч бизнес эрхлэх орчны хувьд ээлгүй, нийслэл, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа ойлгомжгүй, төр, бизнес хоёр хамтрагч биш, өрсөлдөгч болсон байна.

Улаанбаатар хотын иргэдийн өрхийн орлого амьжиргааны зардалтайгаа харьцуулахад бага, ажилгүйдэл их, гурван хүн тутмын нэг нь ядуу амьдарч байна.

**Бидний хийх ажлууд:**

*Бид Улаанбаатар хотоо Зүүн Хойд Азийн бүсийн эдийн засгийн томоохон төвүүдийн нэг, санхүүгийн чадавх сайтай, хөгжлийн зорилтуудаа санхүүжүүлэх хөрөнгө оруулалтаа өөрөө бий болгож, татаж чаддаг, бизнес эрхлэхэд таатай, иргэд нь тогтмол ажилтай орлоготой хот болгоно.*

**2.1 Нийслэл хотын хөрөнгө оруулалт, санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр:**

1. Нийслэл хотын бонд гаргах эрхзүйн орчныг бий болгож, санхүүжилт татаж, хөгжлийн томоохон төслүүдийг санхүүжүүлнэ.
2. Улаанбаатар Бизнес Хөгжлийн Корпорацаар дамжуулан төр хувийн хэвшлийн түншлэлийг гүнзгийрүүлж, томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
3. Нийслэлд байрладаг экспортод чиглэсэн бизнесүүдэд эрхзүйн хувьд зөвшөөрөгдсөн боломжоотой дэмжлэгүүдийг үзүүлнэ.

**2.2 Бизнес эрхлэхэд таатай орчин бүрдүүлэх чиглэлээр:**

1. Зөвшөөрлөөс бүртгэл рүү зарчим баримтална. Олон шат дамжлага хүнд суртал бүхий зөвшөөрлийн системийг халж, бизнес эрхлэхийг хүссэн хүн бүхэн бүртгүүлээд үйл ажиллагаагаа явуулж эхлэх боломжтой байх орчныг бий болгоно.
2. Бизнес эрхлэх орчны олон улсын үнэлгээ, шалгаруулалтад (Doing business гэх мэт) Улаанбаатар хотын зэрэглэлийг дээшлүүлнэ.
3. Хувийн хэвшлийн хийх боломжтой ажлуудыг төр хийдэггүй байх зарчмыг баримталж, нийслэлийн хэмжээнд хувийн хэвшлийг татвар, санхүүгийн оновчтой бодлогоор дэмжинэ.
4. Нийслэлийн өмчит аж ахуйн нэгжүүдийг нээлттэй, олон нийтийн өмчит хэлбэрт оруулж, компанийн засаглал, менежментийг эрс өөрчилнө.
5. Нийслэлийн харьяа байгууллагууд жижиг дунд, өрхийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлж, нийслэлд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан авдаг зарчимд шилжинэ.
6. Нийслэлийн жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх санг жинхэнэ Жижиг Дунд Бизнес эрхлэгчдийн сан болгож, олон нийтийн хяналттай болгоно.
7. Алслагдсан дүүрэг, хот тосгодод аж ахуй эрхлэх байдлыг дэмжихийн зэрэгцээ ажлын байр бий болгоход дорвитой хувь нэмэр оруулсан аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлнэ.
8. Нийслэлийн харьяа байгууллагууд Монголдоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авдаг байх зарчимд шилжинэ.

1117145633
УХА0612 9077278

АРДЧИЛСАН НАМ
НИЙСЛЭЛИЙН ХОРОО

**2.3 Эдийн засгийг тэлэх, ажлын байр бий болгох чиглэлээр:**

1. Дүүрэг бүрд хөдөлмөр зуучлалын төв бий болгож, ажилгүй иргэдийг дүүргийн аж ахуйн нэгжүүдэд ажилд зуучилж, байршуулдаг тогтолцоог бий болгоно.
2. Оюутан залуучуудад цагийн ажил олгож, цаг, өдрөөр ажиллах ажлын байр бий болгосон аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжинэ.
3. Жижиг дунд, өрхийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг борлуулах "Улаанбаатарт үйлдвэрлэв" сүлжээ худалдааны төвүүдийг бий болгоно.
4. Залуусын гарааны бизнесийг дэмжих сан бий болгож, тэдний оролцоотой сонгон шалгаруулалтыг явуулж ази тивд төдийгүй дэлхийд өрсөлдөхөд нь дэмжлэг үзүүлэх төв байгуулна.
5. Тавиас дээш насныхан болон тэтгэврийн насныхныг ажлын байраар хангах "Хоёр дахь залуу нас" хөтөлбөр боловсруулна.
6. "Ажилсаг оюутан", "Жуулчин цагдаа" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
7. "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байр" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

**2.4 Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр:**

1. Улаанбаатар хотыг олон улсад таниулах "Дэлхийн хот Улаанбаатар" төслийг хэрэгжүүлнэ.
2. Нийслэлд олон улсын томоохон хурал, форум үзэсгэлэн, спортын төрөл бүрийн арга хэмжээг (MICE Tourism-Meeting,Incentives,Conferences, Exhibition) жилд 1-2 удаа зохион байгуулах замаар аялал жуулчлалыг нэмэгдүүлэх бодлого барина.
3. Гадаадын жуулчдад зориулсан дижитал үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, Улаанбаатар хотын аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг олон хэлээр хүргэдэг болно.
4. Гадаадын жуулчдад зориулсан аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгож, аюулгүй байдлыг хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
5. Хөшигтийн хөндийн олон улсын нисэх буудал – Улаанбаатар хотын төвийг холбосон экспресс (буухиа) автобусны үйлчилгээг бий болгоно.
6. "Монгол Наадам Цогцолбор"-ыг өргөжүүлж хөгжүүлнэ.
7. Гадаадын жуулчдад зориулсан мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, Улаанбаатар хотын аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг олон хэлээр хүргэдэг болно.
8. "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийг сэргээн өргөжүүлж, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх үүднээс "Бүргэдийн баяр", "Тэмээний баяр"-ыг зохион байгуулна.
9. Олон улсын хурал зөвлөгөөн, үзэсгэлэн худалдаа, урлагийн наадам, соёлын арга хэмжээг зохион байгуулах, жуулчдыг хүлээн авах төвийг байгуулна.

## 3. НЭЭЛТТЭЙ ТӨЛӨВЛӨЛТТЭЙ УЛААНБААТАР

**Өнөөгийн нөхцөл байдал**

Улаанбаатар хот төлөвлөлттэй ч, ил тод биш. Олон нийт төлөвлөлтийг нь мэддэггүй учир хянаж чаддаггүй. Хотын захиргаа ч төлөвлөлтөө мөрддөггүй. Үүний үр дүнд хүүхдүүдийн тоглох талбай, азай буурлуудын нарлах орон зайг булаан "бетонон ширэнгэ" маягийн барилгуудыг барьсаар байна.

Нийслэл хот инженерийн дэд бүтцийн хүрэлцээнээс болж, олон төвт хот болон хөгжиж чадаагүй. Дагуул, хаяа хот, дэд төвүүдийг хөгжүүлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэх менежмент муу хэт удаашралтай.

Хотын хөдөлгөөний урсгал нэн удааширсан. Явган болон унадаг дугуйгаар аюулгүй, ая тухтай зорчих дэд бүтэц баригдаагүй. Нийтийн тээвэр, такси үйлчилгээ зэргийг цогцоор хөгжүүлээгүйгээс болж авто хөдөлгөөний түгжрэл сүүлийн жилүүдэд эрс нэмэгдсэн. Хот төлөвлөлт, авто замын дэд бүтэц, тээврийн бодлогууд уялдаагүй.

**Бидний хийх ажлууд:**

*Бид Улаанбаатар хотынхоо төлөвлөлтийг ил тод, нээлттэй болгож, нэн тэргүүнд хүүхдүүд, ахмадууд, тусгай хэрэгцээт хүмүүст ээлтэйгээр хэрэгжүүлэн, хотын дэд бүтцийг тэлж, олон төвт хот болгон, нийтийн тээврийг олон улсын жишигт хүргэж, явган алхах болон дугуйн замуудтай, амарч зугаалах таатай орчинтой хотыг байгуулна.*

**3.1 Хот төлөвлөлт, бүсчилсэн хөгжлийн чиглэлээр:**

1. Хот төлөвлөлтийг ил тод, нээлттэй болгож, олон нийтийн хяналттай хэрэгжүүлнэ.
2. Хот төлөвлөлтийг иж бүрэн цогцоор нь төлөвлөж, гамшиг эрсдэлд тэсвэртэй байх менежментийг хэрэгжүүлнэ.
3. Батлагдсан ерөнхий төлөвлөгөө хэрэгжилтийг хариуцлагажуулна.
4. Бие даасан үзэл баримтлал бүхий дагуул хот, тосгодыг хөгжүүлэх замаар төвлөрлийг сааруулна.
5. Хотын хэт төвлөрлийг задалж, хөгжлийн 1 төвөөс олон төвт тогтолцоонд шилжүүлж, дэд төвүүдийг үргэлжлүүлэн барьж байгуулна. Хотын бүтэц зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор бүсийн хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнүүдийг баталж хэрэгжүүлнэ.
6. Нийслэлийн хөгжлийн шинэ төвүүдийг үе шаттайгаар шинээр байгуулах замаар төвийн нягтралыг бууруулах, иргэдийн ая тухтай амьдрах орчинг бүрдүүлнэ.
7. Орон нутаг, нийслэл, дагуул болон засаг захиргааны шинэ хотыг байгуулж, хөгжүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
8. "Майдар сити", "Аэро Сити" зэрэг дагуул хотуудыг байгуулахыг дэмжинэ.
9. Налайх, Багануур дүүргүүдийн дагуул хотын төлөвлөлтийг эхлүүлнэ.
10. Хувийн хэвшлийн оролцоо нийслэлийн эдийн засгийг дэмжих зорилгоор шинэ нисэх буудлын орчимд чөлөөт бүс байгуулна.
11. Багануурт үйлдвэрлэл технологийн, Эмээлтэд Хөнгөн үйлдвэрийн, Налайхад барилгын материалын үйлдвэрийн технологийн парк, Ачаа тээврийн нэгдсэн ложистикийн төв байгуулах ажлын тооцоо судалгааг хийж, хэрэгжүүлэх зохион байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
12. Барилгажилтыг дэмжихгүй байршлуудыг шинэчлэн тодорхойлж, уг байршилд шинээр байшин барилга бариулахгүй байх шийдвэр гаргаж, иргэдэд танилцуулна

**3.2 Дэд бүтэц, инженерчлэлийн чиглэлээр:**

1. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэхдээ төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрчимжүүлж газраа орон сууцаар солих бодлого баримтална.

2. Гэр хорооллын иргэдэд төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны хангамжид холбогдсон амины орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлнэ.
3. Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй усны хэрэглээ, ариутгах татуургын хүртээмжийг тогтвортойгоор шинэчлэн сайжруулж, цэвэр усны шугамыг зэсээр доторлох буюу зэс хоолойгоор солих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
4. Сэргээгдэх эрчим хүч, байгаль орчинд ээлтэй дэд бүтцийн шийдлүүдийг хөнгөлөлттэй санхүүжилтээр дэмжинэ.
5. Нийслэл орчмын усны нөөцийг хамгаалах, нэмэгдүүлэх зорилгоор "Туул" усан цогцолборын бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэнэ.
6. Нийслэлийн тээвэр, ложистикийн төвүүдийг оновчтой төлөвлөж, байгуулна.
7. Замын дагалдах дэд бүтэц болох ус зайлуулах шугам, гэрэлтүүлэг, ногоон байгууламжийг олон улсын стандартаар барина.
8. Нийслэлд буй авто зогсоолын тоог төрөлжүүлж 50 хувиар нэмэгдүүлнэ.
9. Осол аваар гардаг замуудад хяналтын камер, хурд хэмжигч, хурд сааруулагч байршуулна.
10. Хотын гудамжнуудыг иргэд, аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулалт хийж, тохижуулж, өөрсдийн нэрээр нэрлүүлэх боломжтой болгоно.
11. Улаанбаатар хотын гудамж, байшингийн хаягжилтыг олон улсын жишигт нийцүүлж, хялбар чиглүүлэгчтэй болгоно.
12. Гэр хорооллын цахилгаан хүчдэлийн уналттай 5104 өрх, огт цахилгаанд холбогдоогүй 2838 айл өрхийг тогтвортой цахилгаан хангамжтай болгоно.

**3.3 Гэр хорооллыг дахин төлөвлөх, орон сууцны орчныг сайжруулах чиглэлээр:**

1. Орон сууцжуулах олон хувилбарт бодлого хэрэгжүүлнэ
2. Гэр хорооллыг инженерийн дэд бүтэц /цэвэр ус, бохир ус ариутгах татуурга, интернет шилэн кабел/-д холбож, халаалтыг төвлөрсөн болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг дэмжих зорилгоор Сервис Центрүүдийг байгуулж иргэдийн амьдран суух байшингаа барихад нь урт хугацаатай, хүү багатай, орон сууцны ипотекийн зээлээр хангаж ажиллах тооцоо судалгааг хийж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
3. Иргэд өөрийн өмчилж авсан хашааны газар дээр айл, хөрш, гудамжаараа нэгдэн төлөвлөлт хийж, инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон, амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлж, амьдран суух байшингаа барихад нь урт хугацаатай, хүү багатай, орон сууцны ипотекийн зээлээр хангаж ажиллах тооцоо судалгааг хийж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
4. Гэр хорооллын дахин төлөвлөлтөөс чөлөөлөгдсөн газар дээр иргэдийн амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх, эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлэх цэцэрлэгт хүрээлэнгүүдийг байгуулна.
5. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн 24 байршил дахь бүтээн байгуулалтын төслүүдийг үргэлжлүүлж, 80 мянган өрхийг орон сууцанд оруулсан байна
6. Газрын эзэн-хувьцаа эзэмшигч хөтөлбөр хэрэгжүүлж, батлагдсан 8 байршилд бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэн 5550 айлын орон сууц ашиглалтад оруулна
7. 2024 он гэхэд 10 мянган өрхийг инженерийн шугам сүлжээнд шинээр холбосон байна
8. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон орон сууцнуудын дахин төлөвлөлтийн төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ
9. Сууц өмчлөгчдийн холбоодыг дэмжих, бэхжүүлэх, чадамжийг нь дээшлүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
10. Орлогод нь нийцсэн төлбөр бүхий "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлж, 2024 он гэхэд 7000 өрхийг түрээсийн орон сууцанд оруулсан байна. Нэн тэргүүнд залуу гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудыг дэмжих бодлого баримтална.
11. Гэр хорооллын янданг цөөрүүлэх, утаа угаарыг багасгах бодлогыг дэмжин хувийн хэвшил, шинэ дэвшилтэт технологи, инновацийн шинэ санааг дэмжинэ.
12. Цахимаар газар өмчлөх ажлыг эрчимжүүлнэ.

1117145633
МХА0612 0077778



НИЙСЛЭЛИЙН ХОРОО

13. Цахимаар газар олгосон шинэ суурьшлын бүсийн 52 байршилд инженер хангамжийн байгууламжуудыг үе шаттайгаар байгуулна.

### 3.4 Хот доторх хөдөлгөөнийг сайжруулах чиглэлээр:

1. "Бүхний түрүүнд явган зорчигч" зарчмыг хэрэгжүүлж, гэрлэн дохио, явган хүний гарц дээр явган зорчигчийг хүлээдэг соёлыг хэвшүүлнэ.
2. Улаанбаатар хотын зарим гудамжнуудыг явган хүнд зориулагдсан, автомашингүй гудамж болгоно.
3. Хотын иргэд явган алхах боломжийг бүрдүүлэх зорилгоор авто зам бүхий газар бүр явган хүний зам гаргана.
4. Ачаалал ихтэй уулзваруудад явган хүн саадгүй зорчих гүүр барина.
5. Нийслэл дэх явган зорчигчдын гол маршрутуудыг дагасан амрах сүүдрэвч, аюулгүй байдлыг хангасан үйлчилгээг дэмжиж, зохих хөрөнгө оруулалт хийнэ.
6. Гамшгийн үед ашиглах орц гарц замыг чөлөөлж, явган зорчигчийн зам, талбайг орхигдуулсан, хаасан иргэн, хуулийн этгээдэд оногдуулах хариуцлагыг өндөржүүлнэ.
7. Иргэдийн чөлөөтэй зорчих эрхийг хязгаарласан, хотын өнгө үзэмжид сөргөөр нөлөөлсөн хашаа, хаалтуудыг буулгах, чөлөөлөх шийдвэртэй арга хэмжээнүүдийг авна.
8. "Унадаг Дугуйтай Улаанбаатар" хөтөлбөрийг хэрэгжүүлж, дугуйн хэрэглээг бүх талаар дэмжинэ. Хотын төв хэсэгт 22,4 км дугуйн зам барина.
9. Дундаа хэрэглэдэг унадаг дугуй, түрээсийн унадаг дугуйн (Bike sharing) төвүүдийг өргөжүүлж чанар стандартыг нь нэмэгдүүлнэ.
10. Зуслан болон амралт, зугаалгын бүсүүдэд явган явах болон унадаг дугуйн дэд бүтцийг байгуулж, одоо байгаа замыг 4 дахин нэмэгдүүлнэ.
11. Авто машиныг хамтран эзэмших (car pool), авто машин түрээслэх (car sharing) үйлчилгээг нэвтрүүлж, дэмжлэг үзүүлнэ.
12. Таксины үйлчилгээг дэмжиж олон улсын жишигт нийцүүлнэ.
13. Нийтийн тээврийн салбарт бүтцийн өөрчлөлт хийж, тээврийн хэрэгслийг олон сонголттой байгаль орчинд ээлтэй (BRT-Тусгай замын автобус, Метро, Railbus-Төмөр замын хөнген галт тэрэг, их, бага, дунд багтаамжийн автобус, буухиа автобус, сургуулийн автобус,жуулчны автобус зэх мэт) болгож, парк шинэчлэлт эрчимтэй хийнэ.
14. Нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулж, төлөвлөлтийг бүсчлэлд тулгуурлан цагийн хуваарийн дагуу явуулдаг болгоно.
15. Нийт зорчилт эргэлтийн 70-80 хувийг Нийтийн тээврээр гүйцэтгэдэг болно.
16. Тэргэнцэртэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийтийн тээврээр саадгүй зорчих стандартыг тогтоож, хэвшүүлнэ.
17. Богдхаан төмөр замын төслийг сэргээж, Улаанбаатар хотыг хөндлөн дайрсан шугамын ачааллыг эрс бууруулах асуудлыг судалж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

УЗ 905 2 4077278



АРДЧИЛСАН НАМ
НИЙСЛЭЛИЙН ХОРОО

## 4. ЭКО УЛААНБААТАР

### Өнөөгийн нөхцөл байдал

Улаанбаатар хот нэг сая хүрэхгүй модтой, ногоон байгууламж муутайгаас агаар, хөрс, орчны бохирдол, тоосжилт зэрэг олон сөрөг үр дагавар бий болж байгаа ч ногоон байгууламжийг нэмэгдүүлж, мод тарьсан иргэдээ дэмжих эрх зүйн орчин байхгүй байна. Агаарын бохирдол бүрэн шийдэгдээгүй хэвээр бөгөөд хөрсний бохирдол хуримтлагдсаар, гүний усыг хордуулах ноцтой нөхцөл байдал үүсэхэд бэлэн болоод байна.

*Ус, дулааны нөөцийг зохистой, тогтвортой ашиглах, алдагдлыг бууруулах тогтолцоо бүрдээгүй байна. Хог хаягдлын ачилт тээвэрлэлт хүрэлцээгүй, ангилан ялгалт хэвшээгүй, хог боловсруулах үйлдвэргүй, энэ чиглэлийн менежмент бүхэлдээ үгүйлэгдсээр байна.*

**Бидний хийх ажлууд:**
Бид Улаанбаатар хотдоо хүрээлэн буй орчин, байгаль экологитойгоо нягт шүтэлцээтэй, ой мод, ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, ус, агаар, хөрсний бохирдлыг эрс бууруулж, нөөцийг хэмнэлттэй, ухаалаг зарцуулах тогтолцоонд шилжсэн тогтвортой хөгжилтэй хот байгуулна.

**4.1 Хүрээлэн буй орчныг хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр:**

1. “Ногоон бүс” хөтөлбөр (Сэлбэ, Туул, Дунд голыг сэргээх, хамгаалах, арчлах зорилгоор голын эрэг дагасан ногоон бүс, ойжуулалт хийх) хэрэгжүүлж, 2024 он гэхэд хотын 1 хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлж 13.3$м^2$ болгоно.
2. Бүх төрлийн барилга байгууламж, тээврийн хэрэгсэлд байгальд ээлтэй байдлын зэрэглэл олгоно.
3. Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хөрсний чанарыг сайжруулах зорилгоор гэр хорооллын айл бүрд хашаандаа мод тарих, хүлэмжийн аж ахуй эрхлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх тогтолцооны судалгаа тооцоо хийх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
4. Байгалийн болзошгүй гамшгийн тохиолдолд хариу үйлдэх, эргэн сэргэх чадавхийг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
5. Хотын бүсэд харшил үүсгэгч шарилж зэрэг нэр бүхий зэрлэг ургамлыг устгаж, иргэдийн эрүүл таатай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
6. Улаанбаатар хотын бүс дэх зэрлэг ан, амьтдыг хамгаалах "Экологийн коридор" төсөл хэрэгжүүлнэ.
7. Ойг нөхөн сэргээх, таримал ойг худалдан авах ажлыг эрчимжүүлэх, тооцоо судалгааг хийж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
8. Дархан цаазат бүс, Туул голын гольдролд барьсан барилгуудаас хүрээлэн буй орчны татвар авч, ногоон байгууламж байгуулах санд төвлөрүүлнэ.

**4.2 Агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр:**

1. Гэр хорооллын янданг цөөрүүлэх зорилгоор орон сууцжуулах хөтөлбөрийг эрчимжүүлэн хэрэгжүүлж, ипотекийн зээлийн олголтыг гэр хорооллоос орон сууцанд орж буй зорилтот бүлэгт нэмэгдүүлнэ. Нийслэлд агаарын бохирдлыг бууруулах зорилгоор “Өнтэй өвөлжье” төсөл хэрэгжүүлж, гэр хорооллын айлын дулаан алдагдлыг бууруулах, санхүүжилтийн санхүүгийн хөнгөлөлттэй нөхцөлтэй хөтөлбөр хэрэгжүүлнэ.

НИЙСЛЭЛИЙН ХОРОО

2. Улаанбаатар хотын тоосжилтыг багасгах цогц арга хэмжээ хэрэгжүүлж, PM10 тоосонцрын хэмжээг 50% бууруулна.
3. Гэр хорооллыг өвлийн цагт цахилгаанаар халаах чадвартай болгох үүднээс цахилгаан дамжуулах чадамжийг нэмэгдүүлж, эрсдэлгүй аюулгүй дэд бүтцээр хангана.
4. Цахилгаан хөдөлгүүрт автомашиныг дэмжих зорилгоор дугаарын хязгаарлалтаас чөлөөлж, 15-аас дээш жил явсан дизель хөдөлгүүрт автомашинуудыг Улаанбаатар хотод явахыг үе шаттайгаар багасгана.
5. Улаанбаатар хотод цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх 20 цэг байгуулна.
6. Дахин цэвэрлэх боломжгүй хөрсний бохирдлоос сэргийлэх зорилгоор ашиглалтаас гарсан тээврийн хэрэгслийг хотын газар нутагт байршуулахыг хориглож, одоо байгаа хаягдлыг нэг цэгт цуглуулна.
7. Зуслангийн газарт шаардлагатай дэд бүтэц тавьж, өмчлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
8. "Жорлонгоо өөрчилье" төслийг дэмжин хэрэгжүүлж гэр хорооллын 210 мянган айлын жорлонг шинэчилж, хөрсний бохирдлыг эрс бууруулах тооцоо судалгааг гаргаж, хийж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
9. Хөрсний бохирдол гүний цэвэр усанд нэвчихээс сэргийлж, яаралтай саармагжуулах арга хэмжээ авна.
10. Туул голын эх, урсац бүрдэх бүс дэх гэр хорооллын 10,000 айлыг бие даасан бохирын системд холбож, усны бохирдлыг багасгана.
11. Агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд "Эрчим хүч үйлдвэрлэгч иргэн" хөдөлгөөнийг гэр хороололд өрнүүлж, иргэд хашаандаа нар сапхины сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэн хэрэглэхээс гадна илүүдэл эрчим хүчээ төвийн эрчим хүчний сүлжээнд худалдан борлуулахыг дэмжинэ.
12. Улаанбаатар хотод "8 нуур" төсөл хэрэгжүүлж, хотын агаарын тоосжилтыг багасгах, агаарын чийгшилтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

**4.3 Нөөцийг тогтвортой ашиглах, хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр:**

1. Ухаалаг барилгын (smart building) стандартыг хэрэгжүүлнэ.
2. Усыг дахин ашиглах "Саарал ус"-ны технологийг нэвтрүүлнэ.
3. Эрчим хүчний хэмнэлттэй хотын гэрэлтүүлэг, ухаалаг гэрлэн дохионы стандарт нэвтрүүлнэ.
4. Дулаан, усны дамжуулалтын алдагдлыг бууруулах зорилгоор газар доорх дундын хоолой, айл өрх бүрд ус, цахилгааны хэрэглээгээ (өдөр, сарын хэрэглээ, мөнгөн дүн г.м) хянах боломжийг олгох электрон дэлгэцтэй смарт метрийг суурилуулна.
5. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, нэгдсэн стандартад шилжүүлж, хог боловсруулах, буцаан ашиглах үйлдвэр байгуулах судалгаа тооцоог гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
6. Аюултай хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, саармагжуулах, устгах тогтолцоог бий болгоно.
7. Орон сууцны хороолол дунд хог хаягдлыг ангилан байршуулах хэвшлийг нэмэгдүүлнэ. Иргэд дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж тушааснаар зарим үйлчилгээг (нийтийн тээвэр г.м) үнэ төлбөргүй авах хөшүүргийг нэвтрүүлнэ.
8. Хог хаягдлыг дахин боловсруулах, аж ахуйн нэгжүүд өөрсдийн гаргаж буй сав, баглаа, боодлыг татан авч, дахин ашиглах тогтолцоог дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
9. Хөрсний усны эрсдэлийг 90 хувь хүртэл бууруулна. Био цөөрөм, хөв цөөрөм байгуулах зэргээр олон улсын технологийг судлан эрдэмтэдтэй хамтран төсөл хэрэгжүүлнэ.
10. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих, цахилгаан сүлжээн дэх нийлүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлнэ.
11. Эрчим хүчний хэмнэлтийг дэмжих, хэрэглээг зүй зохистой удирдах зорилгоор ухаалаг сүлжээг нэвтрүүлнэ.

НИЙСЛЭЛИЙН ХОРОО

## 5. ЭЭЛТЭЙ УЛААНБААТАР

### Өнөөгийн нөхцөл байдал

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотод гэмт хэргийн түвшин буурахгүй байгаагийн зэрэгцээ зам тээврийн осол, аваар их гарч байна. Нийслэл хот хүүхдэд ээлгүй, явган хүний гарц дээр хүүхдүүд автомашинд дайруулж амь насаа алдах буюу эрүүл мэндээрээ хохирсоор байна. Гэр хорооллолд харанхуй, цагдаагийн эргүүл, хараа хяналт бага байгаа нь гэмт хэрэг гарах үндэс болж байна. Нийслэл хотод хүүхдийн цэцэрлэгийн хүрэлцээ муу, суурь боловсролын байгууллагуудын сургалтын чанар, сурах орчин, түвшин харилцан адилгүй, ялгаа ихтэй байна.

Улаанбаатар хотын эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын ачаалал хэтэрсэн, халдварт өвчин нэмэгдсэн үед дийлдэхгүй болж, эцэг эхчүүд, өвчтэй хүүхдүүдийг коридорт хэвтүүлж эмчилсээр байна.

Түүх, соёлын үнэт өв болсон байшин барилгуудаа арчлах, сэргээн засах биш, нурааж, устгаж, оронд нь ашиг харсан өндөр барилга барьдаг болж байна. Соёл урлаг, спортын өндөр амжилт гаргаж буй авьяаслаг иргэдээ дорвитой дэмжиж чадахгүй байна.
Иргэд амарч тухлах цэцэрлэгт хүрээлэн, сул чөлөөтэй алга дарам газар бүрд барилга барьдаг болж байна.

### Бидний хийх ажлууд:

*Бид Улаанбаатар хотоо иргэд нь сурч хөгжих, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ авах боломж бүрдсэн, спортлог, авьяаслаг иргэдтэй, урлаг, гоёзүйн үнэт капиталыг хуримтлуулсан, өв соёлоо хойч үедээ өвлүүлсэн, иргэндээ ээлтэй хот болгоно.*

### 5.1 Амьдрахад таатай, аюулгүй орчин бий болгох чиглэлээр:

1. Төв цэвэрлэх байгууламжийг бүрэн ашиглалтад оруулж, лаг хаягдал, өмхий үнэрээс бүрэн сална.
2. Хуучны угсармал орон сууцны дулаалгыг эрчимтэй хэрэгжүүлж бүрэн дуусгана.
3. Орон сууцны дундах бетон болон төмөр гражтай иргэдийг ипотекийн зээлд хамруулах судалгаа тооцоог хийж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
4. Улаанбаатар хотын барилгажсан дүүрэг, гудамжнуудад нэмж орон сууцжуулахгүйгээр амралт, биеийн тамирын талбай байгуулан тохижуулна.
5. Гэр хорооллын айл өрхийн түлшний хэрэглээг аюулгүй болгоно.
6. Агаар дахь хорт хийн хэмжээг эрүүл ахуйн шаардлага стандартын хэмжээнд хүртэл багасгаж, халаалтын шинэ технологийг дэмжин агаарын бохирдолгүй болгоно.
7. Амьдрахад таатай хотын олон улсын үнэлгээний жагсаалтад Улаанбаатар хотын эзлэх байрыг дор хаяж 20 байраар урагшлуулна.
8. Онцгой байдал, гамшгийн менежментийн тогтолцоог боловсронгуй болгон хөгжүүлж, шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана.
9. Нийслэлд "Гудамж төсөл"-ийг үргэлжлүүлэн, авто замын уулзварыг шинээр барьж түгжрэлийг бууруулна.
10. Хүүхдэд ээлтэй хот болох цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ.
11. Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцнуудыг буулгаж, шинээр барих дахин төлөвлөлтийн төслүүдийг хэрэгжүүлнэ.
12. Хотын төвийн газар эзэмшиж буй аж ахуйн нэгж, иргэдэд хотын стандартын дагуу тохижилт хийх, ногоон байгууламж байгуулах, иргэдийн зорчих боломжийг хангах шаардлага тавьж, хэрэгжүүлнэ.
13. Ногоон байгууламж, амралт зугаалгын бүс, парк байгуулах гэх мэт эко бизнес эрхлэгчдэд татвар, хураамж, төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх талаар тооцоо судалгаа гаргаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

НИЙСЛЭЛИЙН ХОРОО

14. Зуслангийн шинэ суурьшлын байршлуудыг шинэчлэн тогтоож, авто зам, цахилгааны эх үүсвэрээр хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
15. "Хашаандаа сайхан амьдаръя" төсөл хэрэгжүүлж, орчноо тохижуулж мод зүлэг тарьж суулгасан иргэдэд урамшуулал олгох тооцоо, судалгаа гаргаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
16. Улаанбаатар хотын гэр хорооллын болон хотын гудамжнуудыг бүрэн камержуулах, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх замаар гэмт хэргийн гаралтыг бууруулж, хяналтыг сайжруулна.
17. Цагдаагийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, "Миний Цагдаа намайг хамгаална" гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
18. Улаанбаатар хотын дотор тээвэрлэлт хийж байгаа аюултай ачааны тээвэрлэлтийг тусгай цагийн хуваарь, маршрутаар зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлүүлнэ.
19. Өдөр тутмын амьдралд учирч болох эрсдэлтэй объект, барилга байгууламж болон бусад асуудлыг холбогдох байгууллагаар зэрэглэлийг тогтоолгох, мэдээлэх платформ ажиллуулна.
20. Төвөөс алслагдсан бүсийн иргэдэд гамшгаас хамгаалах системийг бий болгож, 50 мянган хүнд ногдох аврах, гал унтраах ангийн барилгыг 40 хувиар нэмэгдүүлнэ.
21. Болзошгүй гамшгийн үед иргэд түр цугларах талбайг 79 байршилд байгуулж, 20 мянган хүнд ногдох цугларах талбайн тоог 60 хувиар нэмэгдүүлнэ.
22. Болзошгүй гамшгийн үед иргэдэд хоргодох байрыг 43 байршилд байгуулна.
23. Нийслэлийн хүнсний аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр стандартуудыг чангатгаж, хүнсэн дэх хорт бодисыг хэмждэг лаборатори байгуулна.
24. Нийслэлийн хүнсний аюулгүй байдлыг хангах үүднээс Улаанбаатар хот орчмын газарт органик хөдөө аж ахуй эрхлэгчдэд сертификат олгож, хоол хүнсний нийлүүлэлтийн сүлжээг боловсронгүй болгоно.
25. Зам тээврийн ослыг бууруулах зорилгоор нийтийн тээврийн жолоочид тавигдах шаардлагыг олон улсын жишигт нийцүүлнэ.
26. Улаанбаатар хотын соёлт иргэнийг төлөвшүүлэх чиглэлээр " Хотын соёлт иргэн" сургалт, нөлөөллийн ажлыг Улаанбаатар хотод шинээр нүүн ирж бүртгэгдэж буй иргэд болон бүх шатны боловсролын байгууллагыг хамруулан тогтмол зохион байгуулж хэвшүүлнэ.
27. Хөршийн холбоо, олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааг идэвхжүүлэн дэмжиж , орчны аюулгүй байдлыг сайжруулна.

**5.2 Эрүүл мэнд, боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр:**

1. Нийслэлийн иргэд харьяалал харгалзахгүйгээр бусад дүүргийн эмнэлгээс эрүүл мэндийн үйлчилгээг авдаг болгоно.
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд идэвхтэй оролцох дэд бүтцийг бий болгоход онцгойлон анхаарна.
3. Эрүүл мэндийн байгууллагын хүртээмжийг стандартын шаардлагад нийцүүлэн сайжруулж, эмнэлгийн орны тоог 2024 он гэхэд 11 мянгад хүргэсэн байна
4. Улаанбаатар хотын дүүрэг бүрд бага насны хүүхэд 500 метрийн радиус дотор цэцэрлэг, сургуульдаа хүрэх боломжтойгоор хотын ерөнхий төлөвлөгөөнд тусгасны дагуу цэцэрлэг сургуулийг нэмж барин хүртээмжийг жигд болгоно.
5. Эмч, багш нарын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулдаг индексийн урамшууллыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
6. Төрийн бус өмчийн сургууль болон алслагдсан сургуулиудад автобус ажиллуулж, хүүхдийн сургуульдаа аюулгүй ирж, очих нөхцөлийг бүрдүүлнэ.
7. Ерөнхий Боловсролын Сургуулиудыг Цогцолбор сургуулийн бүтцээр ажиллуулж менежментийг нь сайжруулахыг дэмжинэ.
8. Нийслэлийн бүх хороод цэцэрлэг, сургуультай болно.
9. Сургууль бүрийг 2-оос дээшгүй ээлжээр хичээллэдэг болгоно.

НИЙСЛЭЛИЙН ХОРОО

10. ЕБС-ын үндсэн хичээлээс гадна сурагчдын оюун ухаан, бүтээлч чадварыг хөгжүүлэх, мэдээллийн технологийн орчин үеийн мэдлэг олгох зорилгоор хиймэл оюун ухааны, кодчилол, роботчлолын лаборатори, эд юмсын интернет гэх мэт хичээл сургалтыг нэмэлтээр ордог болгоно.
11. Хороо бүрд урьдчилсан сэргийлэх эмч ажиллуулж, иргэдийн эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, эрүүл мэнд, биеийн тамирын өрөө, талбайг тохижуулж, спортоор хичээллэх боломжийг бий болгоно.
12. Хороо бүрд тоноглогдсон биеийн тамирын талбай бий болгох, шинээр баригдах цэцэрлэгт хүрээлэнгүүдэд дугуй, гүйлтийн замуудыг байгуулна.
13. Жирэмсэн эхчүүд, ахмад настны халамж, эмнэлгийн үйлчилгээг сайжруулах хөтөлбөр боловсруулна.
14. Сургуулийн эргүүл төслийг үргэлжлүүлэн дэмжиж, сурагч хүүхдүүд сургуульдаа ирэх гэр лүүгээ буцах замдаа халдлагад өртөхгүй аюулгүй байх үүднээс ухаалаг мэдээлэгчтэй сурагчийн үнэмлэхийг нэвтрүүлж, сургуулийн ойр орчим, автобусны буудал, сургуулийн автобусанд долгион дамжуулагч суурилуулна. Ингэснээр сурагчдын байршил, аюулд өртөж буй эсэх мэдээлэл нь аав ээжийнх нь гар утсанд ирдэг болно.
15. Нийслэлийн гэр хорооллод олон нийтийн номын сангуудыг байгуулна.
16. Хүүхэд залуусын инженерийн сэтгэлгээг хөгжүүлэх залуу зохион бүтээгчдийн төв, сансар судлалын танин мэдэхүйн төв байгуулах судалгаа тооцоог, гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

**5.3 Иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газар, соёл, урлагийн байгууламжуудыг хамгаалах чиглэлээр:**

1. Хотын соёлын өв, дурсгалт барилгуудыг нураахгүйгээр арчлах, хамгаалах, сэргээн засварлах ажлыг шат дараатай хийнэ.
2. Соёлын өвийг хамгаалах төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж, хотын аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлнэ.
3. Дүүрэг бүрд иргэдийн амрах, зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх цэцэрлэгт хүрээлэн, авто машины зогсоол, саравч, хүүхдийн тоглоомын талбай, боловсон бие засах газар бүхий цэгүүд байгуулна.
4. Орчин үеийн Соёл урлагийн ордон байгуулна.
5. Дүүрэг бүрд театр, кинотеатр, номын сан, спорт заал бүхий цогцолбор байгуулна.
6. Спортын байгууламж, заал талбайг спортын төрөл төрлөөр олшруулж, менежментийг нь спортын холбоод, клубүүдэд хариуцуулан хамтарч ажиллах, клубүүдыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
7. Газрын нэгдсэн үзлэг зохион байгуулж, ашиглалт, эзэмшлийн зөрчилтэй газруудыг эргүүлэн авч, нийтийн зориулалттай ногоон байгууламж болгоно.
8. Зуслангийн газрыг өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.
9. Заан-Тэрэлжийг аялал жуулчлал, амралт, зугаалгын бүс болгон тохижуулна.
10. Нийслэлийн нутаг дэвсгэрт Монгол морины соёлыг дэлгэрүүлж, морь сургах, морин тойруулга, морин аяллын цогцолбор байгуулахыг бодлогоор дэмжинэ.

1171456[illegible]
ҮХ[illegible]0013 9077278



АРДЧИЛСАН НАМ
НИЙСЛЭЛИЙН ХОРОО